



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ**



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН ЯАМ**



**ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ**

# **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦАГААН НОМ**

# **2019**

**УЛААНБААТАР ХОТ  
2020 ОН**

## **БЭЛТГЭН ГАРГАСАН:**

<b>Г.ГАНТУЛГА</b>	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга
<b>А.ЭНХБОЛД</b>	Зам тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
<b>Д.ӨНӨРЦЭЦЭГ</b>	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн
<b>Л.БАЯНЗУЛ</b>	Зам тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
<b>Х.САРАНЦЭЦЭГ</b>	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Авто тээврийн хяналтын улсын ахлах байцаагч
<b>Ц.ЭРДЭНЭЧИМЭГ</b>	Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны захиргааны удирдлагын газрын Мэдээлэл судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа
<b>Н.ЗОРИГТ</b>	Авто тээврийн үндэсний төв, Төрийн өмчит үйлдвэрийн газрын Судалгаа хөгжил, чанарын удирдлагын төвийн дарга
<b>Б.ТҮМЭН-ӨЛЗИЙ</b>	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Статистик мэдээлэл, тандалт судалгааны албан дарга
<b>С.ХИШИГЗАЯА</b>	Албан журмын даатгагчдын холбооны даатгалын сангийн дарга

## **ХЯНАСАН:**

<b>С.БАТБОЛД</b>	Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
<b>Э.МӨНХНАСАН</b>	Зам тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
<b>Ц.АРИУНБАТ</b>	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



## ГАРЧИГ

ОРШИЛ	5
1. МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	6
2. МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН ТОО, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	11
3. МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ОСОЛ, ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ	14
- 3.1 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14
- 3.2 Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан, гэмтсэн хүн, учирсан хохирол	16
- 3.3 Амь насаа алдсан хүн	16
- 3.4 Гэмтсэн хүн	18
- 3.5 Гэмтсэн хүний гэмтлийн зэрэг	20
- 3.6 Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас нас барсан, гэмтсэн хүүхдийн тоон үзүүлэлт	22
- 3.7 Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн нас, хүйс	23
- 3.8 Осолд өртсөн хүүхдийн замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэр	24
- 3.9 Гэмт хэрэгт холбогдогчийн нас хүйс	26
- 3.10 Зам тээврийн ослын шалтгаан	27
- 3.11 Жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол	28
- 3.12 Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол	29
- 3.13 Замын нөхцөл, техникийн гэмтлээс шалтгаалсан зам тээврийн осол	30
- 3.14 Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэр	32
- 3.15. Зам тээврийн осол гарсан улирал, сар, гариг, цаг, зам орчин, цаг агаар	34
- 3.16 Улсын хэмжээнд бүртгэгдсэн осолд холбогдсон тээврийн хэрэгслийн төрөл	35
- 3.17 Мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол, нас баралт	35
- 3.18 Зам тээврийн осолд холбогдсон хүмүүсийн жолооч болсон жилээр гаргасан судалгаа	37
- 3.19 Зам тээврийн осолд холбогдсон автомашины жолооны хүрдний байрлал, насжилт, марк	39
- 3.20 Монгол улсын жолоочийн тоон үзүүлэлт	40
- 3.21 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг үйлдэгдсэн, осол, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудал	41
4. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТААР БҮРТГЭГДЭЖ БУЙ “ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ”-ЫН БАЙДАЛ	44
- 4.1 2019 онд осол гэмтлийн тандалтаар бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн байдал	46
- 4.2 2019 онд осол гэмтлийн тандалтаар бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын байдал	56

- 4.3 Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, нас баралтын шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудал	61
5. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨРИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХТОГТОЛЦОО	63
- 5.1 Авто замын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих өвчлөлийн байдал	64
6. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ	66
- 6.1 2019 онд байгуулсан нийт гэрээний тоо, болон цуцлалт	66
- 6.2 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр	67
7. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ	68
- 7.1 Дэлхийн зорилт-2030	68
- 7.2 Монгол Улсын Засгийн газрын 128 дугаар тогтоол	70
- 7.3 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн	71
- 7.4 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм	72
- 7.5 Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 01 дүгээр тогтоол	75
- 7.6 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2019-2023/	77
- 7.7 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам	90
- 7.8 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хуралдаанаас гаргасан зөвлөмж	94
8. ЭМНЭЛЭГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ	100
- 8.1 Эрүүл мэндийн сайдын А/293 дугаар тушаал	100
- 8.2 Эмнэлэгийн яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журам	101
- 8.3 Эмнэлэгийн яаралтай тусламжид үйлчлүүлэгчийг эрэмбэлэх заавар	108
- 8.4 Эрүүл мэндийн сайн А/294 дүгээр тушаал	113
- 8.5 Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журам	114
- 8.6 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, олныг хамарсан осол гэмтлийн үеийн эрэмбэллийн заавар	126

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зөрчил, гэмт хэргийн эмхтгэлийг 2013 оноос эхлэн Тээврийн цагдаагийн байгууллагаас эрхлэн өнөөгийн байдлаар 6 дахь жилдээ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Цагаан номыг 2 дах жилдээ хэвлүүлэн ашиглаж байна.

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан, тэдгээрийн чиг хандлагыг нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай харьцуулан шинжлэх ухааны үндэстэй судалж, зам тээврийн ослоос сэргийлэх арга замыг тодорхойлон хууль тогтоох, боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагын бодлого, үйл ажиллагаанд санал зөвлөмж болгох зайлшгүй шаардлага гарч байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан номд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, гэмт хэрэг, статистикийн мэдээлэл болон зам тээврийн осолд нөлөөлдөг нийгэм, хүн ам зүй, иргэдийн мэдлэг, хандлага, эдийн засгийн хүчин зүйлийг илэрхийлдэг мэдээллүүдийг багтаан замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэстэйгээр судлах, бодлого тодорхойлоход албан ёсны эх сурвалж болгон ашиглах зорилготой юм.

Түүнчлэн замын хөдөлгөөнд түгээмэл үйлдэгддэг, нийгэмд анхаарал татаж буй тодорхой төрлийн ослоос үйдэлтэй, гэмтлийг тухайлан судалж, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх

арга замыг тодорхойлох, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, боловсронгуй болгож, шинэчлэх ажлыг зөв тодорхойлох ач холбогдолтой болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж, Монгол улсын засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, түүний ажлын албыг байгуулж, 163 дугаар тогтоолоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг тус тус баталж, Үндэсний зөвлөлийн анхны хурлаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, зөвлөмж, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмыг хэрэгжүүлэхээр баталсан.

Энэхүү номонд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, түүний ажлын албаны үйл ажиллагааны чиглэлээр батлагдан гарсан эрх зүйн актуудыг мэдээлэл болгон оруулав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь зам тээврийн салбарын үүрэг чиглэлээс гадна хөдөлгөөнд оролцогчид, хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт, ослын дараах тусламж үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа хамаарах бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг хангах үүднээс цагдаа, мэргэжлийн хяналт, эрүүл мэндийн болон даатгалын байгууллагын төлөөллүүдтэй хамтран “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном”-ыг боловсрууллаа.

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ

Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр нутагтай, дэлхийд газар нутгийнхаа хэмжээгээр 19-рт жагсдаг. Монгол Улсад авто замын дэд бүтэц нийт нутгийг хамран төдийлэн сайн хөгжөөгүй тул замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Монгол Улсын авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 111916,7 км авто замаас бүрддэг.

Нийт авто замын сүлжээнээс 4 282.3 км авто зам нь олон улсын, 14 918.7 км нь улсын чанартай авто замд хамаарагдах бөгөөд үүний 7 227.5 км нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 872.7 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32, АН-35/, Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4a, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1a, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 3 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан.

Монгол Улс авто замын сүлжээгээ өргөтгөн хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, тэргүүн ээлжинд олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх зорилт тавин, энэ хүрээнд Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 чиглэлийн авто замын сүлжээнд

хамаарах Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам буюу Ярант-Ховд-Өлгий-Улаан байшинт чиглэлийн авто замыг хөгжүүлэх, бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтыг авч хэрэгжүүлсний үр дүнд 2019 оны байдлаар нийт 17 аймаг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон бөгөөд үлдэж буй дөрвөн аймгийг 2020 онд бүрэн холбох зорилт тавьсан.

Сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хатуу хучилттай авто замын сүлжээний урт нэмэгдэж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл бүрдэж байна. Гэвч баригдсан авто замын сүлжээний ашиглалтын хугацаа, норм нормативын дагуу зайлшгүй хийгдэх арчлалт, засварын ажил шаардлагын хэмжээнд хийгдэж чадахгүй байгаагаас авто замд ихээхэн эвдрэл гарч аюулгүй зорчих нөхцлийг хангаж чадахгүйд хүрч байна. /нийт авто замын хучилтын байдал.







**Монгол Улсын хэмжээнд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар бүрэн холбоход 163.7 км зай үлдсэн.**

**Монгол Улсын хэмжээнд нийт хатуу хучилттай авто замаар холбогдсон 95 сум, суурин газар байна.**

Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон болон  
холбогдоогүй аймгийн төвүүд

д/д	Хатуу хучилттай авто замаар холбогдсон аймгууд		Хатуу хучилттай авто замаар холбогдоогүй аймгууд		
	Аймгийн төвийн нэр	Авто замын урт	Аймгийн төвийн нэр	Авто замын урт	Шороон замын урт
1	Цэцэрлэг	478.2	Өлгий	1581.7	96.7
2	Баянхонгор	622.1	Алтай	909.5	96.7
3	Булган	435.2	Улиастай	931	67
4	Сайншанд	445.9	Ховд	1357.8	96.7
5	Чойбалсан	636.3	Монгол Улсын хэмжээнд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар бүрэн холбоход 163.7 км зай үлдсэн		
6	Мандалговь	271.5			
7	Арвайхээр	412.6			
8	Даланзадгад	576.6			
9	Баруун-Урт	484.1			
10	Сүхбаатар	321.2			
11	Мөрөн	778.8	Монгол Улсын хэмжээнд нийт хатуу хучилттай авто замаар холбогдсон 95 сум, суурин газар байна.		
12	Өндөрхаан	306.1			
13	Зуунмод	43			
14	Дархан	224			
15	Баян-Өндөр	381.5			
16	Чойр	22465			
17	Улаангом	141.7			

Улсын чанартай авто  
замын хучилтын байдал



Улсын хэмжээнд ашиглаж байгаа  
гүүрийн хэмжээ



**Төмөр бетон гүүр**  
13928.8 метр



**Ган гүүр**  
284.0 метр



**Модон гүүр**  
1121.0 метр




**Нийт**  
35962.0 метр



Авто замын насжилт

Насжилт /жил/	Хучилт					
	Асфальт		Цемент		Хайрга	
	урт/км	%	урт/км	%	урт/км	%
1-6	2600.86	35.9				
6-13	3107.45	43			73.9	8
13-аас дээш	1519.9	21.1	36.5	100	849,7	92

Одоо ашиглагдаж байгаа улсын чанартай хатуу хучилттай авто зам



Авто замын салбарт 2016–2019 онд нийт **1773.33** км хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд эдгээр төслүүд хэрэгжиж дууссанаар нийт **17** аймгийн төв, **95** сум, **5** хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдож Улсын чанартай авто замын сүлжээний нийт **7227.5** км буюу **48.4%** нь хатуу хучилттай авто замаар ашиглагдаж байна.

Улсын чанартай автозамын ашиглалтын байдлын үнэлгээ

Хучилтын байдал	Сайн		Дунд		Муу	
	урт/км	%	урт/км	%	урт/км	%
Цемент бетон зам			36.5	100		
Асфальт бетон зам	2844.5	43.3	3170.01	48.2	559.6	8.5
Хөнгөвчилсөн хучилт			137	66.8	68.2	33.2
Хайрган зам			653	70.7	270.56	29.3
Сайжруулсан зам			141.9	53.1	125.3	46.9



Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагатай засвар арчлалтыг хийж гүйцэтгэх хөрөнгө оруулалт норм, нормативын хэмжээнд хийгдэж чадахгүй байна.

Тухайлбал олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын түвшинг бууруулахгүйгээр байнгын бэлэн байдлыг хангахад нормативын дагуу жилд урсгал засвар, арчлалтад 55.0-60.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай боловч жил бүр улсын төсвийн хөрөнгөөс нийт шаардагдах хөрөнгийн дөнгөж 30-35 хувь /сүүлийн жилүүдэд дунджаар 20 орчим тэрбум төгрөг хуваарилдаг/-ийг шийдвэрлэж байна. Энэ нь жил ирэх тутам засвар, арчлалт бүрэн хийгдэхгүй байгаагаас замын ашиглалтын бэлэн байдлыг хангахад буурч байна.

Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд /UNESCAP, CAREC зэрэг/ нь бүс нутгаараа хамтран эдийн засаг, нийгмээ хөгжүүлэх зорилгод бүс нутгийг дамнасан авто замын коридоруудыг хөгжүүлэх зорилт тавьсан бөгөөд коридорын дагууд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратеги, бодлого, төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагуудаас авто замын коридоруудад хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах стратегид дэвшүүлж байгаа зорилтуудаас тэргүүн ээлжинд ач холбодол өгч буй зорилтын нэг бол “аюулгүй авто зам” юм.

“Аюулгүй авто зам” зорилтын хүрээнд авто замын инженерчлэлийн стандартыг сайжруулах, бүх авто зам хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог нэвтрүүлэх, хар цэгийг тодорхойлж засварлах, авто замын ажлын байран дахь аюулгүй байдлыг сайжруулах зэрэг асуудлыг хөндөн олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бий болгох асуудлыг хамтын ажиллагааны гишүүн орнууд идэвхтэй хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд дэвшлүүлсэн “аюулгүй авто зам” зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах шаардлагатай. Тус зорилтыг төрийн захиргааны болон харьяа байгууллагын үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангаас харахад 2019 онд Монгол Улс нь авто замын дэд бүтцийн чанараараа дэлхийн 140 улсаас 119 дугаарт, Азийн орнуудаас авто замын дэд бүтцийн чанараараа хамгийн мууд тооцогдож байна.




# ХОЁР: МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО

Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 10 жил тогтвортой өсөж байгаад сүүлийн 5 жилд онцгой хурдацтайгаар өссөн болохыг 2 дугаар графикаас харж болно.

### Монгол Улсад бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо




2019 оны тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллээс харахад Монгол Улсад нийт 1.049.474 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 568.866 нь Улаанбаатар хотод байна. Нийт тээврийн хэрэгслийн 64 хувь буюу 667.375 нь суудлын автомашин, ачааны автомашин 203.675, автобус 19.535, тусгай зориулалтын автомашин 13.582, зүтгүүр 23.850, механизм 13.595, чиргүүл 47.972, мотоцикл 46.951 тус тус бүртгэгдсэн байна.

Монгол Улсад нийт тээврийн хэрэгслийн 89,5% буюу 934.510 автомашин байгаа ба үүнээс зүүн гар талдаа жолооны хүрдтэй буюу замын баруун талаар явахад зориулагдсан 413.690 (44.3%) баруун гар талдаа жолооны хүрдтэй буюу замын зүүн гар талаар явахад зориулагдсан 520.452 (55.7%) тээврийн хэрэгсэл тус тус бүртгэгдсэн байна.

Улаанбаатар хотын хэмжээнд баруун гар талдаа жолооны хүрдтэй 340,753 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн ба энэ нь нийт Улаанбаатарт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 59,9% эзэлж байна.


Бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн 33300 буюу 3% нь 0-3 жил, 32424 буюу 3% нь 4-6 зургаан жил, 175722 буюу 17 % нь 7-9 жил, 801594 буюу 77 % нь 10 болон түүнээс олон жил тус тус ашиглагдаж байна. 2018 онд бүртгэлтэй байгаа 10 болон түүнээс олон жил ашиглагдсан тээврийн хэрэгслийн тоо өмнөх оныхоос 1%-иар өссөн мэдээ байна. Харин 0-3 жил ашиглагдсан тээврийн хэрэгслийн тоо 2012 оноос хойш тасралтгүй буурсаар 2019 онд ялимгүй буурсан үзүүлэлттэй байна.

### Авто тээврийн хэрэгслийн насжилт




Монгол улс сүүлийн 4 жилд нийт 317881 тээврийн хэрэгсэл импортолсон бол 64755 тээврийн хэрэгсэл ашиглалтаас хасагдсан байна.

### Сүүлийн 4 жилд импортоор орж ирсэн болон ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн тоо




- Импортоор орж ирсэн тээврийн хэрэгсэл
- Хасагдсан тээврийн хэрэгсэл

Сүүлийн 4 жилд ашиглалтаас хасагдсан  
тээврийн хэрэгслийн тоо



Сүүлийн 4 жилд импортлолсон  
тээврийн хэрэгслийн тоо



2019 онд Монгол улсад 4196 нь бүрэн бус, эвдрэл, гэмтэлтэй тээврийн хэрэгсэл импортлогдсон байна. Энэ нь 2019 онд импортлогдсон нийт автомашины 4% -ийг эзэлж байна. Эдгээр тээврийн хэрэгслийн 20.1% нь хөдөлгөөний идэвхтэй аюулгүй байдалд нөлөөлөх эд ангийн эвдрэл, гэмтэл, 67.07% нь хөдөлгөөний идэвхгүй аюулгүй байдалд нөлөөлөх эд ангийн эвдрэл, гэмтэл, 12.7% нь бусад төрлийн буюу үерийн усанд орсон, асдаггүй, мөргөлдсөн, мөндөрт цохиулсан гэх мэт эвдрэл гэмтэлтэй байна.

2019 онд импортоор эвдрэл, гэмтэлтэй орж ирсэн  
4196 тээврийн хэрэгсэл эвдрэл, гэмтлийн ангиллаар



## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ОСОЛ, ХЭРГИЙН МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын хэмжээнд 2019 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт 31524 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1276 бүртгэгдэж нийт гэмт хэргийн 4,0 хувийг эзэлсэн нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 6% өсчээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг



### 3.1 ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Д/д	Он	Бүртгэгдсэн бүх зам тээврийн осол		Үүнээс	
				Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	
		Улс	Нийслэл	Улс	Нийслэл
1	2018	29474	25666	1231	517
2	2019	35302	21874	1276	595

Хөдөлгөөний аюулгүй  
байдал, тээврийн хэрэгслийн  
ашиглалтын журмын  
эсрэг гэмт хэрэг

**2019 онд 1276**

бүртгэгдсэнийг өнгөрсөн оны  
үзүүлэлттэй харьцуулахад



Улсын хэмжээнд  
3,7% өсч



Нийслэлд  
15,1% өсч



Орон нутагт  
4,6% буурсан

Улсын хэмжээнд бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн

**681 БУЮУ 53,4% НЬ ОРОН НУТАГТ, 595 БУЮУ 46,6% НЬ НИЙСЛЭЛД БҮРТГЭГДСЭН БАЙНА.**

Д/д	Аймаг, дүүрэг	Гарсан гэмт хэрэг			Нас барсан хүн			Гэмтсэн хүн		
		2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/ Өсөлт, бууралт /хувиар/	2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/ Өсөлт, бууралт хувиар	2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/ Өсөлт, бууралт /хувиар/			
1	Архангай	42	6 16.7	17	4 30.8	29	-1 -3.3			
2	Баян-өлгий	22	4 22.2	6	-2 -25.0	18	3 20.0			
3	Баянхонгор	24	13 2.1д	12	9 4д	15	8 2.1д			
4	Булган	24	-6 -20.0	14	7 2д	12	-10 -45.5			
5	Говь-алтай	13	-1 -7.1		-7	13	5 62.5			
6	Говьсүмбэр	12	1 9.1	2	0 0.0	14	3 27.3			
7	Дархан-уул	30	-24 -44.4	7	-3 -30.0	20	-27 -57.4			
8	Дорноговь	44	2 4.8	13	-6 -31.6	40	20 2д			
9	Дорнод	42	-10 -19.2	18	1 5.9	23	-9 -2.8			
10	Дундговь	14	-2 -12.5	2	-6 -75.0	12	1 9.1			
11	Завхан	8	-6 -42.9	6	-2 -25.0	3	-10 -76.9			
12	Орхон	27	-1 -3.6	6	5 6д	21	-9 -30.0			
13	Өвөрхангай	27	-23 -46.0	9	-8 -47.1	23	-13 -36.1			
14	Өмнөговь	62	13 26.5	20	6 42.9	54	14 35.0			
15	Сүхбаатар	34	6 21.4	10	0 0.0	22	3 15.8			
16	Сэлэнгэ	39	-29 -42.6	16	-3 -15.8	39	-19 -32.8			
17	Төв	117	32 37.6	34	-1 -2.9	79	33 71.7			
18	Увс	8	-8 -50.0	6	5 6д	4	-12 -75.0			
19	Ховд	28	-7 -20.0	10	-3 -23.1	21	-4 -16.0			
20	Хөвсгөл	38	16 72.7	17	9 2.1д	23	5 27.8			
21	Хэнтий	26	-9 -25.7	9	-5 -35.7	26	-4 -13.3			
22	Төмөр зам	6	1 20.0		-2	5	5			
23	Баянгол	78	1 1.3	3	0 0.0	79	4 5.3			
24	Баянзүрх	130	22 20.4	21	6 40.0	118	22 22.9			
25	Сүхбаатар	79	15 23.4	9	1 12.5	72	5 7.5			
26	Сонгинохайрхан	145	44 43.6	28	-1 -3.4	143	59 70.2			
27	Хан-уул	83	4 5.1	12	-3 -20.0	77	7 10.0			
28	Чингэлтэй	50	-1 -2.0	5	-4 -44.4	46	3 7.0			
29	Багануур	9	-1 -10.0	3	2 3д	6	-4 -40.0			
30	Багахангай	1	-4 -80.0		-1	4	2 2д			
31	Налайх	20	-2 -9.1	4	-6 -60.0	16	-1 -5.9			

### 3.2 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН, ГЭМТСЭН ХҮН, УЧИРСАН ХОХИРОЛ

Зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирохоос гадна эд материалын хохирол учирдаг ба хохиролгүй зам тээврийн осол байдаггүй. Зам тээврийн ослын улмаас 2019 онд нийт 4351 хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ.

Он	Зам тээврийн осол		Зам тээврийн ослын улмаас					
			Хэрэгт өртсөн хүн		Амь насаа алдсан хүн		Гэмтсэн хүн	
	Улс	Хот	Улс	Хот	Улс	Хот	Улс	Хот
2019	25302	21874	4351	2836	561	131	3790	2705

Он	Гэмт хэрэг		Гэмт хэргийн улмаас					
			Хэрэгт өртсөн хүн		Амь насаа алдсан хүн		Гэмтсэн хүн	
	Улс	Хот	Улс	Хот	Улс	Хот	Улс	Хот
2019	1276	595	1391	646	319	85	1072	561

### 3.3 АМЬ НАСАА АЛДСАН ХҮН

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД **31524** ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС

**930** ХҮН НАС БАРСАН /амь насаа алдсан/ НЬ ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭС **0,4%**-Р БУУРСАН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ.



НИЙТ НАС БАРСАН ХҮН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС **34.2** ХУВЬ НЬ АМЬ НАСАА АЛДЖЭЭ.



**Амь насаа алдсан хүний тоон үзүүлэлтийг:**

- Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн
- Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн гэж ангилан авч үздэг.

**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН ХҮН** – зам тээврийн ослын улмаас газар дээрээ болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нас барсан хүн буюу бодит нас баралтын тоон үзүүлэлтийг авч үзсэн.

**ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН ХҮН** – Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас боловсруулан гаргасан үзүүлэлт буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтаар хэрэгсэхгүй болгосон хэрэг болон хохиролыг хасч тооцсон тоон үзүүлэлтийг авч үзсэн.

Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон гэмт хэргийн 509 тохиолдол бүртгэгдэж, 561 хүний амь нас хохирсон байна. Хүний амь нас хохирсон гэмт хэргийг ЭХХШТХ-ийн холбогдох зүйл заалтаар хэргийг хэрэгсэхгүй болгосоноор статистик мэдээнд нас барсан хүн 319 гэсэн үзүүлэлт тусгагдсан.



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 319 хүн амь насаа алдаж, 1072 хүн гэмтсэн үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад амь насаа алдсан хүний тоо 1,8% буурч, гэмтсэн хүн 7,4% өссөн. Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүний 234 буюу 73.4% нь орон нутагт, 85 буюу 26.6% нь нийслэлд байна.

Д/д	Төв, орон нутаг	Хүний амь нас хохирсон осол			Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн			Гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүн		
		2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/	2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/	2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/
1	Архангай	22	8	57.1	23	6	35.3	17	4	30.8
2	Баян-өлгий	13	3	30.0	13	2	18.2	6	-2	-25.0
3	Баянхонгор	29	16	2.3д	31	17	2.4д	12	9	4д
4	Булган	21	7	50.0	21	5	31.3	14	7	2д
5	Говь-алтай	5	-6	-54.5	6	-7	-53.8		-7	
6	Говьсүмбэр	3	0	0.0	5	2	66.7	2	0	0.0
7	Дархан-уул	9	-4	-30.8	9	-5	-35.7	7	-3	-30.0
8	Дорноговь	28	0	-8.7	34	-6	-15.0	13	-6	-31.6
9	Дорнод	21	-2	-18.2	22	-2	-8.3	18	1	5.9
10	Дундговь	18	-4	-11.1	18	-4	-18.2	2	-6	-75.0
11	Завхан	8	-1	-2д	10	-1	-9.1	6	-2	-25.0
12	Орхон	8	4	-20.8	9	5	2.2д	6	5	6д
13	Өвөрхангай	19	-5	-15.2	19	-8	-29.6	9	-8	-47.1
14	Өмнөговь	28	-5	64.3	30	-4	-11.8	20	6	42.9
15	Сүхбаатар	23	9	0.0	23	6	35.3	10	0	0.0
16	Сэлэнгэ	18	0	-3.6	22	2	10.0	16	-3	-15.8
17	Төв	53	-2	12.5	63	1	1.6	34	-1	-2.9
18	Увс	9	1	0.0	10	1	11.1	6	5	6д
19	Ховд	14	0	14.3	14	-2	-12.5	10	-3	-23.1
20	Хөвсгөл	24	3	-15.0	26	2	8.3	17	9	2.2д
21	Хэнтий	17	-3		22	-2	-8.3	9	-5	-35.7
22	Төмөр зам		-7	-22.2		-7			-2	
23	Баянгол	7	-2	45.0	7	-2	-22.2	3	0	0.0
24	Баянзүрх	29	9	45.0	31	8	34.8	21	6	40.0
25	Сүхбаатар	15	7	87.5	15	6	66.7	9	1	12.5
26	Сонгинохайрхан	36	0	0.0	46	5	12.2	28	-1	-3.4
27	Хан-уул	14	-14	-50.0	14	-15	-51.7	12	-3	-20.0
28	Чингэлтэй	6	-6	-50.0	6	-6	-50.0	5	-4	-44.4
29	Багануур	5	3	2.5д	5	3	2.5д	3	2	3д
30	Багахангай	1	-1	-50.0	1	-1	-50.0		-1	
31	Налайх	6	-1	-14.3	6	-7	-53.8	4	-6	-60.0


### 3.4 ГЭМТСЭН ХҮН

**Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн** – зам тээврийн осолд өртөж их бага, тодорхой хэмжээгээр гэмтэл, бэртэл авсан /зөөлөн эдийн гэмтэл, шарх авсан, шалбарсан, зулгарсан гэх мэт/ хүнийг багтаасан тоон үзүүлэлт юм.

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн** – зам тээврийн ослын улмаас биед авсан гэмтлийн зэрэг нь шүүх эмнэлгийн магадлагаагаар хүндэвтэр, хүнд зэрэг тогтоогдон эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргийн улмаас гэмтсэн хүний тоон үзүүлэлт юм.



ГЭМТСЭН ХҮНИЙ  
ТООН ҮЗҮҮЛЭЛТ



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүн

Гэмт хэргийн ослын улмаас амь насаа алдсан хүн

**Гэмтсэн хүний үзүүлэлтийг аймаг, дүүргээр харуулбал:**

Д/д	Төв, орон нутаг	Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүн			Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн		
		2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/	2019 он	Өсөлт, бууралт /тоогоор/	Өсөлт, бууралт /хувиар/
1	Архангай	99	34	52.3	29	-1	-3.3
2	Баян-өлгий	19	10	2.1д	18	3	20.0
3	Баянхонгор	26	21	5.2д	15	8	2.1д
4	Булган	38	0	0.0	12	-10	-45.5
5	Говь-алтай	25	7	38.9	13	5	62.5
6	Говьсүмбэр	33	5	17.9	14	3	27.3
7	Дархан-уул	67	-10	-13.0	20	-27	-57.4
8	Дорноговь	64	20	45.5	40	20	2д
9	Дорнод	62	18	40.9	23	-9	-28.1
10	Дундговь	29	-11	-27.5	12	1	9.1
11	Завхан	20	-14	-41.2	3	-10	-76.9
12	Орхон	44	1	2.3	21	-9	-30.0
13	Өвөрхангай	37	5	15.6	23	-13	-36.1
14	Өмнөговь	23	-10	-30.3	54	14	35.0
15	Сүхбаатар	52	27	2д	22	3	15.8
16	Сэлэнгэ	60	-2	-3.2	39	-19	-32.8
17	Төв	223	-75	-25.2	79	33	71.7
18	Увс	32	12	60.0	4	-12	-75.0
19	Ховд	24	-1	-4.0	21	-4	-16.0
20	Хөвсгөл	60	39	2.8д	23	5	27.8
21	Хэнтий	48	9	23.1	26	-4	-13.3
22	Баянгол	397	-184	-31.7	79	4	5.3
23	Баянзүрх	608	-264	-30.3	118	22	22.9
24	Сүхбаатар	371	-187	-33.5	72	5	7.5
25	Сонгинохайрхан	646	-136	-17.4	143	59	70.2
26	Хан-уул	358	-120	-25.1	77	7	10.0
27	Чингэлтэй	267	-142	-34.7	46	3	7.0
28	Багануур	15	-7	-31.8	6	-4	-40.0
29	Багахангай	6	0	0.0	4	2	2д
30	Налайх	37	-16	-30.2	16	-1	-5.9

### 3.5 ГЭМТСЭН ХҮНИЙ ГЭМТЛИЙН ЗЭРЭГ

Зам тээврийн ослын хамгийн хүнд үр дагавар бол хүний эрүүл мэнд, амь нас хохирох явдал байдаг. Зам тээврийн ослын үед хэн хохирогч болж байгаа, гэмтлийн хүнд хөнгөн гэмтсэн эрхтэн, юунаас гэмтэл авч байгаа зэрэг болон гэмтэл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох нь түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг багасгах, эмнэлгийн тусламжийг шуурхай оновчтой үзүүлэх зэрэг арга хэмжээг төлөвлөх, боловсронгуй болгоход нэн чухал ач холбогдолтой.

#### УЛСЫН ХЭМЖЭЭНД ГЭМТСЭН 3790 ХҮНИЙ ГЭМТЛИЙН ЗЭРЭГ:



Бага зэрэг гэмтэл, бэртэл авсан

2718 буюу 71.7%

Хөнгөн гэмтэл

166 буюу 4.4%

Хүндэвтэр гэмтэл

711 буюу 18.8%

Хүнд гэмтэл


195 буюу 5.1%

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүний 71.7% нь зөөлөн эдийн гэмтэл, бэртэл, шалбарсан, зулгарсан гэх мэт амь насанд аюул багатай гэмтэл авсан байна.


**Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн хувьд гэмтлийн зэргийн эзлэх хувиар тооцвол:**

- Хөнгөн зэргийн гэмтэл тогтоогдсон – 166
- Хүндэвтэр зэргийн гэмтэл тогтоогдсон – 711
- Хүнд зэргийн гэмтэл тогтоогдсон 195 байгаа нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний 66,3% нь хүндэвтэр гэмтэл авчээ.

Хүнд зэргийн гэмтэл авсан 36 хүн эмчлэгдэж байгаад 30 хоногт амь насаа алдсан байна.



ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС **2019** ОНД ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД **24** ТЭРБУМ **308.2** САЯ ТӨГРӨГИЙН ХОХИРОЛ УЧИРСАНЫ **19** ТЭРБУМ **823.5** САЯ ТӨГРӨГИЙН БУЮУ **82.0** ХУВИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙНА.




### 3.6 ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС НАС БАРСАН, ГЭМТСЭН ХҮҮХДИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Бүртгэгдсэн зам тээврийн /хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан/ ослын 22.0 хувийг хүүхэд өртсөн осол эзэлж, нийт нас барсан хүний 13.8 хувийг хүүхдийн нас баралт, гэмт хэргийн улмаас гэмтсэн хүний 14.3 хувийг хүүхэд гэмтсэн байна.

Д/д	Төв, орон нутаг	Нас барсан хүүхэд	Өсөл, бууралт	2019 онд нийт нас барсан хүнд хүүхдийн эзлэх хувь	Гэмтсэн хүүхэд	Өсөлт, бууралт	2019 онд нийт гэмтсэн хүнд хүүхдийн эзлэх хувь
1	Архангай	6	6д	35.3	6	3д	20.7
2	Баян-өлгий			0.0	2	-66.7	11.1
3	Баянхонгор	1		8.3	1	0.0	6.7
4	Булган	1	-50.0	7.1	2	2д	16.7
5	Говь-алтай				4	4д	30.8
6	Говьсүмбэр	1		50.0			0.0
7	Дархан-уул			0.0	6	-40.0	30.0
8	Дорноговь	1	-50.0	7.7	1	-66.7	2.5
9	Дорнод	4	2д	22.2	2	-66.7	8.7
10	Дундговь	0		0.0	1		8.3
11	Завхан	3	3д	50.0	0		0.0
12	Орхон	3		50.0	3	-50.0	14.3
13	Өвөрхангай	2	2д	22.2	2	-66.7	8.7
14	Өмнөговь	3		15.0	6	20.0	11.1
15	Сүхбаатар	1	-50.0	10.0	7	75.0	31.8
16	Сэлэнгэ	2	-33.3	12.5	5	-37.5	12.8
17	Төв	3	-50.0	8.8	3	-40.0	3.8
18	Увс			0.0	0		0.0
19	Ховд	1	-50.0	10.0	4	-42.9	19.0
20	Хөвсгөл	2		11.8	4	4д	17.4
21	Хэнтий	4	-50.0	44.4	4	33.3	15.4
22	Баянгол	5	-33.3	0.0	10	66.7	12.7
23	Баянзүрх		4д	23.8	18	63.6	15.3
24	Сүхбаатар	3	2.5д	0.0	11	2.7д	15.3
25	Сонгинохайрхан	1		10.7	26	2.8д	18.2
26	Хан-уул	1	0.0	8.3	8	-27.3	10.4
27	Чингэлтэй			20.0	10	-16.3	21.7
28	Багануур			0.0	1	-75.0	16.7
29	Багахангай	1	-50.0		0		0.0
30	Налайх			25.0	2	0.0	12.5
<b>Улаанбаатар</b>		<b>11</b>	<b>-8.3</b>	<b>12.9</b>	<b>86</b>	<b>41.0</b>	<b>15.3</b>
<b>Орон нутаг</b>		<b>38</b>	<b>15.2</b>	<b>16.2</b>	<b>63</b>	<b>-23.2</b>	<b>12.3</b>
<b>Нийт дүн</b>		<b>49</b>	<b>8.9</b>	<b>15.4</b>	<b>146</b>	<b>4.2</b>	<b>13.9</b>

Хүүхэд өртсөн осол нь нийслэлд их бүртгэгдсэн ч ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 77.6% нь орон нутгийн замд бүртгэгдсэн байна. Орон нутагт гарч буй ослын улмаас хүүхдийн амь нас илүү хохирч байгаа нь орон нутагт гарсан осол нь хохирол ихтэй, ноцтой осол байгаатай холбоотой.

### Амь насаа алдсан хүүхдийн үзүүлэлт




### 3.7 ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН НАС, ХҮЙС

Зам тээврийн осолд өртсөн нийт **819** хүүхдийн **34,6%**-г **0-6** хүртэл насны хүүхэд, **46,0%**-г **7-14** насны хүүхэд, **19,4%**-г **15-17** насны хүүхэд эзэлсэн байна.

д/д	Он	0-6 нас	7-14 нас	15-17 нас
<b>Улсын хэмжээнд</b>				
1	2018	408	462	179
2	2019	283	377	159
<b>Нийслэлийн хэмжээнд</b>				
1	2018	328	398	156
2	2019	212	282	122

### Осолд өртсөн хүүхдийн насны байдал



**2019 ОНД 0-6 НАСНЫ 23 ХҮҮХЭД, 7-14 НАСНЫ 24 ХҮҮХЭД, 15-С ДЭЭШ НАСНЫ 2 ХҮҮХЭД АМЬ НАСАА АЛДЖЭЭ.**

д/д	Он	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Улсын хэмжээнд</b>			
1	2017	676	437
2	2018	580	469
<b>Нийслэлийн хэмжээнд</b>			
1	2017	567	362
2	2018	488	394

### Осолд өртсөн хүүхдийн хүйсийн байдал



ЭРЭГТЭЙ ХҮҮХЭД 580



ЭМЭГТЭЙ ХҮҮХЭД 469

2019 ОНД ЗАМ  
ТЭЭВРИЙН  
ОСЛЫН УЛМААС

22 ЭМЭГТЭЙ  
27 ЭРЭГТЭЙ  
ХҮҮХЭД АМЬ НАСАА  
АЛДЖЭЭ.

### 3.8 ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙСАН ХЭЛБЭР


Зам тээврийн осолд өртсөн нийт хүүхдийн 66,1% нь явганаар, 28,8% нь тээврийн хэрэгслээр зорчигч, 5,1% нь унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцож байхдаа амь нас, эрүүл мэндээрээ хохирч, гэмтэл бэртэл авчээ.

#### Замын хөдөлгөөнд оролцсон хэлбэр /улс, нийслэл/

д/д	Он	Явган зорчигч	Зорчигч	Дугуйгаар зорчигч
<b>Улсын хэмжээнд</b>				
1	2018	698	288	63
2	2019	541	236	42
<b>Нийслэлийн хэмжээнд</b>				
1	2018	590	236	56
2	2019	441	140	35

Нийслэлд зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд нь явганаар замын хөдөлгөөнд оролцогч хүүхдүүд байгаа нь цэцэрлэг, сургуульд бага насны хүүхдүүдэд замын хөдөлгөөний мэдлэг, боловсрол олгох, замын хөдөлгөөнд зөв оролцох хандлага, дадал хэвшээгүйтэй холбоотой гэж үзэж байна.

### Осолд өртсөн хүүхдийн замын хөдөлгөөнд оролцсон хэлбэр



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД  
ЯВГАНААР ОРОЛЦОЖ  
БАЙСАН 23 ХҮҮХЭД,  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР  
ЗОРЧИЖ БАЙСАН  
26 ХҮҮХЭД АМЬ НАСАА  
АЛДСАН БАЙНА.



Нийслэлд хүүхдүүд замын хөдөлгөөнд явганаар оролцож байхдаа амь нас, эрүүл мэндээрээ хохирсон бол орон нутагт тээврийн хэрэгслээр зорчигч нилээдгүй хувийг эзэлж байна. Замын хөдөлгөөнд оролцож явахдаа зам тээврийн осолд 7-14 насны, эрэгтэй хүүхдүүд их өртжээ. Хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсан цаг хугацаа, гариг, сар улирал нь хүүхдийн сургууль хичээлийн цаг хугацаатай давхцаж байгаа ба хүүхдүүд гэр-сургууль-гэр маршрутаар явахдаа өртөх тохиолдол их байна.

Хүүхдийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг автомашин доторх аюулгүй байдлыг хангаж хүүхдийн зориулалтын хамгаалах бүс, хамгаалалтын суудал хэрэглэж хэвших, хүүхдийг зөв тээвэрлэхээс явдал юм. Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 77.6 хувийг орон нутагт бүртгэгдсэн осол эзэлсэн.

Нийслэлд 2019 онд явганаар замын хөдөлгөөнд оролцож гэмтсэн хүүхдийн 36.8% нь насанд хүрсэн харгалзах хүнтэй замын хөдөлгөөнд оролцсон бол 42.1% нь ХАРГАЛЗАХ ХҮНГҮЙ ГАНЦААРАА, 21.1% нь насанд хүрээгүй /найз, ах, эгч дүү/ хүнтэй замын хөдөлгөөнд оролцсон байна.

### 3.9 ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧИЙН НАС ХҮЙС


Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдон шалгагдсан 973 хүний мэдээллийг нэгтгэв.

Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 825 (84.8%) эрэгтэй жолооч, 148 (15.2%) эмэгтэй жолооч эзэлж байна.



Хүйс		Эзлэх хувь
Эрэгтэй	825	84,8
Эмэгтэй	148	15,2



ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН  
**18-34 НАСНЫ** ЗАЛУУ ХҮМҮҮС  
**67.0 ХУВИЙГ** ЭЗЭЛЖ БАЙНА.





### 3.10 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААН

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 25302 зам тээврийн ослын 24741 буюу 97.8% нь жолоочийн буруугаас, 530 буюу 2.1% нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 31 буюу 0.2% нь замын нөхцлөөс шалтгаалсан гэж бүртгэгдсэн.



Бүртгэгдсэн зам тээврийн ослын 97.87 хувь нь жолоочийн буруутай үйлдэл буюу жолоочийн хууль, дүрэм зөрчсөн, сахилга хариуцлагагүй үйл ажиллагаатай холбоотой байна.

### 3.11 ЖОЛООЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЛЭЭС ШАЛТГААЛСАН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ

Бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 97.8 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс үйлдэгдсэн үзүүлэлт гарч байна.

Он		Зам тээврийн осолл холбогдсон жолоочийн буруутай үйлдэл														
		Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	Хурд хэтрүүлсэн	Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	Анхаарал болгоомжгүй	Зогсоох арга хэмжээ аваагүй	Уулзвар нэвтрэх	Гэрлэн дохио	Эргэх үйлдэл	Зай тохируулаагүй	Гүйцэж түрүүлэх	Эсрэг урсгал	Эгнээ байр	Хүн ба тээврийн журам зөрчсөн	Ухрах	Бусад
<b>Улсын хэмжээнд</b>																
2019	Тоо	978	989	131	675	540	4220	142	75	11786	184	209	2964	62	1630	156
	Эзлэх хувь	4.0	4.0	0.5	2.7	2.2	17.1	0.6	0.3	47.6	0.7	0.8	12.0	0.3	6.6	0.6
<b>Нийслэлийн хэмжээнд</b>																
2019	Тоо	514	583	23	11	49	3988	115	19	11586	36	91	2855	36	1487	14
	Эзлэх хувь	2.4	2.7	0.1	0.1	0.2	18.6	0.5	0.1	54.1	0.2	0.4	13.3	0.2	6.9	0.1

## ЖОЛООЧИЙН БУРУУТАЙ ОСЛЫН ШАЛТГААНААС



## ЖОЛООЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЛЭЭС ГАРСАН ОСЛЫН ШАЛТГААНЫГ ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ХАРЬЦУУЛАН АВЧ ҮЗВЭЛ:

#### ӨССӨН үзүүлэлт:

- анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон 26,4%,
- согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 22,4%,
- зогсоох арга хэмжээ аваагүйгээс 14.2%,
- эргэх үйлдэл буруу гүйцэтгэсэн 11.9%,
- бүрэн бус тээврийн хэрэгсэл 4.8%,
- гүйцэж түрүүлэх үйлдэл 5.7%
- хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн 2 дахин

#### БУУРСАН үзүүлэлт:

- ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэн 21,1%
- уулзвар гарц нэвтрэх журам 21,0%
- хурд хэтрүүлсэнээс 19.6%,
- эгнээ байр буруу эзэлсэн 15,8%,
- эсрэг урсгалд орсон 11,4%
- гэрэл дохио зөрчсөн 7,2%
- хажуу хоорондын зай тохируулаагүй 7,1%,

### 3.12 ЯВГАН ЗОРЧИГЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЛЭЭС ШАЛТГААЛСАН ОСОЛ

**ЯВГАН ЗОРЧИГЧ** – “замаар явган яваа /зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж яваагаас бусад/ хүн, жагсаалаар яваа болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэргэнцэртэй, түүнчлэн тэрэг түрж чарга чирж, мотоцикл, мопед, унадаг дугуйг хөтөлж замаар яваа хүнийг<sup>1</sup>.

**“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧ”** гэж замаар явж байгаа жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч, явган зорчигчийг<sup>2</sup>. Явган зорчигч нь жолоочийн нэгэн адил замын хөдөлгөөнд оролцогч юм.

Замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх хэрэгжүүлэх нь зөвхөн жолоочид биш замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигчид ч хамааралтайг Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хуулийн /14.7/ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулинд зааж өгсөн байдаг.

#### ЯВГАН ЗОРЧИГЧИЙН БУРУУГААС ШАЛТГААЛСАН ОСОЛ:



- явган хүний гарцын шугам, гарамгүй газраар зам хөндлөн гарах
- гэрлэн дохио зөрчиж зам хөндлөн гарах
- ойртон ирж яваа тээврийн хэрэгслийн урдуур зам хөндлөн гүйх



- зогсож буй автомашины урдуур буюу автобуснаас буугаад урдуур нь замын зорчих хэсэгт орох
- замын зорчих хэсэг дээр буюу зорчих хэсгийн захаар дагаж явах



- согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ авч явах чадваргүй үедээ замын зорчих хэсэг дээгүүр явах, хэвтэх
- замын голоор тавьсан тусгаарлах хайс, хашлага дээгүүр давах, доогуур нь шургах



- замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжгүй оролцох /зам хөндлөн гарахдаа гар утсаар ярих, чихэвчний хөгжим сонсох, мессеж бичих/
- сургуулийн өмнөх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулах /эцэг ах асран хамгаалагчийн буруугаас/ зэргээс автомашинд дайрагдах, мөргөгдөх хэлбэрээр хохирох тохиолдол бүртгэгдсээр байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2019 онд улсын хэмжээнд 530 буюу нийт бүртгэгдсэн ослын 2.1 хувийг эзэлсэн байна. Явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсэхгүй, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна.

1 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.11 заалт.

2 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.7 заалт.

д/д	Он	Жолоочийн буруугаас	Замын нөхцөлөөс	Явган зорчигчийн буруугаас	
1	2019	Улсын хэмжээнд	24741	31	530
		Нийт осолд эзлэх	97.8	0.1	2.1
		Хувь хэмжээнд	21407	16	451
		Нийт осол эзлэх	97.8	0.1	2.1

### 3.13 ЗАМЫН НӨХЦӨЛ, ТЕХНИКИЙН ГЭМТЛЭЭС ШАЛТГААЛСАН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ

**Авто замын аюулгүй байдал нь замын хөдөлгөөний нэг хэсэг юм.**

**Замын нөхцөл** - Замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ нь шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна. Зам-орчин нь өөрөө замын хөдөлгөөний нэг бүрдэл болдог.

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан осол улсын хэмжээнд 31 бүртгэгдсэнээс нийслэлд 16, орон нутагт 15 байна. Дээрх хүчин зүйлд техникийн гэмтэл, гадны гэрэл /замын гэрэл/, зам орчны нөхцлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон байдал хангалтгүй байгаагаас замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага хэвээр байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцлүүдийн нэг болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдолын бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна.

Замын нөхцлөөс шалтгаалсан зам тээврийн ослын хохирлыг тухайн зам, байгууламжийг хариуцсан байгууллага, аж ахуйн нэгж бүрэн хариуцдаг учраас энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлага маш өндөр байдаг гэж Европын Хөдөлгөөний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн тээврийн хорооны тайланд дурьджээ.

Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам дотроо аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.


Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын шалтгаан: Хүний амь нас хохирсон зам тээврийн ослын 26.6 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 28.2 хувь нь анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон, 18.5 хувь нь хурд хэтрүүлсэнээс шалтгаалж, онхолдох хэлбэрээр 47.6 хувь нь гарч хүний амь нас хохирчээ.



СОГТУУГААР  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ  
ЖОЛООДСОН




АНХААРАЛ  
БОЛГООМЖГҮЙ  
ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦСОН



ХУРД  
ХЭТРҮҮЛСЭНЭЭС


**ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН:** Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 16.4 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 11.5 хувь нь хурд хэтрүүлсэн, 7.1 хувь нь уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөнөөс шалтгаалан гарчээ.



СОГТУУГААР  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ  
ЖОЛООДСОН




ХУРД  
ХЭТРҮҮЛСЭНЭЭС



УУЛЗВАР ГАРЦ  
НЭВТРЭХ ЖУРАМ  
ЗӨРЧСӨН

### 3.14 УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ХЭЛБЭР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 20764 буюу 82.1% нь мөргөлдөх, 1996 буюу 7.9 % нь явган зорчигч мөргөх, 1071 буюу 4.2% нь онхолдох, 986 буюу 3.9% үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, шон мөргөсөн/ 75 осол зорчигч унагах, 88 унадаг дугуйтай хүн мөргөх, 162 осол мал, амьтан дайрах, 160 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.



Улсын хэмжээнд ЯВГАН ЗОРЧИГЧ МӨРГӨХ хэлбэрээр бүртгэгдсэн ослын 1996 буюу 83.0% нь НИЙСЛЭЛД, улсын хэмжээнд ОНХОЛДОХ хэлбэрээр бүртгэгдсэн ослын 1071 буюу 90.0 % нь ОРОН НУТАГТ бүртгэгджээ.

ЗАМ ТЭЭВРИЙН  
ОСОЛ ГАРЧ БУЙ  
ХЭЛБЭРИЙГ  
ӨНГӨРСӨН ОНЫ  
ҮЗҮҮЛЭЛТТЭЙ  
ХАРЬЦУУЛАХАД:



**БУУРСАН:**

- тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх 17.5%,
- явган зорчигч мөргөх 20,8%,
- дугуйгаар зорчигч мөргөх 28,5%, буурсан байна.



**ӨССӨН:**

- онхолдох хэлбэрээр гарсан осол 33,0%,
- үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр гарсан осол 52,2%,
- зорчигч унагасан хэлбэрээр гарсан осол 4 дахин,
- мал амьтан дайрах хэлбэр 74,2% өссөн байна.

### Нийслэлийн болон орон нутагт бүртгэгдсэн ослын хэлбэр

#### УЛААНБААТАР ХОТОД:

- Мөргөлдөх – **19188** буюу **87.7%**
- Явган зорчигч мөргөх – **1657** буюу **7.6%**
- Онхолдох – **106** буюу **0.5%**
- Зорчигч унагах – **27** буюу **0,1%**
- Дугуйтай хүн мөргөх - **68** буюу **0.3%**
- Тээврийн хэрэгсэлээр үл хөдлөх зүйл мөргөх – **782** буюу **3.6%**
- Мал, амьтан дайрах – **34** буюу **0.2%** нь бүртгэгдсэн байна.

#### ОРОН НУТАГТ:

- Мөргөлдөх – **1576** буюу **46.0%**
- Явган зорчигч дайрах – **339** буюу **9.9%**
- Онхолдох – **965** буюу **28.2%**
- Зорчигч унагах – **48** буюу **1.4%**
- Дугуйтай хүн мөргөх - **20** буюу **0.6%**
- Тээврийн хэрэгсэлээр үл хөдлөх зүйл мөргөх – **204** буюу **6.0%**
- Мал амьтан дайрах - **128** буюу **3.7%**
- Бусад хэлбэрээр **148** буюу **4,3%** нь бүртгэгдсэн байна.

Нийслэл хотод автомашин мөргөлдөх, явган зорчигч мөргөх хэлбэрээр дийлэнх зам тээврийн осол гарсан, орон нутагт автомашин мөргөлдөх, онхолдох хэлбэрээр осол их бүртгэгдсэн.

### 3.15. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН УЛИРАЛ, САР, ГАРИГ, ЦАГ, ЗАМ ОРЧИН, ЦАГ АГААР

Зам тээврийн ослын 27,6% нь өвөл, 25,7% нь хавар, 21,4% нь зун, 25,3% нь намар бүртгэгджээ. Өвлийн улиралд замын гадаргуунд өөрчлөлт орох, хальтиргаа гулгаанаас хамааралтай зам тээврийн ослын дуудлага өсдөг учир тухайн улиралд бүртгэгдсэн осол их байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын үзүүлэлтийг улирлаар харуулбал:

#### ӨВӨЛ

- ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА  
20555 БУЮУ 26.5%
- БҮРТГЭГДСЭН БҮХ ОСОЛ  
6980 БУЮУ 27.6%
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ  
297 БУЮУ 23.3%
- АМЬ НАСАА АЛДСАН ХҮН  
87 БУЮУ 15.5%
- ГЭМТСЭН  
766 БУЮУ 20.2%

#### ХАВАР

- ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА  
18429 БУЮУ 23.8%
- БҮРТГЭГДСЭН БҮХ ОСОЛ  
6705 БУЮУ 25.7%
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ  
321 БУЮУ 25.2%
- АМЬ НАСАА АЛДСАН ХҮН  
128 БУЮУ 22.8%
- ГЭМТСЭН  
1102 БУЮУ 29.1%

#### ЗУН

- ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА  
16978 БУЮУ 21.9%
- БҮРТГЭГДСЭН БҮХ ОСОЛ  
5416 БУЮУ 21.4%
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ  
354 БУЮУ 27.7%
- АМЬ НАСАА АЛДСАН ХҮН  
173 БУЮУ 30.8%
- ГЭМТСЭН  
1042 БУЮУ 27.5%


#### НАМАР

- ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА  
21482 БУЮУ 27.7%
- БҮРТГЭГДСЭН БҮХ ОСОЛ  
6399 БУЮУ 25.3%
- ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ  
304 БУЮУ 23.8%
- АМЬ НАСАА АЛДСАН ХҮН  
173 БУЮУ 30.8%
- ГЭМТСЭН  
880 БУЮУ 23.2%




### 3.16 УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ОСОЛД ХОЛБОГДСОН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРӨЛ

Зам тээврийн осолд холбогдсон автомашиныг төрлөөр харуулбал:




### 3.17 МОТОЦИКЛООР ҮЙЛДЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, НАС БАРАЛТ

Монгол улсад нийт 46951 мотоцикл бүртгэлтэй үүний 5729 буюу 12.2% нь нийслэлд 41222 буюу 87,8% нь орон нутагт бүртгэлтэй байна. Баянхонгор, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Төв, Увс аймгуудын мотоциклын хэрэглээ бусад аймгуудаас илүү байна.



Улсын хэмжээнд мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол 489 бүртгэгдэж, 122 хүний амь нас хохирч, 273 хүн гэмтэл бэртэл авчээ. Тухай ослын 84.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн.

Мотоцикль жолоодсон зам тээврийн ослын гаралтыг харахад: энэ төрлийн ослын 28 буюу 5,7% нь Өвөрхангай аймагт, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгуудад тус бүр 34 осол бүртгэгдсэн байна.




### Мотоцикл холбогдсон зам тээврийн осол:



Мотоциклоор замын хөдөлгөөнд оролцож буй тохиолдолд хамгаалалтын малгай өмсөж хэвшихэд үхэлд хүргэх эрсдэл 40 хүртэл хувиар буурна гэж олон улсад үздэг байна.

Мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас Баянхонгор, Дорноговь, Сүхбаатар, Төв аймгуудад 17-14 хүн замын хөдөлгөөнд оролцож яваад амь насаа алджээ.

### Амь насаа алдсан хүний тоон үзүүлэлт



2019 онд Монгол улсад бүртгэгдсэн мотоциклын тоо өнгөрсөн оны үзүүлэлтээс 16.1%-р, мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол 11.4%-р тус тус буурсан ч мотоциклоор үйлдэгдсэн ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 5.2%-р өссөн.


Мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохдоо хамгаалалтын малгай өмсөөгүй 4116 зөрчилд арга хэмжээ тооцсон байна.

### 3.18 ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ХОЛБОГДСОН ХҮМҮҮСИЙН ЖОЛООЧ БОЛСОН ЖИЛЭЭР ГАРГАСАН СУДАЛГАА

Зам тээврийн осолд холбогдсон жолоодох эрхтэй 15540 жолоочийн жолооч болсон жилээр судалгаа хийхэд: 27.5% нь 0-4 жил, 30.9% нь 5-9 жил, 16.1% нь 10-14 жил, 21.2% нь 15-19 жил, 3.2% нь 20-24 жил, 0.4% нь 25-29 жил, 0.4% нь 30-34 жил, 0.2% нь 35-39 жил, 0.2% нь 40-55 жил тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч байна.

Зам тээврийн осолд 12204 эрэгтэй, 3336 эмэгтэй жолооч хэрэгт холбогдсон байна.

#### Зам тээврийн осолд холбогдсон хүмүүсийн жолооч болсон жил



№	Жолооч болсон жил	Зам тээврийн осолд холбогдсон жолоочийн тоо	5 жилээр үзүүлэлт
1	0	675	4271
2	1	1015	
3	2	924	
4	3	841	
5	4	816	
6	5	1099	4796
7	6	1150	
8	7	889	
9	8	979	
10	9	679	
11	10	538	2496
12	11	681	
13	12	448	
14	13	403	
15	14	426	
16	15	1057	3296
17	16	808	
18	17	731	
19	18	422	
20	19	278	
21	20	215	500
22	21	133	
23	22	97	
24	23	29	
25	24	26	
26	25	16	65
27	26	5	
28	27	21	
29	28	11	
30	29	12	
31	30	11	55
32	31	12	
33	32	13	
34	33	8	
35	34	11	
36	35	6	34
37	36	8	
38	37	7	
39	38	8	
40	39	5	
41	40	2	27
42	41	6	
43	42	2	
44	43	8	
45	44	2	
46	45	1	
47	46	1	
48	47	1	
49	48	1	
51	49	2	
53	52	1	

### 3.19. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ХОЛБОГДСОН АВТОМАШИНЫ ЖОЛООНЫ ХҮРДНИЙ БАЙРЛАЛ, НАСЖИЛТ, МАРК,

Нийслэлийн нутаг дэвсгэрт зам тээврийн осолд холбогдсон 21282 автомашины жолооны хүрдний байрлал, автомашины марк, брэндээр ангилан тоон судалгаа хийсэн.

Монгол улсад 2019 оны байдлаар бүртгэлтэй автомашины 520452 буюу 72.7% нь баруун талдаа, 413690 буюу 27,3% нь зүүн талдаа хүрдний байрлалтай байна.


Зам тээврийн осолд холбогдсон 21282 автомашины 15476 буюу 72,7% нь, 5806 буюу 27,3% нь зүүн /зөв/ талдаа жолооны хүрдтэй автомашин байна.

#### Зам тээврийн осолд холбогдсон автомашины жолооны хүрдний байрлал



#### Зам тээврийн осолд холбогдсон автомашины марк, брэнд

Судалгаанд хамрагдсан 21282 автомашины 73.8% нь Япон улсад үйлдвэрлэгдсэн, 20.0% нь Солонгос, 3.6% нь Хятад, 1.0% нь Герман, 0.5% нь Америк, 0.3% нь Оросын холбооны улсад үйлдвэрлэгдсэн автомашин эзэлж, 178 буюу 0.8% нь бусад улс оронд үйлдвэрлэгдсэн автомашин байна.




### 3.20 МОНГОЛ УЛСЫН ЖОЛООЧИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ


Монгол улсын жолоочийн бүртгэлийн санд 1265544 жолооч бүртгэлтэй, 2019 онд 63154 хүн шинээр жолооч болжээ. Монгол улс 2015 онд 648825 жолоочтой байсан бол жолоочийн тоо 2019 оны байдлаар 95.1%-р өссөн байна.

Сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр жилд дундажаар 70 мянган жолооч шинээр бэлтгэгдэн Монгол улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрх авч байна.

Монгол улсын жолоочийн тоо



Монгол улсад бүртгэлтэй жолоочийн насны ангилал



### 3.21 ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ҮЙЛДЭГДСЭН, ОСОЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсад 2019 онд тээврийн хэрэгслийн тоо 72148 тээврийн хэрэгсэл буюу 7.4 хувиар өсч, 2019 онд 25302 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 4172 буюу 3.7 хувиар буурсан байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2019 онд 1276 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд 3.7 хувь, нийслэлд 15.1 хувиар тус тус өсч, орон нутагт 4.6 хувиар буурсан. Энэ төрлийн гэмт хэргийн 53.4 хувь нь орон нутагт, 46.6 хувь нь нийслэлд бүртгэгдсэн нь, хөдөө орон нутгийн замд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт шалгалт сул, орон нутгийн замд хурд хэтрүүлсэн хор аюул, хохирол ихтэй зам тээврийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Манай улсад бүртгэлтэй автомашины 65,0 хувийг суудлын автомашин эзэлж, зам тээврийн осолд холбогдсон автомашины 86,6 хувийг суудлын автомашин эзэлж байна.

Хүний амь нас хохирсон осол зун болон намрын улиралд их бүртгэгдсэн байхад өвлийн улиралд ослын гэмтэл, бэртэл ихэнх хувийг эзэлж байна.

Гэмт хэрэг, осолд холбогдсон хүмүүсийн нас, хүйсийн үзүүлэлтээс харахад 18-45 насны эрэгтэй, хөдөлмөрийн насны хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцох соёл хангалтгүй, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн буруутай үйлдлээс хамаарч, иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирсоор байна.

Зам тээврийн ослын улмаас 2019 онд 561 хүний амь нас хохирч, 3790 хүн эрүүл мэндээрээ хохирсон нь 2018 оны үзүүлэлтээс амь насаа алдсан хүний тоо 0.2 хувь, гэмтсэн хүний тоо 20.4 хувиар тус тус буурсан. Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүний 76.6 хувь нь орон нутагт, нийт гэмтсэн хүний 71.4 хувь нь нийслэлд бүртгэгдсэн осол эзэлж байна. Өөрөөр хэлбэл орон нутагт зам тээврийн ослын улмаас хүний амь нас их хохирч, нийслэлд ослын улмаас хөдөлгөөнд оролцогчид гэмтэх нь их байна.

Зам тээврийн ослын шалтгааныг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 22.4 хувиар, эргэх үйлдэл буруу хийсэн 11,9 хувь, бүрэн бус тээврийн хэрэгслээс шалтгаалсан осол 4,8 хувиар өсчээ.

Зам тээврийн осолд өртсөн хүмүүсийн замын хөдөлгөөнд оролцсон хэлбэрээс дүгнэхэд: Улаанбаатар хотод гарсан зам тээврийн осолд өртсөн хүний 60.1 хувь нь явган зорчигч байхад орон нутагт 43.3 хувийг тээврийн хэрэгсэлээр зорчигч эзэлж байна.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ маршрутаар

явахдаа анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа гарц, гарамтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр өөрсдийн замын хөдөлгөөний мэдлэг дутмагаас осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна.

Зам тээврийн осолд 2019 онд 819 хүүхэд өртсөн нь урд оны мөн үеэс 10,49 хувиар буурсан байна. Осолд өртсөн хүүхдийн хүйсийн байдлаас үзэхэд 55.3 хувь нь эрэгтэй, 44.7 хувь нь эмэгтэй хүүхдүүд зам тээврийн осолд өртөж байна.

Зам тээврийн осолд өртсөн нийт хүүхдийн насны байдлаас судлахад: Олон жилийн үзүүлэлтэд эмэгтэй хүүхдийн осолд өртөх хувь эрэгтэй хүүхдийнхээс 15-20 орчим хувиар бага байсан бол, 2018 онд 10,6 хувь болж, сүүлийн жилүүдэд зам тээврийн осолд эмэгтэй хүүхэд өртөх явдал ихэсч байгаа нь харагдаж байна.

Арав хүртэл насны хүүхэд ганцаараа замын хөдөлгөөнд оролцож зам тээврийн осолд өртөх нь 2018 онд 26,0 хувиар буурч байсан боловч, 2019 онд энэ үзүүлэлт 4,0 хувиар өссөн нь, эцэг эх, асран хамгаалагч, насанд хүрсэн гэр бүлийн гишүүд нь тухайн насны хүүхдийг замын хөдөлгөөнд оролцоход анхаарал хандуулах шаардлагатай байна.

Хүүхэд өртсөн осол нь нийслэлд их бүртгэгдсэн ч ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн 77.6 хувь нь орон нутгийн замд бүртгэгдсэн нь хөдөө, орон нутгийн замд замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний дүрэм зөрчих, хурд хэтрүүлэх, зорчигч болон хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аваарын бүс, зориулалтын суудал хэрэглэхгүй бусдын эрүүл мэнд, амь насанд аюул учруулсаар байна.

Зам тээврийн осолд холбогдсон 21282 автомашины 15476 буюу 72,7 хувь нь баруун /буруу/, 5806 буюу 27,3 хувь нь зүүн /зөв/ талдаа жолооны хүрдтэй автомашин байна. Цаашид гадаадын улсуудаас орж ирж байгаа автомашиныг зүүн талдаа жолооны хүрдтэй автомашины эзлэх хувийг ахиулах, баруун /буруу/ талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах шаардлагатай байна.

Улсын хэмжээнд мотоциклоор үйлдэгдсэн зам тээврийн осол 489 бүртгэгдэж, 122 хүний амь нас хохирч, 273 хүн гэмтэл бэртэл авчээ. Тухай ослын 84.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн.

Мотоциклоор үйлдэгдсэн ослын улмаас амь насаа алдсан хүний дийлэнхи нь жолооч, тээврийн хэрэгслээр зорчигч хамгаалалтын малгай өмсөж хэвшээгүй, мотоциклыг зориулалтаар нь зөв зохистой хэрэглэх дадал, мэдлэг, чадвар хангалтгүй байснаас ослын үед толгойндоо гэмтэл авсан нь үхэлд хүргэх шалтгаан болжээ.



Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол 2019 онд улсын хэмжээнд 530 буюу нийт бүртгэгдсэн ослын 2.1 хувийг эзэлсэн байна. Явган зорчигчдын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дутмаг, замын хөдөлгөөнд соёлтой оролцохыг хүсэхгүй, тэдэнд оногдуулах хариуцлага хэрэгжихгүй байгаагаас явган зорчигч амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна. Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн осол өнгөрсөн оны үзүүлэлтээс буурсан хэдий ч замын хөдөлгөөнд оролцож байхдаа осолд өртөх, хохирох үзүүлэлт буурахгүй байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаанаас авч үзвэл: бүртгэгдсэн ослын 97.8 хувь нь жолоочийн буруутай үйлдэл, 2.1 хувь нь явган зорчигчийн буруу, 0.2 хувь нь замын нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Жолоочийн буруутай үйлдэл дотроос жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл буруу гүйцэтгэсэнээс шалтгаалсан осол дийлэнх хувийг эзэлсэн. Хүний амь нас хохироосон ослын гол шалтгаан нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцсон, хурд хэтрүүлсэн шалтгаан давамгайлж байна.

Бүртгэгдсэн зам тээврийн ослын хэлбэрээс авч үзвэл: явган зорчигч мөргөсөн нийт ослын 83.0 хувь нь нийслэлд гарсан байхад онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн нийт ослын 90.0 хувь нь орон нутагт гарчээ. 2019 оны үзүүлэлтэд бүртгэгдсэн зам тээврийн осол р буурсан хэдий ч орон нутагт онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн осол 33.0 хувь, үл хөдлөх зүйл мөргөх хэлбэрээр гарсан осол 52.2 хувь, тээврийн хэрэгсэлээр зорчигч унагах хэлбэрээр бүртгэгдсэн осол 4 дахин өссөн үзүүлэлт гарч байна.

Зам тээврийн осолд холбогдсон жолоодох эрхтэй 15540 жолоочийн 27.5 хувь нь 0-4 жил, 30.9 хувь нь 5-9 жил, 16.1 хувь нь 10-14 жил, 21.2 хувь нь 15-19 жил, 3.2 хувь нь 20-24 жил, 0.4 хувь нь 25-29 жил, 0.4 хувь нь 30-34 жил, 0.2 хувь нь 35-39 жил, 0.2 хувь нь 40-55 жил тээврийн хэрэгсэл жолоодсон жолооч байна.

Тээврийн хэрэгслийг 0-9 жил жолоодож байгаа жолооч нараас нийт бүртгэгдсэн ослын 58,4 хувьд холбогдсон статистик мэдээнээс үзэхэд 10-аас дээш жил автомашин жолоодсон жолооч нарт жолоодох дадал зуршил, туршлага, бий болж байна гэж үзэж байна.


### **Цаашид хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ**

Технологийн дэвшил хурдацтай хөгжиж буй энэ цаг үед авто замын алсын болон хот доторх хяналтыг хүний хүчээр бус технологийн дэвшлийг ашиглан хянаж, осол, хэрэг олон давталттайгаар гарч байгаа газруудад дундаж хурд тогтоох хяналтын цогц систем байгуулах, хяналтын камеруудыг байрлуулж, зөрчлийг бүртгэлжүүлэн, жолооч нарын хариуцлагыг дээшлүүлэх, зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай байна.


# ДӨРӨВ: МОНГОЛ УЛСЫН 2019 ОНД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТААР БҮРТГЭГДЭЖ БУЙ “ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ”-ЫН БАЙДАЛ

Монгол улсад 2015 оноос “Осол гэмтлийн тандалтын тогтолцоо” хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2016 оны 1 сарын 1-нээс улс орон даяар “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягтаар осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын шинэ тохиолдлыг бүртгэж эхэлсэн. Энэхүү маягтаар бүх шатны эрүүл мэндийн байгууллага осол гэмтлийн шинэ тохиолдлыг бүртгэж, эрүүл мэндийн цахим программ Hinfo V3.0-д шивж, цахим мэдээний сан үүсгэж байгаа ба сар бүр ГССҮТөвийн СМТСАлбанд мэдээллэж байна. Мэдээний урсгалыг дараах схемээс харна уу.

## Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын шинэ тохиолдлыг бүртгэх мэдээллийн схем



Эрүүл мэндийн салбарт бүртгэгдэж буй зам тээврийн осол нь өвчний олон улсын 10-р ангиллаар **V00-V99**-д хамаарах тээврийн хэрэгслийн ослууд бүртгэгддэг. Үүнд:



“Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягт нь ЭМС-ын 2011 оны 434 тоот тушаалаар батлагдсан А4-ийн 2 нүүр хэмжээтэй, үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийн хэсэг болон гэмтлийн шалтгаан, онош, авсан арга хэмжээ гэх мэтийг нарийн тусгасан тандалтын хуудас юм. Энэхүү маягтад “ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ”-ын шинэ тохиолдолд дараах 5 асуултыг нэмэлтээр асуудаг.


**“Зам тээврийн осол”-ын шинэ тохиолдолд тавих асуумж. Хүснэгт 6.**

B1 Осол гарах үед та ямар тээврийн хэрэгслээр явж байсан бэ		B2 Та ослын үед замын хөдөлгөөнд яаж оролцож байсан бэ		B3 Та ослын үед ямар зүйлтэй мөргөлдсөн бэ		B4 Осол гарах үед та ямар хамгаалалт хэрэглэсэн бэ		
Явган	1	Явган зорчигч	1	Явган хүн, мал амьтан	1	Хамгаалалтын бүс		
Унадаг дугуй, мопед	2	Жолооч	2	Унадаг дугуй	2	Тийм	1	
Мотоцикл	3	Зорчигч	3	Мотоцикл	3	Үгүй	2	
Суудлын машин	4	Уралдааны морь унаач	4	Суудлын машин ба бага даацын машин	4	<b>B5 Хамгаалалтын малгай</b>		
Ачааны машин	5	Энгийн морь унаач	5	Автобус, ачааны машин	5	Тийм	1	
Нийтийн тээвэр	6	Бусад	98	Галт тэрэг	6	Үгүй	2	
Морь	7	Тодорхойгүй	99	Хөдөлгөөнгүй зүйл	7			
Галт тэрэг	8			Мөргөлдөөгүй /онхолдох/	8	<b>B6 Зам тээврийн осолд өртөгсдийн тоо</b>		
Онгоц	9			Тодорхойгүй	99	1	2	3
Бусад	98					4-с дээш		
Тодорхойгүй	99							


## 4.1 2019 ОНД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТААР БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ

Зам тээврийн ослын улмаас жил бүр 17000–21000 хүн гэмтэж, бэртэж байгаа нь осол гэмтлийн шинэ тохиолдлын 14-15%-ийг эзэлж 3-р байрт ордог. Монгол улсын 10000 хүн тутмын 56-65 нь зам тээврийн ослын улмаас эмнэлэгт хандсан ба жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна.

### Зам тээврийн ослын улмаас эмнэлэгт хандсан үзүүлэлт




### Зам тээврийн ослын шинэ тохиолдол, 10000 хүн амд



Зам тээврийн ослын нийт тохиолдлын 62.6% нь эрэгтэй, 37.4% нь эмэгтэй байна. Мөн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.3 дахин их зам тээврийн осолд өртөх эрсдэлтэй ба гэмтсэн 10 хүн тутмын 6 нь эрэгтэйчүүд байна.


Өөрөөр хэлвэл Монгол улсын 10000 эрэгтэй тутамд 70-83 эрэгтэй, 10000 эмэгтэй тутамд 41-47 эмэгтэй зам тээврийн ослын улмаас гэмтэж, бэртэж байна.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, хүйсээр 10000 хүн амд




2019 онд зам тээврийн ослын шалтгаант нийт тохиолдлыг насны бүлэг хүйсээр авч үзвэл 25-29 насны эрэгтэйд хамгийн их, 30-34 насны эмэгтэйд их тохиолдлыг эзэлж байгаа бол 65-аас дээш насанд хамгийн бага байна.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, насны бүлэг, хүйсээр бодит тоо



Зам тээврийн ослын улмаас гэмтсэн нийт тохиолдлыг насны бүлэгээр авч үзэхэд 20-24 насанд хамгийн өндөр байгаа бол 0-4 насанд хамгийн бага байна.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, насны бүлгээр 10 000 хүн амд



2019 онд зам тээврийн ослын шалтгаанаар гэмтсэн нийт тохиолдолын 53% нь дунд боловсролтой 28% нь ажилгүй иргэд байна.

**Зам тээврийн ослын шалтгаанаар гэмтсэн нийт хүмүүсийн боловсрол, ажил эрхлэлтийн байдал**

Боловсрол	Албан тушаал	Ажилчин	Албан хаагч	Малчин	Ажилгүй	Бусад	%	
Бага	Боловсролд эзлэх хувь	1.5	0.2	18.5	7.5	15.7	12.3%	
	Албан тушаалд эзлэх хувь	1.5	0.2	18.5	3.3	31.4		
Дунд	Боловсролд эзлэх хувь	16.6	1.1	17.7	39.7	6.3	53.3%	
	Албан тушаалд эзлэх хувь	74.2	7	77.2	76.1	54.4		
Мэргэжил техникийн	Боловсролд эзлэх хувь	32	11.5	5.2	27.1	7.9	3.0%	
	Албан тушаалд эзлэх хувь	8.1	4.2	1.3	3	3.9		
Дээд	Боловсролд эзлэх хувь	12	47.6	0.6	29.3	2.4	15.4%	
	Албан тушаалд эзлэх хувь	15.5	88.5	0.7	16.2	6		
Боловсролгүй	Боловсролд эзлэх хувь	0.4	0	1.8	2.5	1.7	16.0%	
	Албан тушаалд эзлэх хувь	0.6	0	2.3	1.4	4.4		
		<b>%</b>	<b>11.9%</b>	<b>8.3%</b>	<b>12.2%</b>	<b>27.8%</b>	<b>6.2%</b>	<b>100.0</b>

2019 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант нийт тохиолдлыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь авч үзвэл суудлын машинаар зорчигч үед зам тээврийн осолд өртөх, мотоциклын осол, явган зорчих үед осолд өртсөн тохиолдол өндөр хувийг эзэлж байна.



Зам тээврийн ослын шалтгаант 10 000 эрэгтэй тутамд суудлын автомашинаар зорчих болон мотоциклтэй зорчих үеийн ослын түвшин өндөр байгаа бол 10 000 эмэгтэй тутамд мөн адил суудлын автомашинаар зорчих болон явган зорчих үед зам тээврийн осолд өртөх тохиолдол өндөр байна.

**Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл,  
тээврийн хэрэгслийн төрлөөр 10000 хүн амд**




Насны бүлэг бүрт тээврийн хэрэгслийн төрөл статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. 5 хүртэлх болон 20-64 насанд суудлын машинд явж байх үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол хамгийн их бүртгэгдсэн байгаа бол 5-9, 10-19, 65-аас дээш насанд явган явж байх үедээ тээврийн хэрэгсэлд мөргүүлж гэмтсэн тохиолдол тэргүүлэх шалтгаан болж байна. Ердийн хөсөг буюу морь, тэмээнээс унаж гэмтсэн тохиолдол 10-14 насанд 1-р байр, 5-9 насанд 2-р байр, 65-аас насанд 3-р байр, 15-64 насанд 4-рт байна. 20 хүртэлх насанд унадаг дугуйтай явж байх үедээ зам тээврийн осолд өртсөн тохиолдол, 55-аас дээш насанд нийтийн тээврийн хэрэгсэл дотор явж байх үедээ гэмтсэн тохиолдол цөөнгүй бүртгэгдсэн байна.

**Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл, насны бүлэг бүрт тээврийн хэрэгслийн төрлөөр. Хүснэгт 10.**

Насны бүлэг	Тээврийн хэрэгслийн төрөл				
	I	II	III	IV	V
0-4	V40-V49 48.3%	V00-V09 24.7%	V81-V89 8.8%	V20-V39 6.7%	V10-V19 4.7%
5-9	V00-V09 36%	V80 20.9%	V40-V49 19.8%	V10-V19 11.3%	V20-V39 5.1%
10-14	V80 29%	V00-V09 27.1%	V10-V19 15.5%	V40-V49 11.8%	V20-V39 10.2%
15-19	V00-V09 27.4%	V40-V49 23.1%	V20-V39 20.1%	V80 14.7%	V10-V19 7.5%
20-24	V40-V49 39.6%	V00-V09 21.7%	V20-V39 20.2%	V80 8.2%	V81-V89 4.1%
25-29	V40-V49 41.5%	V20-V39 20.9%	V00-V09 20.7%	V80 6.6%	V81-V89 4.4%
30-34	V40-V49 38.5%	V20-V39 22.7%	V00-V09 21.3%	V80 6.9%	V81-V89 4.5%
35-39	V40-V49 34.4%	V20-V39 25%	V00-V09 19.8%	V80 10.1%	V50-V69 3.6%
40-44	V40-V49 32.5%	V20-V39 24.2%	V00-V09 23.1%	V80 10.2%	V81-V89 3.5%
45-49	V40-V49 30.1%	V20-V39 24.3%	V00-V09 23.4%	V80 11.5%	V81-V89 3.6%
50-54	V40-V49 29.7%	V00-V09 24.5%	V20-V39 22.9%	V80 11.2%	V81-V89 4.1%
55-59	V40-V49 29.5%	V00-V09 25.4%	V20-V39 18.3%	V80 14.3%	V70-V79 4.6%
60-64	V40-V49 28%	V00-V09 27.4%	V20-V39 17%	V80 15.1%	V70-V79 5.5%
65-69	V00-V09 28.8%	V40-V49 26.7%	V80 15.5%	V20-V39 14%	V70-V79 7.7%
70+	V00-V09 36.1%	V40-V49 28.4%	V80 13.6%	V20-V39 10.2%	V70-V79 6%




Зам тээврийн ослын шалтгаанаар гэмтсэн иргэдийн 39.9% нь толгойн гэмтэл, 10.17% нь өвдөг ба шилбэний гэмтэл, 6.63% нь хэвлийн гэмтэл, 6.51% нь мөр бугалгын гэмтэл авсан байна.



Зам тээврийн ослын улмаас гэмтсэн эрэгтэйчүүдэд цээжний гэмтэл тэргүүлж байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд биеийн олон хэсгийн гэмтэл болон тархины гэмтэл тэргүүлж байна.

### Зам тээврийн улмаас гэмтсэн иргэдийн онош, хүйсээр, 2019 оны дундаж хувь




Явганаар болон автобусаар явж байхдаа зам тээврийн осолд орсон тохиолдлуудад тархины гэмтэл, суудлын болон ачааны машинтай явж байхдаа осолд орсон тохиолдлуудад биеийн олон хэсгийн гэмтэл, унадаг дугуй, мотоцикл, ердийн хөсөгтэй явж байгаад осолд орсон тохиолдлуудад цээжний гэмтэл тэргүүлж байна.

### Зам тээврийн ослоор эмнэлэгт хандсан иргэдийн онош, тээврийн хэрэгслийн төрлөөр. Хүснэгт 11.

Исэлт	V00-V09	V10-V19	V20-V39	V40-V49	V50-V69	V70-V79	V80						
Тархины/г	37.9%	Цэвэрлэгдсэн/г	30.8%	Цэвэрлэгдсэн/г	33.7%	Биеийн о/х/г	38.6%	Биеийн о/х/г	27.2%	Тархины/г	33.5%	Цэвэрлэгдсэн/г	44.7%
Биеийн о/х/г	22.1%	Тархины/г	26.2%	Биеийн о/х/г	23%	Тархины/г	20.2%	Цэвэрлэгдсэн/г	23.7%	Биеийн о/х/г	26%	Тархины/г	18.6%
Цэвэрлэгдсэн/г	16.1%	Хүзүүний/г	21.4%	Тархины/г	17.9%	Цэвэрлэгдсэн/г	14.7%	Тархины/г	18.4%	Цэвэрлэгдсэн/г	16.5%	Биеийн о/х/г	17.2%
Шагай, тавхайн/г	11.6%	Биеийн о/х/г	10.6%	Хүзүүний/г	13.5%	Шагай, тавхайн/г	10.2%	Хүзүүний/г	12.5%	Шагай, тавхайн/г	9.5%	Хүзүүний/г	8.1%
Хүзүүний/г	7.1%	Шагай, тавхайн/г	5.9%	Хэвлийн/г	4.2%	Хүзүүний/г	8.9%	Шагай, тавхайн/г	10.3%	Хүзүүний/г	8.8%	Хэвлийн/г	4.7%


Зам тээврийн осолд өртөх үедээ жолоо барьж явсан байдал эрэгтэйчүүдэд, зорчигчоор явж байсан байдал эмэгтэйчүүдэд их байна. Нийт бүртгэгдсэн тохиолдлын 29.3% нь жолооч, 28.7% нь зорчигч, 25% нь явган зорчигч байна.

### Зам тээврийн осолд орох үедээ замын хөдөлгөөнд оролцсон байдал, хүйсээр




Эрэгтэйчүүд ямар нэгэн тээврийн хэрэгсэлтэй явж байгаад онхолдсон осолд их өртсөн бол эмэгтэйчүүд суудлын машинтай мөргөлдсөн осолд их өртжээ.

### Зам тээврийн осолд орох үед мөргөлдсөн зүйл, хүйсээр




Суудлын машинаар зорчигч зам тээврийн осолд орж гэмтсэн тохиолдолын 69.57 %, ачааны машинтай явж байсан тохиолдлын 56.38% нь осолд орох үедээ хамгаалах бүс хэрэглээгүй байна.

### Зам тээврийн осолд өртсөн иргэдийн суудлын бүс хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрлөөр




Зам тээврийн ослын шалтгаанаар бэртэж гэмтсэн нийт хүмүүсийн 10-11% нь осолд орох үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан гэсэн өгүүлэмжтэй байна.

**Зам тээврийн осолд өртсөн иргэдийн согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, 10000 хүн амд**



Зам тээврийн ослын шалтгаанаар гэмтсэн байдал аль ч хүйсэнд зуны улиралд их, өвлийн улиралд бага бүртгэгджээ. Бүртгэгдсэн нийт тохиолдлын 34.91% нь зөвхөн зуны улиралд бүртгэгдсэн байна.

**Зам тээврийн осол бүртгэгдсэн улирал**




Ачааны машин болон автобусаар зорчигч гэмтсэн тохиолдол Баасан гарагт, бусад тээврийн хэрэгслийн осол Даваа гарагт их бүртгэгджээ.

**Зам тээврийн осол бүртгэгдсэн гараг, тээврийн хэрэгслийн төрлөөр. Хүснэгт 12.**

Тээврийн хэрэгслийн төрөл	Явган зорчигчийн зам тээврийн осол	Дугуйтай зорчигчийн зам тээврийн осол	Мотоциклын осолд орох	Суудлын машинаар зорчигчийн зам тээврийн осол	Ачааны машинаар зорчигчийн зам тээврийн осол	Автобусаар зорчигчийн зам тээврийн осол	Ердийн хөстгийн осол
1	Даваа 16.2%	Даваа 15.3%	Даваа 16.9%	Даваа 15.6%	Баасан 15.6%	Баасан 20%	Даваа 16.5%
2	Баасан 15.7%	Бямба 15.3%	Мягмар 14.8%	Баасан 15.5%	Бямба 15.6%	Даваа 16%	Мягмар 14.7%
3	Мягмар 15.4%	Баасан 14.1%	Лхагва 14.8%	Ням 14.9%	Пүрэв 15.3%	Бямба 15.8%	Баасан 14.5%
4	Лхагва 14.9%	Мягмар 13.9%	Пүрэв 14.7%	Бямба 14.5%	Даваа 13.8%	Лхагва 14.4%	Пүрэв 14.3%
5	Пүрэв 14.3%	Лхагва 13.9%	Баасан 14.4%	Пүрэв 13.5%	Ням 13.7%	Мягмар 13.3%	Ням 13.9%
6	Бямба 12.2%	Ням 13.8%	Ням 12.3%	Лхагва 13.1%	Лхагва 13.3%	Пүрэв 11.4%	Лхагва 13.6%
7	Ням 11.2%	Пүрэв 13.7%	Бямба 12.1%	Мягмар 12.9%	Мягмар 12.8%	Ням 9.1%	Бямба 12.5%


2019 онд зам тээврийн ослын шалтгаант өвчлөл Төв аймагт хамгийн их бүртгэгдсэн ба тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох зам тээврийн ослын түвшинээр мөн адил хамгийн их хувийг эзэлсэн байна. Зам тээврийн ослын шалтгаант өвчлөлөөр тэргүүлэх удаах аймгуудад Архангай, Дорноговь орж байгаа бол Говьсүмбэр, Дундговь аймгуудад 10000 хүн амд ногдох тохиолдолын түвшин өндөр байна.



## 4.2 2019 ОНД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТААР БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ

Сүүлийн 4 жилийн хугацаанд нийт 2113 хүн зам тээврийн ослын улмаас нас барсан байна /тухайн онд нас баралтын гэрчилгээ авсан хүний тоогоор/. Зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан хүний тоо өмнөх онуудтай өссөн ба 10000 хүн амд ногдох түвшин хэвээр байна.


Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10000 хүн амд



2019 онд зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 71.33% нь орон нутагт 28.67% нь нийслэлд бүртгэгдсэн байна. Нийслэлийн 10000 хүн тутамд 1.2-1.8 хүн, орон нутгийн 10000 хүн тутамд 1.6-2 хүн зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан байна.

2019 онд зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн 77.6%-ийг эрэгтэйчүүд, 22.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, харъяаллаар




Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, хүйсээр.




Улсын хэмжээний 10.000 эрэгтэй тутамд 2.4–2.7 эрэгтэй, 10.000 эмэгтэй тутамд 0.8–0.9 эмэгтэй зам тээврийн ослын улмаас нас барсан байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, хүйсээр–10000 хүн амд**




2019 онд зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин 50–59 насанд хамгийн өндөр байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны бүлгээр–10000 хүн амд**



Зам тээврийн ослын улмаас амь эрсэдсэн нийт тохиолдлыг тээврийн хэрэгслийн төрлөөр нь ангилвал 1-рт суудлын машинаар зорчигчийн осол /34%/, 2-рт явган зорчигч зам тээврийн осолд орох /27%/, 3-рт мотоциклын осол /27%/, 4-рт ачааны машинаар зорчигчийн осол /5% 5-рт ердийн хөсгийн осол /4%/ эзэлж байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, тээврийн хэрэгслийн төрлөөр**



2018 оныг 2019 онтой харьцуулахад эрэгтэйчүүдийн хувьд 10000 эрэгтэйд ногдох явган зорчигчийн осол бага зэрэг буурч, мотоциклтэй зорчих үеийн осол ихэссэн үзүүлэлттэй байна. Харин 10000 эмэгтэйд ногдох осол бүх тээврийн хэрэгслийн төрөлд буурсан үзүүлэлттэй байна.

**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, тээврийн хэрэгслийн төрөл, хүйсээр, 10000 хүн амд.**

Осол гэмтлийн шалтгаан (ӨОУА-10 дагуу)		2018		2019	
		эр	эм	эр	эм
V01-V09	Явган зорчигчийн зам тээврийн осол	0.72	0.52	0.61	0.32
V10-V19	Дугуйтай зорчигчийн зам тээврийн осол	0.01	0.02	0.01	0.00
V20-V39	Мотоциклтэй зорчигчийн зам тээврийн осол	0.58	0.57	0.92	0.03
V40-V49	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	0.78	0.98	0.80	0.39
V50-V69	Ачааны машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	0.15	0.09	0.14	0.02
V70-V79	Автобус дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх	0.00	0.01	0.07	0.01
V80.0-V80.9	Ердийн хөсгийн осол	0.16	0.16	0.14	0.00
V81-V86	Бусад	0.08	0.05	0.01	0.01
V87-V88	Тээврийн хэрэгслийн төрөл тодорхойгүй	0.01	0.01	0.01	0.01

30-34 насны хувьд мотоциклын ослын шалтгаант, бусад насны бүлэгт суудлын машинаар зорчих үед зам тээврийн осолд орж нас барсан тохиолдол их байна. Ялангуяа 10-14, 60-64 насныханы дунд тохиолдолсон зам тээврийн ослын шалтгаант 2 нас баралт тутмын 1 нь суудлын машинтай зорчиж байжээ.


**Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, насны бүлэг бүрт тээврийн хэрэгслийн төрлөөр.**

Насны бүлэг	Тээврийн хэрэгслийн төрөл				
	I	II	III	IV	V
0-4	V40-V49 /41.9%/	V00-V09 26.9%	V20-V39 23.7%	V80 5.4%	V50-V69 2.2%
5-9	V40-V49 32.0%	V20-V39 22.0%	V00-V09 20.0%	V80 10.0%	V50-V69 8%
10-14	V40-V49 50%	V20-V39 23.3%	V00-V09 16.7%	V50-V69 6.7%	V10-V19 3.3%
15-19	V40-V49 31.9%	V00-V09 26.4%	V20-V39 22.2%	V80 8.3%	V50-V69 8.3%
20-24	V40-V49 45.6%	V00-V09 24.6%	V20-V39 19.3%	V50-V69 4.4%	V80 2.6%
25-29	V40-V49 35.6%	V00-V09 26.5%	V20-V39 22%	V80 6.1%	V50-V69 5.3%
30-34	V20-V39 30.9%	V40-V49 28.7%	V00-V09 25.4%	V80 7.7%	V50-V69 3.9%
35-39	V40-V49 35.5%	V00-V09 27.6%	V20-V39 23%	V80 5.9%	V50-V69 3.3%
40-44	V40-V49 38.9%	V00-V09 28%	V20-V39 25.5%	V80 4.5%	V50-V69 2.6%
45-49	V40-V49 29.5%	V00-V09 28.5%	V20-V39 22.3%	V50-V69 7.8%	V80 6.7%
50-54	V40-V49 40.4%	V00-V09 21.2%	V20-V39 19.2%	V80 7.9%	V50-V69 5.3%
55-59	V40-V49 37.9%	V00-V09 26.2%	V20-V39 20.4%	V80 8.7%	V50-V69 1.9%
60-64	V40-V49 57.1%	V20-V39 19.1%	V00-V09 15.9%	V50-V69 4.8%	V80 1.6%
65-69	V40-V49 42.9%	V00-V09 35.7%	V20-V39 17.9%	V50-V69 3.6%	
70+	V40-V49 41.7%	V00-V09 27.8%	V20-V39 13.9%	V80 13.9%	




Зам тээврийн ослын улмаас нас барсан хүмүүсийн 41.1% нь ямар нэгэн зүйлтэй мөргөлдөөгүй, тээврийн хэрэгсэл нь онхолдсоноос болж нас баржээ.

### Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, ослын төрөл, хүйсээр




Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 34.6% нь зун, 26.9% нь намар, 21.6% нь хавар, 16.9% нь өвөл бүртгэгдсэн байна. Хүйсийн хувьд ижил байна.

### Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, улирлаар




Зам тээврийн ослын шалтгаант нас баралт 7 сард хамгийн их, 1 сард хамгийн бага байжээ.

### Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, нас барсан сараар



2019 онд зам тээврийн ослоор нас барсан тохиолдол Архангай, Өмнөговь, Төв, Орхон аймгуудад хамгийн их бүртгэгдсэн бол тухайн газар нутгийн 10000 хүн амд ногдох зам тээврийн ослын нас баралтын түвшин Баянхонгор, Хөвсгөл аймгуудад өндөр байна.

### Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, аймгаар-10000 хүн амд



#### 4.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

- Монгол улсад зам тээврийн ослын шалтгаант өвчлөл жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд осол гэмтлийн шинэ тохиолдлын 3-рт орж байна. 2019 оныг 2017 онтой харьцуулахад 10000 хүн ам тутамд ногдох тохиолдлын түвшин 8.6 промиллээр өссөн үзүүлэлттэй байна.
- 2019 оны зам тээврийн ослын нийт тохиолдлын 69 хувь нь нийслэлд, 31 хувь нь орон нутагт бүртгэгдсэн.
- Зам тээврийн ослын улмаас бэртэж гэмтсэн 10 хүн тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байгаа бөгөөд 20-24 насанд тохиолдлын түвшин өндөр байна.
- 2019 онд зам тээврийн ослын шалтгаанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан нийт иргэдийн 34.8 хувь нь суудлын автомашинаар зорчих үедээ зам тээврийн осолд өртөж, эдгээр тохиолдлын 56.4 хувь нь суудлын хамгаалах бүс хэрэглээгүй байжээ.
- Эрэгтэйчүүдийн хувьд суудлын автомашин болон мотоцикльтой зорчих үед зам тээврийн осолд өртөх тохиолдлын түвшин өндөр байгаа бол эмэгтэйчүүдэд суудлын автомашинаар зорчих болон явган үед осолд өртөх тохиолдол өндөр байна.
- Зам тээврийн ослын улмаас бэртэж гэмтсэн нийт иргэдэд толгойн гэмтэл, өвдөг шилбэний гэмтэл, хэвлийн болон мөр бугалгын тэргүүлж байгаа бол эрэгтэйчүүд ихэвчлэн цээжний гэмтэл, эмэгтэйчүүд биеийн олон хэсгийн гэмтэл авах тохиолдол өндөр байна.
- Зам тээврийн осолд өртөх үедээ жолоо барьж явсан тохиолдол эрэгтэйчүүдэд, тээврийн хэрэгслээр зорчиж байсан тохиолдол эмэгтэйчүүдэд их, бүртгэгдсэн тохиолдлын 29.3 хувь нь ямар нэг тээврийн хэрэгсэл жолоодож явсанаас харахад жолооч замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжоо дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.
- 2019 онд зам тээврийн осолд өртсөн нийт иргэдийн 11.3 хувь нь согтууруулах ундаа хэрэглэсэн нь урд онтой харьцуулахад 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл зуны (34.97%) улиралд их байна.

- 2019 онд зам тээврийн ослын шалтгаант өвчлөл Дорноговь аймагт хамгийн их бүртгэгдсэн бол 10 000 хүн амд ногдох зам тээврийн ослын тохиолдлын түвшин Говьсүмбэр аймагт өндөр байна.

#### **Зам тээврийн ослын шалтгаант нас баралт**

- Монгол улсад зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан хүний тоо, өмнөх онуудтай харьцуулахад өссөн бол 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин хэвээр байна.
- 2019 онд зам тээврийн осолд өртөж нас барсан иргэдийн 77.6 хувь нь эрэгтэйчүүд эзэлсэнийг урд онтой харьцуулахад 7.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 22.4 хувь нь эмэгтэйчүүд, нас баралтын түвшин 50-59 насанд өндөр байна.
- Зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 34.2 хувийг суудлын машинаар зорчигчийн осол, 27.4 хувийг мотоциклоор зоригчийн осол, 26.8 хувийг явган зорчигчийн осол эзэлж байна.
- Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 41.1 хувийг ямар нэг зүйлтэй мөргөлдөөгүй буюу тээврийн хэрэгсэл нь онхолдсоноос болсон нас баралт эзэлж байна.
- Зам тээврийн ослын шалтгаант нас баралт зуны улиралд (34.6%), 7 сард (13.6%) хамгийн их тохиожээ.
- 2019 онд зам тээврийн ослоор нас барсан тохиолдол Дорноговь, Баянхонгор аймгуудад хамгийн их бүртгэгдсэн байна.

## ТАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨРИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

Автотээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Автотээврийн салбарын үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ” гэж заасан.

Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 –т Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д Автотээврийн тухай хууль зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэхээр заасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т тээврийн хэрэгслийн ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчлийн хяналтыг авто тээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэхээр заасан.

Автотээврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу автотээврийн салбарт захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч нь автотээврийн үйлчилгээнд мөрдөж байгаа Автотээврийн тухай, Зөрчлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд, салбарын 85 стандарт, 1 дүрэм, 6 журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах үүрэгтэйгээр 2019 онд улсын хэмжээнд 110 автотээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид захиргааны хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Автотээврийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т зааснаар Автотээврийн хяналт, шалгалтын мэргэжлийн төв, орон нутгийн хяналтын байгууллагын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 заасны дагуу улсын ерөнхий байцаагч олгодог.

Улсын хэмжээнд 21 аймгаас 20 аймгийн МХГ, хилийн Мэргэжлийн хяналтын албанд-2, Нийслэлийн МХГ-т 2, МХЕГ-т 1 орон тоотойгоор улсын хэмжээнд нийт 25 улсын байцаагч ажиллав.

Улсын байцаагчид төлөвлөгөөт хяналт шалгалт 264, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 77, зөвлөн туслах үйлчилгээ 157-ыг хийсэн байна. Тайлант хугацаанд 2245 заалттай 264 албан шаардлага, 109 заалттай 42 дүгнэлт, 61 заалттай 18 актыг гаргаж, зөрчил гаргасан эзэн холбогдогчдын 225 зөрчлийн хэргийг прокурорт бүртгүүлж, 112.520.0 мян.төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ 100% барагдуулсан байна.

## Автотээврийн салбарт төрийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоо



Авто тээврийн хяналтын улсын байцаагчид 2019 онд 477 албан бичиг, хүсэлт, 21 өргөдлийг хүлээн авч, 254 хариуг өгсөнөөс бодлогын чанартай санал, авах арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаар яам, агентлаг, төрийн захиргааны байгууллагууд болон Засаг дарга, орон нутгийн захиргааны байгууллагуудад холбогдох саналыг хүргүүлэхээс гадна тодорхой чиглэлээр зөвлөмж, сэрэмжүүлгийг боловсруулан өгч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр холбогдох мэдээллийг олон нийтэд өгч, Автотээврийн тухай хуулийг сурталчиллаа.

### 5.1 АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

Авто замын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх “Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг авто замыг өмчлөгч, эзэмшигч, зам хариуцагч байгууллага, Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу захиалагч Зам, тээврийн хөгжлийн яам, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, хариуцагч байгууллагууд хяналтыг эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлж байна.

Авто замын хяналтын чиглэлээр 2019 онд 21 аймгаас орон нутгийн МХГ-т 15, нийслэлийн МХГ-т 3, МХЕГ-т 2 орон тоотойгоор улсын хэмжээнд нийт 20 улсын байцаагч тухайн орон нутагтаа Авто замын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, норм дүрэм, журам, стандартын шаардлагын хэрэгжилт, авто зам, замын байгууламж, гүүрийн ашиглалт, барилга угсралтын ажилд хяналт шалгалт гүйцэтгэх, сурталчлах ажлыг гүйцэтгэж ажиллав.

Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагчид нийт 730 шалгалт, үүнээс төлөвлөгөөт 204, төлөвлөгөөт бус 380, гүйцэтгэлийн 145 шалгалтыг, 134 зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, урьдчилан сэргийлэх 79 шалгалтыг, 2 тандалт судалгааг хийж, нийт 141 зөвлөмж өгч, давхардсан

тоогоор 1662 зөрчлийг илрүүлсэнээс 79.38 % буюу 1251 арилгуулсан байна. Улсын байцаагчийн 348 заалттай 118 дүгнэлт боловсруулж, улсын байцаагчийн үйл ажиллагааг түр зогсоох 6, сэргээх 3 буюу нийт 9 актыг тогтоож, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 708 заалттай 134 албан шаардлага өгч, 573 заалттай 118 нь биелсэн бөгөөд хэрэгжилт 81.91 %-тай, 26 заалттай 16 албан даалгавар өгч, 16 заалт нь биелсэн бөгөөд хэрэгжилт 77.25 %-тай байна. Түүнчлэн 65.450,0 мян төгрөгийн торгууль ногдуулан 78.1 %-ийг нь барагдуулж, 3589.21 мян төгрөгийн нөхөн төлбөрийн арга хэмжээг авсан байна.

Авто замын хяналтын улсын байцаагчид 794 албан бичиг, хүсэлт, 93 өргөдлийг хүлээн авч, бодлогын чанартай санал, авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаар яам, агентлаг, төрийн захиргааны байгууллага, Засаг дарга, орон нутгийн захиргааны байгууллагуудад холбогдох саналыг өгсөн байна.

Хууль тогтоомжийг суртачилах, эрсдлээс урьдчилэн сэргийлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр нэвтрүүлэг, нийтлэл, ярилцлага, сэрэмжлүүлэг бэлтгэж, 12 ном, гарын авлага боловсруулан боловсруулан олон нийтийн хүртээл болгоод байна.

Авто замын хяналт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангуулах чиглэлээр хийгдсэн үр бүтээлтэй дараах ажлууд байна. Үүнд:

Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 автозамын түр зурагт хяналт тавьж холбогдох норм дүрмийн дагуу хайрган хучилттай байхаар төсөллөх, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай дүгнэлтийг захиалагч талд хүргүүлж дүгнэлтийн дагуу нийт 204 км түр хайрган хучилт хийхээр шийдвэрлэж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэв.

БОАЖЯ, ЗТХЯ-ны хүсэлтийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замын ашиглалт, засвар арчлалтын ажил, нөхцөл байдалд БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ ЗТХТ, АТҮТ-ийн ажлын хэсэг үнэлэлт, дүгнэлт гаргаж, зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагыг “Эрдэнэс Монгол” ХХК, “Гашуун сухайт авто зам” ХХК-д өгч, замын нөхцөл байдлыг сайжруулсан.

МХЕГ-ын удирдамжийн дагуу Сүхбаатар, Дорнод аймгийн уул уурхайн авто замын ашиглалтын байдалд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага, түр хугацаагаар зогсоох акт, дүгнэлт, зөвлөмж үйлдэж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 3.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, Сүхбаатар, Дорнод аймгийн Засаг дарга, ЗДТГ, ЗТХЯ, ЗТХТ-д албан бичгийг хүргүүлэн ажиллаж, цаашид уул уурхайн авто замын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажилд улсын ахлах байцаагчийн гаргасан дүгнэлт, албан шаардлагын дагуу 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн хатуу хучилттай болгох хүртэлх арчлалтын ажлыг гүйцэтгүүлэв.

## ЗУРГАА. ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

### 6.1 2019 ОНД БАЙГУУЛСАН НИЙТ ГЭРЭЭНИЙ ТОО, БОЛОН ЦУЦЛАЛТ

2019 онд гишүүн 15 даатгалын компаниуд 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, нийт 700,617 даатгалын гэрээ байгуулж, 38,395,718,909 төгрөгийн хураамжийн орлого олох боломж бүрдсэн байна. Нийт 26176 гэрээ цуцлагдаж цуцлагдсан гэрээний нийт үнийн дүн 1,824,113,864 төгрөг байна.

#### Жолоочийн даатгалын гэрээ /Тээврийн хэрэгслийн ангиллаар/

№	Зүйл	Даатгалын гэрээний тоо	
		2018	2019
1	А	13,754	12,022
2	В	555,329	577,646
3	С	50,414	47,841
4	Д	14,947	14,287
5	М	5,263	5,484
6	Бусад	1547	17,161
<b>Нийт</b>		<b>641,254</b>	<b>674,441</b>

/Бусад ангилалд мэргэшсэн жолоочийн гэрээ, хураамжийн дүн хамаарна/

#### Нийт гэрээний тоо, /Даатгалын компаниар

№	Нэрс	Хувь хүн	Хуулийн этгээд	Мэргэшсэн жолооч	Дамжин өнгөрөх	Нийт
		Гэрээний тоо	Гэрээний тоо	Гэрээний тоо	Гэрээний тоо	Гэрээний тоо
1	Соёмбо даатгал	6,928	2,531	325	1	9,785
2	Миг даатгал	77,930	30,826	1,543	110	110,409
3	Мөнх даатгал	1,591	2,052	283	2,413	6,339
4	Монгол даатгал	96,327	30,758	3,797	1,226	132,108
5	Практикал даатгал	34,995	11,815	1,326	192	48,328
6	Амар даатгал	1,639	1,592	65	441	3,737
7	Улаанбаатар хотын даатгал	157	91	1	0	249
8	Номин даатгал	38,301	11,386	1,784	26	51,497
9	Тэнгэр даатгал	42,499	14,869	1,389	58	58,815
10	Бодь даатгал	88,342	16,244	922	193	105,701
11	Ган зам даатгал	67	420	95	0	582
12	Монре даатгал	31,420	23,001	583	1	55,005
13	Ард даатгал	41,142	13,333	1,351	33	55,859
14	Мандал даатгал	2,616	3,355	99	2	6,072
15	Хаан даатгал	38,445	14,910	2,774	2	56,131
<b>Нийт</b>		<b>502,399</b>	<b>177,183</b>	<b>16,337</b>	<b>4,698</b>	<b>700,617</b>

/Цуцлагдсан гэрээг оруулж тооцсон/



## 6.2 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Албан журмын даатгагчдын холбооны даатгалын сангаас болон гишүүн 15 даатгалын компаниас 2019 онд нийт 33,286 жолоочийн даатгалын тохиолдолд 18,866,569,795 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг дараах хүснэгтээс харна уу.


### Нөхөн төлбөр өссөн дүнгээр, даатгалын компани тус бүр /төгрөг/

№	Даатгалын компани нэр	Н.Т тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Соёмбо даатгал	250	163,323,545
2	Миг даатгал	5,157	2,995,676,780
3	Мөнх даатгал	101	78,611,660
4	Монгол даатгал	6,204	3,628,342,099
5	Практикал даатгал	1,879	1,148,561,519
6	Амар даатгал	169	100,712,012
7	Улаанбаатар хотын даатгал	7	2,079,200
8	Номин даатгал	2,316	1,364,792,590
9	Тэнгэр даатгал	2,675	1,513,610,149
10	Бодь даатгал	5,352	2,646,890,092
11	Ган зам даатгал	22	18,600,700
12	Монре даатгал	3,156	1,728,732,350
13	Ард даатгал	2,140	1,286,278,247
14	Мандал даатгал	548	274,617,356
15	Хаан даатгал	3,309	1,911,741,496
16	АЖДХолбоо	1	4,000,000
<b>НИЙТ</b>		<b>33,286</b>	<b>18,866,569,795</b>

### Жолоочийн даатгалын хүчинтэй гэрээний хураамжийн дүн /оноор/

2019 оны албан журмын даатгалын хүчинтэй гэрээний хураамжийн орлогыг 2018 оны хүчинтэй гэрээний хураамжийн орлоготой харьцуулахад 15,6%-иар буюу 4,93 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Албан журмын даатгалын хүчинтэй гэрээний хураамжийн орлого



# ДОЛОО: ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ ДЭЛХИЙН ЗОРИЛТ-2030

## Зорилт 1 /ногоон/

2020 он гэхэд бүх улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон талт үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг боловсруулах

## Зорилт 2 /ногоон/

2030 гэхэд бүх улс орнууд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой НҮБ-ын нэг буюу хэд хэдэн гол хууль эрх зүйн бичиг баримтыг хүлээн зөвшөөрч нэгдэнэ.

## Зорилт 3 /шар/

2030 он гэхэд бүх шинэ замууд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, бүх зам хэрэглэгчид нийцсэн техникийн стандартын дагуу баригдсан байх ба гурван од, түүнээс ч илүү сайн үнэлэгдэнэ.

## Зорилт 4 /шар/

2030 он гэхэд одоогийн ашиглагдаж буй авто зам дээрхи аяллын 75 хувиас илүү нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, бүх авто зам хэрэглэгчид нийцсэн техникийн стандартын хангасан авто замаар зорчино.

## Зорилт 5 /ногоон/

2030 он гэхэд 100 хувь шинэ автомашин /үйлдвэрлэсэн, худалдагдсан, импортолсон/ болон ашиглагдсан автомашинууд нь НҮБ-ын техникийн зохицуулалтууд, Дэлхийн техникийн зохицуулалт болон эдгээр бичиг баримттай нийцэхүйц үндэсний шаардлагууд зэрэг өндөр чанарын аюулгүй байдлын техникийн стандартуудад нийцсэн байна.

## Зорилт 6 /ягаан/

2030 он гэхэд тогтоосон хурдны хязгаараас илүү гарч хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн тоог 2 дахин бууруулах ба хурдтай холбоотой гэмтэл, нас баралтыг бууруулна.

## Зорилт 7 /ягаан/

2030 он гэхэд мотоциклоор зорчигчдын стандартын хамгаалалтын малгайн зөв зохистой хэрэглээг 100 хувьд хүргэнэ.

## Зорилт 8 /ягаан/

2030 он гэхэд тээврийн хэрэгслийн жолоочийн аюулгүй бүс болон тээврийн хэрэгслээр зорчигч хүүхдийн хамгаалах системийн хэрэглээг 100 хувьд хүргэнэ.

### Зорилт 9 /ягаан/

2030 он гэхэд жолооч согтууруулах ундаа хэрэглэсэнтэй /эсвэл сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бүтээгдэхүүнтэй холбоотойгоор үүссэн зам тээврийн ослоор нас барагсад ба гэмтэгсэдийн тоог 2 дахин бууруулна.

### Зорилт 10 /ягаан/

2030 он гэхэд бүх улс орнууд тээврийн хэрэгсэл жолоодохдоо гар утас ашиглахыг хориглосон эсвэл хязгаарласан үндэсний хуультай болно.

### Зорилт 11 /ягаан/

2030 он гэхэд бүх улс орнууд мэргэжлийн жолооч нарын ажил, амралтын цагийг мөрдүүлэх зохицуулалттай болсон байх ба энэ чиглэлээр олон улсын болон бүс нутгийн зохицуулалтуудад нэгдсэн байна.

### Зорилт 12 /улбар шар/

2030 он гэхэд эмнэлэгийн анхны тусламж, үйлчилгээний нөхцөл болон зам тээврийн осол хоорондын цагийн интервалыг багасгах үндэсний зорилгуудыг бүх улс орнууд дэвшүүлэх ба энэ зорилгодоо хүрнэ.

#### Замын хөдөлгөөний аюулгүй байдлын 5 тулгуур:

**Цэнхэр өнгө** - Тулгуур 1: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент

**Шар өнгө** - Тулгуур 2: Аюулгүй авто зам ба аюулгүй хөдөлгөөн

**Ногоон өнгө** - Тулгуур 3: Аюулгүй тээврийн хэрэгсэл

**Ягаан өнгө** - Тулгуур 4: Аюулгүй авто зам хэрэглэгч

**Улбар шар өнгө** - Тулгуур 5: Ослын дараах тусламж үйлчилгээ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 128

#### ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.6, 7.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 25 дугаар хавсралт болгон 1 дүгээр, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албыг Зам, тээврийн хөгжлийн яамны батлагдсан орон тоо, төсөвт багтаан байгуулж ажиллуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 20 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын комисс, хороо, ажлын хэсэг, тэдгээрийн дарга” гэсэн жагсаалтын 24-т “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хороо, Зам, тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, Монгол Улсын Ерөнхий сайд” гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Б.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2019 оны 128 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд

Орлогч дарга - Зам, тээврийн хөгжлийн сайд

- Гишүүд:
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
  - Сангийн сайд;
  - Барилга, хот байгуулалтын сайд;
  - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд;
  - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
  - Эрүүл мэндийн сайд;
  - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч;
  - Цагдаагийн ерөнхий газрын дарга;
  - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
  - Тээврийн цагдаагийн албаны дарга;
  - Монголын Үндэсний олон нийтийн телевизийн захирал;
  - Монголын Улаан загалмай нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга;
  - Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал;
  - Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал
- Нарийн бичгийн дарга - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга.

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах үүрэг бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Үндэсний зөвлөл нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

### Хоёр. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Үндэсний зөвлөл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7.4-т заасны дагуу орон тооны бус гишүүдээс бүрдэнэ.

2.2. Үндэсний зөвлөл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7.5-д заасан орон тооны Ажлын албатай байна.

2.3. Үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга нь Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

2.4. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.5. Үндэсний зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах ба шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, эсхүл нийт гишүүдийн 50-иас дээш хувийн саналаар зарлан хуралдуулж болно.

2.6. Ээлжит хуралдааны товыг Нарийн бичгийн дарга Үндэсний зөвлөлийн даргатай зөвшилцөж тогтооно. Нарийн бичгийн дарга хуралдааны товыг тогтоосон өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанаар хэлэлцэх асуудал, холбогдох материалыг зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

2.7. Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч дарга хуралдааныг удирдаж болно.

2.8. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааны материалыг хүлээн авсан бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцож чадахгүйн

улмаас саналаа бичгээр ирүүлсэн гишүүнийг хуралдааны ирцэд оруулж тооцно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.9. Үндэсний зөвлөл нь бүрэн эрхийнхээ хүрээнд хуралдаанаас тогтоол, зөвлөмж гаргах ба тогтоол, зөвлөмжид Үндэсний зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

### **Гурав. Үндэсний зөвлөлийн бүрэн эрх**

3.1. Үндэсний зөвлөл нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7.6-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үндэсний зөвлөлөөс тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтийг хангах;

3.1.2. бодлого, хөтөлбөр боловсруулах, судалгааны ажил хийхэд эрдэмтэн, судлаачид, холбогдох мэргэжилтнийг татан оролцуулах;

3.1.3. Үндэсний зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

3.1.4. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хариуцах, хамтран ажиллах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай танилцах, тайланг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж үүрэг, чиглэл өгөх;

3.1.5. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.1.6. замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлаар хурал, зөвлөгөөн, семинар, сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

### **Дөрөв. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг**

4.1. Үндэсний зөвлөлийн дарга дараахь эрх, үүрэгтэй:

4.1.1. Үндэсний зөвлөлийн ажлыг ерөнхий удирдлагаар хангах;

4.1.2. Үндэсний зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

4.1.3. Үндэсний зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

4.1.4. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

4.2. Үндэсний зөвлөлийн гишүүн дараахь эрх, үүрэгтэй:

4.2.1. Үндэсний зөвлөлийн хуралдаанд асуудал оруулж хэлэлцүүлэх;

4.2.2. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих;

4.2.3. хариуцсан салбар, чиглэлийн дагуу Үндэсний зөвлөлд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;

4.2.4. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах.

### **Тав. Үндэсний зөвлөлийн ажлын алба**

5.1. Үндэсний зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын алба хариуцна.

5.2. Ажлын алба нь дарга, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналт хариуцсан мэргэжилтэн, эрүүл мэнд, боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй байна.

5.3. Ажлын албаны дарга, мэргэжилтэн нь төрийн захиргааны албан хаагч байна.

5.4. Ажлын алба нь дараахь эрх, үүрэгтэй:

5.4.1. хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж Үндэсний зөвлөлийн даргаар батлуулах;

5.4.2. Үндэсний зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудалтай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангах;

5.4.3. Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх;

5.4.4. Үндэсний зөвлөлийн тогтоол, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах.

### **Зургаа. Бусад**

6.1. Үндэсний зөвлөл нь ажлаа жил бүрийн II улиралд багтаан Улсын Их Хуралд тайлагнана.

6.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлагдсан төсвөөс санхүүжүүлнэ.

6.3. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой байгууллага, хувь хүний нууцад хамаарах асуудлыг задруулах, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 08 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Төлөвлөгөө, журам, зөвлөмж, загвар батлах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрдугаар зүйлийн 2.9, Үндэсний зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023 он/-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г нэгдүгээр хавсралтаар, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг гуравдугаар хавсралтаар, Үндэсний зөвлөлийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, салбар хоорондын ажлын уялдааг хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын албанд тус тус даалгасугай.

3. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаад дотоодын болон аж ахуйн нэгж, байгууллагын тусламж, зээлийн хөрөнгөөр холбогдох хуулийн хүрээнд санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Үндэсний зөвлөлийн нийт гишүүд, нийслэл, аймаг орон нутгийн салбар зөвлөл, Засаг дарга нарт даалгасугай.

4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх журам”-ыг хэрэгжүүлж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллахыг Үндэсний зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

5. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулж, үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн Ажлын албанд ирүүлж ажиллахыг орон нутгийн салбар зөвлөлд даалгасугай.

6. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023 он/-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай зөвлөмж”-ийн биелэлтийг хагас, бүтэн жилээр Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Б.Энх-Амгаланд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд,  
Үндэсний зөвлөлийн дарга



У.ХҮРЭЛСҮХ

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын  
үндэсний зөвлөлийн 2019 оны  
1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2019-2023)

Стратегийн зорилт		2.2.1. “Зам тээврийн ослыг 50 хувь бууруулах” гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн болон эдийн засгийн хосолсон зохицуулалтыг бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай “Цагаан ном”-ыг боловсруулан, гаргана.	Цагаан ном хэвлэгдэж, нийтийн хүртээл болсон байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	2019-2026
		Өндөр хөгжилтэй улсад хэрэгждэг түгжрэлийн, зогсоолын төлбөрийг албан үүргээ гүйцэтгэж байгаа тусгай дуут дохио хэрэглэсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэлд /албан тушаал, ажлын байрны онцлог үл харгалзан/ ногдуулдаг эрх зүйн болон эдийн засгийн хөшүүрэг хэрэглэнэ.	Албан тушаал, ажлын байрны онцлог үл харгалзан авто замын болон зогсоолын төлбөр тогтоох эрх зүйн зохицуулалттай болсон байна.	БХБЯ СЯ	ЗТХЯ ХЗДХЯ Нийслэлийн засаг дарга	2019-2020
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбоотой хууль тогтоомж, стратегийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.	Үнэлгээ хийгдэж, зөвлөмж гаргасан байна.	Үндэсний зөвлөл ЗТХЯ	ХЗДХЯ ЭМЯ	2019
		Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулахад холбогдох яам, засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрх үүргийг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж тодорхой болгон хэрэгжүүлнэ.	Холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлтүүд хийгдэж, хэрэгжсэн байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ ХЗДХЯ	2019-2021
		“Дугуйт тээврийн хэрэгсэл болон тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж болон эд ангид зориулсан техникийн нэгдсэн шаардлагыг батлах тухай хийгээд эдгээр шаардлагад үндэслэн олгосон зөвшөөрлийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр” (1995 оны 10 дугаар сарын 16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан)-ийн тухай хэлэлцээрт нэгдэн орно.	Олон улсын хэлэлцээрт нэгдэн орсон байна. Тус хэлэлцээрийн 144 хавсралтаас нэн шаардлагатай 50 стандартыг нутагшуулсан байна.	ЗТХЯ	ХЗДХЯ СХЗГ	2019
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой шилдэг туршлага, эрх зүйн хэм хэмжээ, стандарт норм, дүрмийг судлан нутагшуулах.	Жил бүр 2-оос доошгүй судалгаа хийж, өндөр хөгжилтэй улсад ашиглаж буй 1-ээс багагүй туршлагыг хэрэгжүүлсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ СХЗГ	2019-2023

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ЦАГААН НОМ»2019

1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах олон улсын жишигт нийцсэн эрх зүйн болон эдийн засгийн хосолсон зохицуулалтыг бүрдүүлнэ;	Байгаль орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд ээлтэй техник технологийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжих, аюултай техник технологи, үйлчилгээг хязгаарлах эрх зүйн болон эдийн засгийн хэм хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.	Холбогдох судалгааны дагуу Байгаль орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдалд ээлтэй техник технологийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжих бодлого, шийдвэр батлагдаж хэрэгжсэн байна.	ЗТХЯ СЯ	ХЗДХЯ	2019- 2023
2	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, чадавхыг бэхжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цогц байдлаар шинжлэн судлах бие даасан, хараат бус тогтолцоог бүрдүүлнэ;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл"-ийг байгуулна.	Үндэсний зөвлөл байгуулагдсан байна.	ЗТХЯ	ХЗДХЯ	2019
		Зам тээврийн ослыг шинжлэн шалгах албыг байгуулна.	Зам тээврийн ослыг шинжлэн шалгах нэгж байгуулагдсан байна.	ЗТХЯ	ХЗДХЯ	2020
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулах.	Салбар тус бүрт жилд 3-аас доошгүй сургалт зохион байгуулсан байна.	ЗТХЯ ХЗДХЯ	БСШУСЯ ХНХЯ	2018- 2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдал (ЗХАБ)-ын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо – Зааврыг хэрэглэх хэрэгцээ шаардлага MNS ISO 39001 : 2014 стандартыг хэрэгжүүлнэ.	MNS ISO 39001:2014 стандартын шаардлага хангагдсан байна.	ЗТХЯ	ХЗДХЯ БСШУСЯ ХНХЯ ЭМЯ Нийслэл, аймгуудын засаг дарга нар МХЕГ	2019- 2023
3	Замын хөдөлгөөн зохион байгуулалтын болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэжилтэн, тээврийн эдийн засагч нарыг гадаадын их дээд сургуульд бэлтгэх, цаашид дотоодын их дээд сургуульд бэлтгэх замаар хүний нөөцийг бүрдүүлэх;	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулах чиглэлээр 10-аас доошгүй хүнийг гадаадад сургахад бодлого, эдийн засгаар дэмжих. Төгсөж ирсэн хүмүүсийг их дээд сургуульд багшлахад бодлогын дэмжлэг үзүүлэх.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөн зохион байгуулах чиглэлээр 10-аас доошгүй хүн гадаадад суралцаж их дээд сургуульд багшилж, үндэсний хүний нөөц бэлтгэж эхэлсэн байна.	БСШСЯ	ЗТХЯ ХЗДХЯ	2020- 2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах сургалтыг байгууллагын удирдлага, мэргэжилтэн, судлаач, хэрэглэгч нарын төвшинд жилд 3-аас доошгүй сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.	Холбогдох төлөвлөгөө, удирдамжийн дагуу сургалт зохион байгуулсан байна.	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	Нийслэл, аймгийн засаг дарга нар	2019- 2023
		Тээврийн цагдаа, автотээврийн улсын байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нарт эрх зүйн мэдлэг олгохоос гадна ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулна.	Холбогдох сургалтууд төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.	МХЕГ ЦЕГ АТҮТ ТӨҮГ	Нийслэл, аймгийн засаг дарга нар	2019- 2023

4	Судалгаа, шинжилгээ, төлөвлөлтөд суурилсан замын хөдөлгөөн зохион байгуулалтын оновчтой зохицуулалтыг нэвтрүүлэх, замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох	Зам тээврийн ослыг цогц байдлаар судлах судалгааны ажлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг их дээд сургуулиудад захиалга өгч хийлгэх нөхцлийг бүрдүүлнэ.	Зам тээврийн ослыг цогц байдлаар судлах судалгааны ажлыг их дээд сургуулиудад хийгддэг болсон байна.	БСШУСЯ	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	2019-2023
		Зам тээврийн осол, зөрчлийг бүртгэх нэгдсэн системийг нэвтрүүлж, судалгаа, шинжилгээ хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгоно;	Зам тээврийн осол, зөрчлийг бүртгэх нэгдсэн систем бий болж, судалгаа шинжилгээнд ашиглагдсан байна.	Үндэсний зөвлөл	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ	2019-2023
		Зам тээврийн ослыг судлах чиглэлээр гадаад дотоодод сурч байгаа магистр, докторуудад бодлогын дэмжлэг үзүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр жилд 2-3 хүн магистр, докторын зэрэг хамгаалсан байна.	БСШУСЯ	ЗТХЯ ХЗДХЯ ЭМЯ Их, дээд сургуулиуд	2019-2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах баруун, төвийн, хангайн, төвийн, зүүн бүс, орон нутгийн хэмжээнд аймаг тус бүр үндсэн хөтөлбөр, судалгаа, шинжилгээнд суурилсан дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах баруун, төвийн, хангайн, төвийн, зүүн бүсийн хэмжээнд болон аймаг тус бүр дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлсэн байна.	Үндэсний зөвлөл	ХЗДХЯ ЗТХЯ ЭМЯ Аймаг, нийслэлийн засаг дарга	2019-2023
		Гудамж замын хөдөлгөөнийг сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ "Аюултай нь бага, аюулгүй нь их" гэсэн олон улсын зарчмыг баримталж явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцлийг бүрдүүлнэ. Сургууль цэцэрлэгийн орчинг хөдөлгөөний эрчим ихтэй авто замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглах;	Сургууль цэцэрлэгийн орчин болон ачаалал ихтэй гудамж, авто замын аюулгүй байдал хангагдсан байна.	ЗТХЯ БХБЯ	ХЗДХЯ ЭМЯ Аймаг, нийслэлийн засаг дарга	2019-2023
		Замын хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотой судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.	Замын хөдөлгөөнийг зохион байгуулахтай холбоотой жилд нэгээс доошгүй судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.	БХБЯ	ЗТХЯ ХЗДХЯ	2019
		Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах аюулгүй байдлыг шалгах иж бүрэн лаборатори, судалгааны төвийг барьж байгуулах	Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах аюулгүй байдлыг шалгах иж бүрэн лаборатори, судалгааны 1 төвийг барьж байгуулсан байна.	ЗТХЯ	АТҮТ ТӨҮГ	2019-2024

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ЦАГААН НОМ»2019

Стратегийн зорилт		2.2.2. "Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл /10 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт, гэмтэл/-ийг 50 хувиар бууруулах"				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1	Явганаар болон унадаг дугуйгаар зорчих, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцлийг бүрдүүлэх;	Суурин газрын авто замын дагуу явган зорчигч, унадаг дугуйн хөдөлгөөнийг автомашины хөдөлгөөнөөс тусгаарласан зохион байгуулалтын шийдлийг бий болгоно.	Суурин газарт зорчих хэсгийн дагуу явган хүний хөдөлгөөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрэн тусгаарласан байна.	ЭТХЯ	ЗТХТ ТӨҮГ Нийслэл аймгийн засаг дарга	2018-2023
		Зам, явган хүний гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглоно.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэг, иргэдийн амьдардаг байрны ойролцоо замын явган хүний гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглосон байна.	ЭТХЯ	ЗТХТ ТӨҮГ Нийслэл, аймгийн засаг дарга	2019-2023
		Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнөөс тусгаарласан унадаг дугуйн замын уртыг нэмэгдүүлнэ.	Жилд 1км-ээс багагүй урттай зөвхөн унадаг дугуйгаар зорчиход зориулсан зам барьсан байна.	Нийслэл, аймгийн засаг дарга	БХБЯ	2019-2023
		Явган хүний гарам, гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр цогц байдлаар шийдвэрлэх. Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох. Шөнийн харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгох, холбогдох стандартыг шинэчлэн, хэрэгжүүлнэ.	Явган хүний гарцын техникийн шаардлага, стандартад өөрчлөлт оруулж хэрэгжүүлсэн байна .	БХБЯ ЭТХЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга	2019-2022
2	Жолоочийн сахилга хариуцлага сул байдлаас шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулах;	Олон улсын авто замын тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийнбагийн ажлын талаарх Европын хэлэлцээр / AETR/-т нэгдэн орох.	Хэлэлцээрт нэгдэн орсон байна.	ЭТХЯ	ГХЯ ХЗДХЯ	2019-2023
		Олон улсын авто даатгагчдынкартын систем буюу "Ногоон картын систем"-д нэгдэх	Системд нэгдэн орсон байна.	ЭТХЯ	ГХЯ СЯ ХЗДХЯ АЖДХ	2019-2023
		Жолоочийн ажил, амралтын дэглэмтэй холбогдсон шаардлагыг мөрдүүлэх, жолоочийн ядаргаанаас үүсэлтэй шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулна;	Жолоочоос хамаарсан зам тээврийн ослын тоо буурсан байна. / Судалгаа хийнэ/	ЭТХЯ	МАТНХ Судалгааны байгууллагууд Их дээд сургуулиуд	2019-2023
		Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчилд жил бүр судалгаа хийж ноцтой, зам тээврийн осол, түүний үр дагаварт нөлөөлж байгаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх компаниит ажил зохион байгуулах.	Холбогдох судалгааны үндсэн дээр жилд 1-ээс доошгүй компаниит ажил хийгдсэн байна.	ЭТХЯ ХЗДХЯ ЭМЯ	НЭМХ ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019-2023

2	Жолоочийн сахилга хариуцлага сул байдлаас шалтгаалсан зам тээврийн ослыг бууруулах;	Жолоочийн зөрчлийн бүртгэлд оноо тооцох, зөрчил болон ослын бүртгэлийг даатгалын системтэй уялдуулах.	Жолоочийн гаргасан зөрчил, осол гаргасан байдал нь даатгалын эрсдлийн үнэлгээнд нөлөөлдөг нөхцөл бүрдэж, хэрэгжсэн байна.	ЗТХЯ ХЗДХЯ	СЗХ ЦЕГ АТҮТ ТӨҮГ АЖДХ	2019- 2023
		Замын хөдөлгөөнд оролцогчдын зөрчлийг иргэдийн мэдээллээр шийдвэрлэх эрх зүйн болон техникийн шийдлийг бий болгоно.	Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх техникийн шийдлийг бий болгоно. Техникийн шийдлийг ашиглах хууль, журмыг батлан хэрэгжүүлнэ.	ХЗДХЯ ЗТХЯ	ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019- 2020
3	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.	Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх жишиг төвийг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих замаар байгуулах асуудлыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах.	Эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Улаанбаатарт 2, орон нутгийн хэмжээнд 4-өөс багагүй төвийг байгуулсан байна.	ХЗДХЯ ЗТХЯ	ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019- 2023
		Жолооч бэлтгэх арга, хөтөлбөр, тогтолцоог боловсронгуй болгох, мэргэшүүлэх, шалгах үйл ажиллагаанд хүнээс хамаарсан хамаарлыг багасгаж, ЕХУ, БНСУ, АНУ зэрэг улсуудад хэрэглэж байгаа програм хангамж, тоног төхөөрөмжөөр хангана. чанартай жолооч бэлтгэх үр ашигтай техник технологи, тогтолцоог хэрэглэх.	Жолоочийн шалгалт авдаг, дүгнэх үйл ажиллагаа ЕХУ, БНСУ, АНУ-ын тухайн үеийн жишигт хүрсэн байна.	НХХЯ ХЗДХЯ ЗТХЯ	ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019- 2023
		Олон Улсын Автотээврийн Холбооны жолооч, менежер, тээврийн байгууллагын удирдах ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх.	Олон улсын жишигт нийцсэн сургалтын хөтөлбөрт хамрагдах, мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлсэн байна.	ЗТХЯ БСШУСЯ	ХЗДХЯ АТҮТ НТГ Төрийн бус байгууллагууд	2019- 2021
4	Боловсролын тогтолцооны бүх шатны сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг тусгах замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлнэ.	Хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөр батлагдан, хэрэгжсэн байна.	ХНХЯ	БСШУСЯ ХЗДХЯ ЗТХЯ	2020- 2023
		Хүүхдүүдийн дунд уламжлан болгон зохион байгуулдаг "Ногоон гэрэл, цагаан шугам", "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнээс гадна хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулна.	Жил бүр уралдаан тэмцээн зохион байгуулсан байна	БСШУСЯ Аймаг, нийслэлийн засаг дарга	ХЗДХЯ ЗТХЯ	2020- 2023



4	Боловсролын тогтолцооны бүх шатны сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг тусгах замаар замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бага наснаасаа Замын хөдөлгөөний дүрэм үзэж, жолоодлогын дадлага хийж, 18 нас хүрэхдээ жолоочийн шалгалт өгдөг байх нөхцөл бүрдүүлэх.	Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд болон гэрээгээр ажиллах замын хөдөлгөөний дүрмийн танхим, жолоодлогын автомашин, дадлагын багш нар ажиллаж, 18 нас хүрсэн хүмүүсийн 30 хүртэл хувь нь жолоочийн шалгалт өгөх нөхцөл бүрдсэн байна.	Аймаг, нийслэлийн засаг дарга	ХЗДХЯ ЭТХЯ БСШУСЯ	2020-2023
		Боловсролын тогтолцооны бүх шатны сургалтын хөтөлбөрт замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, дадал, хандлагыг дээшлүүлэх сургалтыг оруулж, аймаг дүүрэг тус бүрт 1-ээс доошгүй тооны замын хөдөлгөөний иж бүрэн сургалт зохион байгуулах төвийг нэг сургуульд түшиглэн зохион байгуулах;	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг боловсруулагдан батлагдаж хэрэгжүүлсэн байна.	БСШУСЯ НХХЯ	ХЗДХЯ ЭТХЯ	2019-2023
		Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний нийт сургуульд хэрэгжүүлэх арга хэмжээг авна.	Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний нийт сургуульд хангагдсан байна.	БСШУСЯ МХЕГ	ЭТХЯ Нийслэл, аймгийн засаг дарга	2019-2023
5	Замын хөдөлгөөнд оролцогчын хандлага, соёл, дадал, хариуцлагыг дээшлүүлэх.	Эрүүл мэнд, ёс зүй, сэтгэхүйн сорилтын хичээлийн цагийг нэмэгдүүлэн сургалтын хөтөлбөрт оруулж, шалгалтын шалгуур үзүүлэлтэд багтаана.	Сургалтын хөтөлбөр батлагдаж, жолоочийн шалгалт авахад замын хөдөлгөөнд оролцох бие болон сэтгэл зүйн онцлог, ёс зүйн асуултууд шалгалтын тестэд багтсан байна.	ХЗДХЯ ЭТХЯ	ЦЕГ	2019-2023
		Мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулах.	Үйл ажиллагааг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлагдсан байна.	ЭТХЯ ХЗДХЯ МХЕГ	МХЕГ ЦЕГ АТҮТ ТӨҮГ АЖДХ	2019-2023
		Бизнесийн салбарт амжилттай үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын анхаарлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хандуулж, хууль тогтоомжийн хүрээнд сургалт сурталчилгаа явуулах, олон нийтийг уриалах үйл ажиллагаанд татан оролцуулах.	Олон нийтийн болон аж ахуйн нэгжийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд оролцох нөхцөл хангагдсан, урьдчилан сэргийлэх болон олон нийтийг хамарсан үйл ажиллагааг аж ахуйн нэгжүүд дэмжсэн байна.	Үндэсний зөвлөл	ЭТХЯ ХЗДХЯ ЭМЯ АЖДХ	2019-2023
Хамгаалах бүс, хамгаалалтын малгай болон бусад аюулгүйн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр компани тэжээг үе шаттай, системтэй хэрэгжүүлнэ.	Хамгаалах бүс, хамгаалалтын малгай болон бусад аюулгүйн хэрэгслээ 90 хувьд хүрсэн байна.	ХЗДХЯ ЭТХЯ	ЭМЯ БСШУСЯ АЖДХ	2019-2023		



6	Зам тээврийн ослын үед ашиглах техник хэрэгслийн хангалтыг сайжруулах, орчин үеийн шаардлагад нийцүүлэх, осол саатлын үед үзүүлэх тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулна.	Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох талбайг 50 км тутамд, амрах талбай, үйлчилгээний цогцолборыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, эрэлт хэрэгцээнд тулгуурлан барьж байгуулна.	Хатуу хучилттай замын дагуу 50 км тутам зогсох талбайг, 30-аас багагүй үйлчилгээний цогцолборыг стандартын дагуу барьж байгуулна.	ЗТХЯ	ХХААХҮЯ БОАЖЯ Аймгийн засаг дарга нар	2019-2023
		Зам тээврийн ослын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, байрлал тогтоох техникийн шийдэл, журам боловсруулан хэрэгжүүлэх. Ингэхдээ орчин үеийн интернет, үүрийн телефон, сансрын холбооны сүлжээ ашиглахаас гадна олон улсын чанартай автозамын сүлжээний дагуу яаралтай тусламжийн утсан сүлжээ бий болгоно;	Журам болон яаралтай тусламжийн утсан сүлжээг бий болгосон байна.	ЗТХЯ	ЭМЯ Аймгийн засаг дарга нар	2019-2023
		Зам тээврийн ослын үед эмнэлгийн тусламжийг автомашинаар саадгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээс гадна ноцтой, хүнд гэмтлийн үед нисдэг тэрэг, бага оврын агаарын хөлөг ашиглах нөхцлийг бүрдүүлнэ;	Ослын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний хугацаа богиносох, ослоор нас барагсадын болон гэмтсэн бэртсэн хүний тоо буурна.	ЗТХЯ	ЭМЯ Аймгийн засаг дарга нар	2019-2023
		Авто замын дагуух үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг түшиглэн тэдгээрийн ажилчдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг чадварыг эзэмшүүлэх замаар тусламж үзүүлэх цэгүүдийг байгуулна;	Анхны тусламжийн үйлчилгээг авто замын дагууд бүрэн хангагдсан байна.	ЭМЯ	ЗТХЯ	2019-2023

Стратегийн зорилт		2.2.3. "Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложикийн сүлжээг 30 хувь өргөжүүлэн хөгжүүлнэ" гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:				
1	Автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалт, техникийн үйлчилгээ, техникийн хяналт, устгал, дахин боловсруулахтай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох, үндэсний стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулан мөрдүүлэх замаар тээврийн хэрэгслийн техникийн болон экологийн аюулгүй байдалд тавих шаардлагыг нэмэгдүүлнэ.	Орчин үеийн технологид нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, техникийн шаардлага хангах, хүрээлэн буй орчинд ээлтэй байх тээврийн хэрэгслийг ашиглахтай холбоотой олон улсад мөрдөж байгаа стандарт, дүрэм, хэм хэмжээг нутагшуулах ажлыг зохион байгуулна.	Жилд 5-аас багагүй стандарт, дүрэм, хэм хэмжээг нутагшуулах ажил хийгдсэн байна.	ЗТХЯ ХЗДХЯ	СХЭГ	2019-2020
		Авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, техникийн шаардлага хангах болон хүрээлэн буй орчинд ээлтэй байх нөхцөлийг даатгалын тогтолцоотой уялдуулан хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	Тээврийн хэрэгслийн идэвхтэй, идэвхгүй, ослын дараах, байгаль орчны аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг тээврийн хэрэгслийн даатгалд хамруулсан байна.	СЭХ	ЗТХЯ АЖДХ	2020-2022
		Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэл нь аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	ЕХУ-д хэрэгжүүлдэг хяналтын үзлэгт орсон тээврийн хэрэгслийг олон нийт хянадаг механизм бүрдсэн байна.	ЗТХЯ	АТҮТ ТӨҮГ МАТНХ	2020-2022
2	Үйлдвэрлэгчээс баталгаат автотээврийн хэрэгсэл, сэлбэгийг шууд хэрэглэгчид хүргэх тогтолцоог бүрдүүлэх, мөн тухайн оронд болон Монгол Улсад ашиглахыг хориглосон, ашиглалтын хугацаа дууссан, баруун гар талдаа жолооны хүрдтэй, зургаагаас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах замаар авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй осол, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулна;	Автомашин үйлдвэрлэдэг орнуудын Засгийн газар, яамд хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах замаар баталгаат автомашин, сэлбэг хэрэгсэл импортлох нөхцөлийг бүрдүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	ЗТЯ	СЯ	2020-2023
		Тухайн улсдаа ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй болсон байна.	Тухайн улсдаа ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй болсон байна.	СЯ ГЕГ	ЗТХЯ	2019-2022
		Одоо ашиглаж байгаа баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байрлалыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн инженерийн шийдлийг бий болгох жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.	Холбогдох судалгааг холбогдох их дээд сургуулиудтай хамтран хийж, үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.	ХХААХҮЯ СЯ	ЗТХЯ	2019-2023
		Тээврийн хэрэгсэлд дүрс бичлэг хийх "Хар хайрцаг" суурилуулах ОХУ-д хэрэглэж буй шийдлийг хэрэглэж, осол, эерчил шийдвэрлэх эрх зүйн тогтолцоог бий болгоно.	Нийт тээврийн хэрэгсэлд "Хар хайрцаг" суурилуулж ашигласан байна.	ЗТХЯ ХЗДХЯ	ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019-2023

3	Тээврийн хэрэгслийн хийц, технологийн онцлогт тохирсон, техник технологийн дэвшилд суурилсан, тээврийн хэрэгслийн тооны зохистой харьцаанд нийцүүлэн "Үйлчилгээ-Оношилгоо-Хяналт"-ын нэгдсэн системийг бүрдүүлнэ;	Автотээврийн тухай хууль болон татварын холбогдох хууль тогтоомж, хөдөлгөөн зохицуулах менежментийг хэрэгжүүлэх замаар зургаагаас дээш жил ашигласан болон баруун талдаа жолооны хүрдтэй автомашины хөдөлгөөнийг үе шаттай хязгаарлана.	Зургаагаас дээш жил ашигласан болон баруун талдаа жолооны хүрдтэй автомашины тоо 90 хүртэл хувь буурсан байна.	СЯ ЭТХЯ ХЗДХЯ	Нийслэл, аймгийн засаг дарга нар	2019- 2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан сангууд, тэдгээрийг ашиглах журмыг баталж хэрэгжүүлнэ.	Хуульд заасан сан, тэдгээрийг ашиглах журмууд бүрэн батлагдаж хэрэгжсэн байна.	ЭТХЯ ХЗДХЯ	ЦЕГ АТҮТ ТӨҮГ	2019- 2020
		"Үйлчилгээ-Оношилгоо-Хяналтын" нэгдсэн системийг тээврийн хэрэгслийн болон жолоочийн даатгалтай уялдуулах замаар аюулгүй байдлын цогц систем бүрдүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан сангуудын үйл ажиллагаа даатгалын системтэй уялдсан байна.	ЭТХЯ СЗХ	ХЗДХЯ АЖДХ	2019- 2022
4	Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын хөдөлгөөний удирдлага, хяналт, зохицуулалт, осол зөрчлийг бүртгэх мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэгдсэн сан"-г бий болгох журам баталж, санг ашиглах үйл ажиллагааг зохион байгуулна.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэгдсэн сан"-г бий болгох журам баталж, санг ашиглах үйл ажиллагааг зохион байгуулна.	Үндэсний зөвлөл	ЭТХЯ ХЗДХЯ ХНХЯ	2019
		Мэдээллийн нэгдсэн системийг ашиглан жилд 3-аас доошгүй судалгаа хийж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглана.	Судалгааны үндсэн дээр 3 доошгүй кампанит ажил зохион байгуулсан байна.	Үндэсний зөвлөл	ЭТХЯ ХЗДХЯ ЭМЯ	2019- 2023
		Хүн ба ачаа тээвэрлэхэд ашиглалтын үйл ажиллагаанд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлдэг нэгдсэн бүртгэл хяналтын систем бүрдүүлнэ.	Бүртгэл хяналтын техникийн шийдэл бий болсон байна.	ЭТХЯ	АТҮТ ТӨҮГ	2019- 2021
		Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын удирдлага, хяналт, зохицуулалтын төвийг байгуулж, орчин үеийн дэвшилтэд технологи бүхий систем нэвтрүүлнэ.	Хүн ба ачаа тээвэр, замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтад хяналт, зохицуулалтын шинэ систем нэвтэрсэн байна.	ЭТХЯ	ХЗДХЯ УУХҮЯ ХХААХҮЯ ЭМЯ НХХЯ	2019- 2023
5	Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана;	Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох судалгааг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор хийнэ.	Жолооч, тээврийн хэрэгслийн дааггалыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох судалгаа хийгдсэн байна.	ЭТХЯ СЗХ	ХЗДХЯ Албан журмын даатгагчдын холбоо	2019- 2020
		Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад импорт-оношлогоо үйлчилгээ-засвар-техникийн хяналтын бүх шатанд даатгалын цогц систем бий болгоно.	Жолоочийн даатгалын тухай хуульд холбогдох өөрчлөлт орж хэрэгжсэн байна	ХЗДХЯ ЭТХЯ	СЗХ АЖДХ	2020- 2023

5	Автотээврийн салбарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах даатгалын цогц систем бий болгох замаар төр, иргэнд ирэх санхүүгийн дарамтыг багасгана;	Тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байрлал, ашиглалтаас хамаарсан даатгалын эрсдэлийн үнэлгээ тооцдог тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх.	Тээврийн хэрэгслийн жолооны хүрдний байрлал, ашиглалтаас хамаарсан даатгалын эрсдэлийн үнэлгээ тооцдог тогтолцоо бий болж, хэрэгжсэн байна.	СЯ СЗХ	ЗТХЯ АЖДХ	2020- 2023
6	Нийтийн тээврийн үйлчилгээнд суурилсан хот төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлнэ;	Иргэдийг хувийн автомашинаас татгалзах зогсоол, зорчилтын менежментийн системийг бий болгоно.	Авто зогсоолыг байгуулах, ашиглах, хөдөлгөөний ачаалал ихтэй замд төлбөр ногдуулахтай холбоотой харилцааг бий болгож хэрэгжүүлнэ.	БХБЯ	ЗТХЯ ХЗДХЯ Нийслэлийн засаг дарга	2018- 2022
		Нийтийн тээврийн үйлчилгээг боловсронгуй, ая тухтай, аюулгүй, шуурхай байх нөхцөлийг бүрдүүлсэн менежментийг бий болгох.	Нийслэлийн иргэдийн 50 хувь нь нийтийн тээврээр зорчдог байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	БХБЯ ЗТХЯ	Нийслэлийн засаг дарга	2019- 2023
		Хот төлөвлөлтийг боловсронгуй болгох, дахин төлөвлөлт хийх, хэсэгчилсэн төлөвлөлт хийх, замналыг шинэчлэх замаар нийтийн тээврийн шуурхай байдлыг хангах.	Нийтийн тээврээр зорчих нь хувийн автомашинаар зорчих хугацаанаас 2 дахин ашигтай байх нөхцөл бүрдсэн байна.	БХБЯ ЗТХЯ	Нийслэлийн засаг дарга	2020- 2023
		Өнөөгийн нийтийн тээврийн үйлчилгээнд иж бүрэн судалгаа хийж хөдөлгөөний замналаас гадна, зогсоолын шийдлийг оновчтой болгох	Нийтийн тээврийн замнал, зогсоолын шийдэл хамгийн оновчтой хувилбараар зохион байгуулсан байна.	Нийслэлийн засаг дарга	Нийслэлийн зам, тээврийн байгууллагууд	2019- 2022
7	Хот суурин газрын төлөвлөлт, газар олголтод замын хөдөлгөөн зохион байгуулалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг нэн тэргүүнд тавих зохицуулалтыг бүрдүүлнэ;	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх.	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэгдсэн байна.	БХБЯ	ЗТХЯ	2019
		Газар олголт, суурин газрын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний үед хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэмд замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн үзүүлэлтийг тооцдог байх, үндсэн үзүүлэлт зөрчигдсэн тохиолдолд зөвшөөрөл олгохгүй, гэрээ цуцалдаг байх эрх зүйн орчинг бүрдүүлэх	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД-ийн хэрэгжилт хангагдсан байна.	БХБЯ	ЗТХЯ	2019- 2023
		Шинээр хорооллыг төлөвлөхдөө сургууль цэцэрлэгийг төвд нь байхаар, хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, удирдлага, мэдрэгч тэргүүний арга хэрэгслийг ашиглана.	Шинээр баригдаж байгаа суурьшилын бүсийн хүн амын тоо, эрэлт хэрэгцээг тооцсон сургууль, цэцэрлэг нийгмийн үйлчилгээний байгууллага хамт баригдах нөхцөл бүрдэж, хэрэгжсэн байна.	БХБЯ	Аймаг, нийслэлийн засаг дарга	2019- 2023

8	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх;	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал боловсруулан, батлуулах, хэрэгжүүлэх.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тухай заалтыг тусгасан байна.	ЭТХЯ	ХЗДХЯ	2019-2023	
		Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах, ашиглалтын дараах үе шатанд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх тогтолцоог бүрдүүлнэ;	Авто зам, замын байгууламжийг төлөвлөх, зураг, төсөл зохиох, барих, ашиглах үед авто замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал боловсруулан, батлуулах, хэрэгжүүлэх.	Жил бүр замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийгдсэн байна.	ЭТХЯ	ЦЕГ ЭТХТ ТӨҮГ АТУТ ТӨҮГ	2019-2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх, холбогдох судалгаа, шинжилгээ хийх замаар "хар цэг"-ийг тодорхойлж, ослын шалтгаан нөхцөлийг тогтоож, үр дагаврыг арилгах арга хэмжээ авна.	"Хар цэг"-ийг тодорхойлж осол гарах нөхцлийг арилгах арга хэмжээ авсан байна.	ЭТХЯ	ЭТХТ ТӨҮГ, Их дээд сургууль, судалгааны байгууллага	2019-2023	
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах судалгааг мэргэжлийн байгууллага, судлаачдын оролцоотойгоор зохион байгуулж, тэмдэг, тэмдэглэл, техникийн шийдлийг оновчтой хэрэглэх ажлыг зохион байгуулна.	Судалгааны үндсэн дээр замын хөдөлгөөнийг эдийн засгийн үр ашигтайгаар зохион байгуулсан байна.	ЭТХЯ	ЭТХТ ТӨҮГ, Их дээд сургууль, судалгааны байгууллага	2019-2023	
9	Тусгай зориулалтын авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлэх	Уул уурхайн болон нийтийн хэрэгцээний бус замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, хуультай нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт батлан хэрэгжүүлнэ.	Холбогдох хууль, дүрэм журам, стандарт батлагдсан байна	ЭТХЯ УУХҮЯ	ХЗДХЯ	2019-2022	
		Уул уурхайн замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийж, шаардлагатай тоног төхөөрөмж, тэмдэг тэмдэглэлээр хангах	Жил бүр уул уурхайн 1-ээс доошгүй замд аудит хийж, холбогдох дүгнэлтийн дагуу өөрчлөлт хийсэн байна.	ЭТХЯ УУХҮЯ	ХЗДХЯ УУХҮЯ ХХААХҮЯ ЭМЯ НХХЯ	2019-2023	
		Уул уурхайн болон нийтийн хэрэгцээний бус газарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтын механизмыг бий болгоно	Уул уурхайн болон нийтийн хэрэгцээний бус газарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтын техникийн болон хүний нөөц, эрх зүйн шийдэл бий болсон байна.	УУХҮЯ	ЭТХЯ ХЗДХЯ	2019-2023	
		Орон нутгийн бэлчээр хэсэг, замгүй газарт тээврийн хэрэгсэл ашиглах талаар жил бүр 1-ээс доошгүй компани ажил зохион байгуулах	Холбогдох судалгаа хийж, жил бүр 1-ээс доошгүй компани ажил зохион байгуулсан байна.	ХЗДХЯ ХХААХҮЯ	ЭМЯ НХХЯ ЭТХЯ	2019-2023	

Стратегийн зорилт		2.2.4. “Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбай, хот хоорондын замын 50 хувийг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна” гэсэн хөтөлбөрийн зорилтын хүрээнд:				
	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1	Тээврийн ухаалаг системд суурилсан авто замын удирдлага, хяналт, зохицуулалтын систем нэвтрүүлнэ;	тээврийн ухаалаг системд суурилсан эрэлтийн удирдлагын системийг бий болгоно.	Зорчигч, ачаа урсгалын судалгаа хийж эрэлт, хэрэгцээнд суурилсан тээвэрлэлт хийгдэж эхэлсэн байна.	ЗТХЯ	Нийслэл, аймгуудын Засаг дарга	2019-2023
		Тээврийн ухаалаг системд суурилсан замын хөдөлгөөний удирдлагын төвийг Нийслэл орон нутагт шинээр байгуулна.	Холбогдох судалгаа хийж, Улаанбаатарт болон 2 оос багагүй аймагт шаардлага хангасан, дэвшилтэд технологи ашигласан хөдөлгөөний удирдлагын төв шинээр байгуулсан байна.	ХЗДХЯ Аймаг, Нийслэлийн засаг дарга	ЗТХЯ ЭМЯ	2020-2021
		Тээврийн хэрэгслийн даац хэтрэлтийг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ.	Тээврийн хэрэгслийн даац хэтрүүлэх зөрчлийг таслан зогсоох нөхцөл бүрдсэн байна	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгуудын Засаг дарга, МХЕГ	2019-2023
		Тээврийн хэрэгслийн зогсолт, зогсоолыг хянаж, зохицуулах систем нэвтрүүлнэ.	Тээврийн хэрэгслийн зогсоолын зөрчлийг таслан зогсоох, тээврийн хэрэгслийн зогсоолыг зохицуулах нөхцөл бүрдсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгуудын Засаг дарга, МХЕГ	2019-2023
2	Улсын болон орон нутгийн чанартай авто замын дагууд тээврийн хэрэгслийн зөрчлийг хянах дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх.	Улсын чанартай замд тээврийн хэрэгслийн хурдыг хянах хяналтын камер систем ашиглана.	Улсын чанартай замын 50 хувьд камерын хяналт нэвтэрсэн байна	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгуудын Засаг дарга	2019-2023
		Улсын чанартай замд тээврийн хэрэгслийн хурдыг хянах хяналтын камер систем ашиглана.	Улсын чанартай замын 50 хувьд камерын хяналт нэвтэрсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ Нийслэл, аймгуудын Засаг дарга	2019-2023
		Улсын чанартай замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий хяналтын пост барьж ашиглана.	Нийт улсын чанартай замын дагуу хяналтын тоног төхөөрөмж бүхий 60 пост ашигласан байна.	ХЗДХЯ	ЗТХЯ ЦЕГ	2019-2023
3	Тээврийн хэрэгслээс хөдгөөнийг хянах тогтолцоог бий болгоно.	Тээврийн хэрэгсэлд камер суурилуулж ашиглах эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай болон Жолоочийн даатгалын тухай хууль, Тээврийн хэрэгслийг ашиглахтай холбоотой стандартад холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан байна.	ЗТХЯ ХЗДХЯ СХЗГ	Албан журмын даатгагчдын холбоо	2019-2023

3	Тээврийн хэрэгслээс хөдгөөнийг хянах тогтолцоог бий болгоно.	Зам тээврийн шалтгаан нөхцлийг тогтоох, замын хөдөлгөөний болон бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд камер суурилуулж ашиглана.	Нийт тээврийн хэрэгсэлд камер сууртлуулж ашигладаг болсон байна.	ЗТХЯ ХЗДХЯ	Албан журмын даатгагчдын холбоо	2019-2023
		Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлнэ.	Е-Police цахим систем ашиглан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг шийдвэрлэнэ.	ЗТХЯ	ЦЕГ Аймаг, нийслэлийн засаг дарга	2019-2023
		Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний удирдлагын систем, ашиглах камер, тоног төхөөрөмжийн стандарт батлагдаж, нислэл, орон нутгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөнийг хянах удирдлагын системийн технологийн шийдлийг бий болгож, ашиглана.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний удирдлагын систем, ашиглах камер, тоног төхөөрөмжийн стандартыг бий болгож ашиглана.	ЗТХЯ ХЗДХЯ	Аймаг нийслэлийн засаг дарга	2019-2023
4	Гудамж замын хөдөлгөөнийг сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ "Аюултай нь бага, аюулгүй нь их" гэсэн олон улсын зарчмыг баримталж явган зорчигч замын хөдөлгөөнд оролцох таатай нөхцөл бүрдүүлнэ.	Гудамж замын хөдөлгөөний сүлжээг төлөвлөх, шинэчлэхдээ олон улсын жишиг аргачлал ашиглан, судалгаа тооцоо хийж гэр хорооллын дундах замыг явган хүн зорчих аюулгүй байдлыг хангахаас гадна, гэмт халдлагаас хамгаалах, ая тухтай нөхцлийг бүрдүүлнэ.	Нийтийн тээврээр зорчихын тулд автобусны буудлаас гэр хүртэл зорчих хэв журам хамгаалагдсан, гэрэлтүүлэг, явган хүний зам, ногоон байгууламж, камер зэрэг явган хүн ая тухтай зорчих бүхий л нөхцөл хангагдсан байна.	БХБЯ, Аймаг, нийслэлийн засаг дарга	ЗТХЯ ХЗДХЯ	2019-2023
		Сургууль цэцэрлэгийн гол, төв, хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлах, хөдөлгөөнд оролцогчийн аюулгүй оролцох шилдэг модель, тэргүүний арга хэрэгслийг ашиглана.	Сургуулийн бүс. Техникийн шаардлага MNS 6444:2014 стандартыг улсын хэмжээний нийт сургуульд хангагдаж, хөдөлгөөнийг хянах камераар тоноглогдсон байна.	БСШУСЯ	ХЗДХЯ	2019-2023
		Явган хүний гарам, гарцыг тооцоо, судалгааны үндсэн дээр цогц байдлаар шийдвэрлэх. Явган хүний гарцыг шилдэг техник технологи, инновацийн арга хэрэглэн тоноглох. Шөнийн харанхуй үед замын бусад хэсгээс илт ялгарах техникийн шийдлийг бий болгоно.	Суурин газрын нийт явган хүний гарц стандартын шаардлага хангаж, шөнийн цагт замын бусад хэсгээс илт ялгарч харагдах нөхцөл бүрдсэн байна.	ЗТХЯ	ХЗДХЯ ЗТХТ ТӨҮГ	2019-2023

## **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН ТҮҮНИЙ ТӨРӨЛЖСӨН САНГ ХӨТӨХ, УГ САНГААС МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА ӨГӨХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг зүйл**

1.1. Төрийн байгууллагын мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, мэдээлэл солилцох, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон мэдээллийг шуурхай, нэг цэгээс үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад байршиж байгаа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох системийг бий болгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн сан болон түүний төрөлжсөн сан /цаашид мэдээллийн нэгдсэн сан гэх/-г баяжуулах, ашиглах, түүний байнгын ажиллагааг хангах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэдээллийн нэгдсэн сан нь Төрийн цахим мэдээллийн сангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

1.3. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл солилцох систем нь төрийн үйлчилгээний Хур болон Дан системтэй холбогдож ажиллах боломжтой байна.

1.4. Мэдээллийн нэгдсэн сангаас авах лавлагааг төрийн үйлчилгээний цахим машинаас авах боломжтой байна.

1.5. Мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн сан, уг сангийн мэдээлэл, лавлагаа нь Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйл, холбогдох мэдээллийг боловсруулж, технологийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйн үндсэн дээр орчин үеийн тооцоолох техник хэрэгсэл ашиглан хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангах зорилготой.

1.6. Мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, мэдээллийг боловсруулах, мэдээлэл лавлагаа өгөх хэрэглэгчдэд үйлчлэх ажлыг улсын хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д заасан байгууллагууд хамтран хэрэгжүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба хариуцна.

1.7. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, яам, төрийн бусад байгууллагууд өөрсдийн чиг үүрэгтэй холбоотой замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдээллийн сантай байж болох бөгөөд түүнийг мэдээллийн нэгдсэн сантай холбон ашиглаж болно.

1.8. Мэдээллийн нэгдсэн санг хариуцан хөтөлж байгаа байгууллагын зөвшөөрөлгүйгээр уг сангийн мэдээллийг байгууллага, иргэнд хуулбарлан өгөх,



засварлах, устгахыг хориглоно.

1.9. Мэдээллийн нэгдсэн сангийн анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх зааврыг холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба боловсруулж мөрдүүлнэ.

### **Хоёр. Сангийн мэдээ ирүүлэх, тайланг гаргах**

2.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан бүртгэл, мэдээллийн санг хөтлөх байгууллага сар бүрийн 20-ны өдөрт багтаан мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг албан бичиг болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.2. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээ баримтын эх хувийг Архивын тухай хуульд зааснаар хадгална.

2.3. Мэдээллийн нэгдсэн сангаас замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбоотой мэдээг сар бүрийн 25-ны дотор боловсруулан Үндэсний статистикийн хороонд мэдээлж байна.

2.4. Мэдээллийн сангаас гаргасан мэдээ, тайланд эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

### **Гурав. Мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, мэдээлэл боловсруулах**

3.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан байгууллагууд ажлын 24 цагт багтаан өөрийн хариуцсан мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд оруулна.

3.2. Хуульд заасан эрх бүхий байгууллагаас бичгээр ирүүлсэн мэдээг ажлын 3 хоногт багтаан Мэдээллийн нэгдсэн санд тусгаж, санг баяжуулах ажлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба хариуцна.

3.3. Шаардлагатай гэж үзвэл бусад хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт өгөгдлүүдийг мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлж болно.

3.4. Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан байгууллагууд хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан байгууллагууд нь мэдээллийн санд хандах боломжит эрхээр хангагдах ба эрхийг бусад этгээдэд дамжуулахыг хориглоно.

### **Дөрөв. Мэдээллийн санг ашиглах**

4.1. Мэдээллийн нэгдсэн санг байгууллага, иргэдэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдолтой тоо, мэдээ гаргаж өгөх, судалгаа хийх мэдээллийн эх үүсвэр болгон ашиглана.

4.2. Эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтээр мэдээллийн нэгдсэн сангаас тоо, материал гаргаж өгөх,

судалгаа, шинжилгээ хийх ажлыг зохих төлбөртэйгээр гүйцэтгэж болно.

4.3. Байгууллага, иргэдэд албан бичиг, иргэний үнэмлэхийг үндэслэн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагааг албан бичгээр болон цахим хэлбэрээр хуулбарлан өгч болно.

4.4. Цахим мэдээлэл солилцох системийг ашиглахдаа “Төрийн байгууллагын цахим мэдээллийн сан ашиглах журмыг баримтлана.

4.5. Мэдээлэл, лавлагааг телефон утас, нийгмийн сүлжээгээр өгөхийг хориглоно.

#### **Тав. Мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдал**

5.1. Мэдээллийн нэгдсэн сангийн сервер тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг "Үндэсний Дата төв УТҮГ" хариуцаж хамгаалалт бүхий сүлжээнд байршуулна. Мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хариуцан ажиллах ажилтныг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны зөвшөөрлийг үндэслэн томилно.

5.2. Мэдээллийн нэгдсэн сангийн ашиглалт, үйлчилгээ, мэдээллийн үнэн зөв байдлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба хариуцна.

5.3. Үндэсний дата төв нь мэдээллийг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах болон түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба, бусад байгууллагын албан хаагчдад чиг үүргийн хүрээнд мэргэжил, арга зүй дэмжлэг үзүүлж ажиллана.

5.4. Мэдээллийн нэгдсэн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах ажиллагаа нь Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”, мэдээллийн аюулгүй байдал, технологийн талаарх Монгол Улсын холбогдох стандартад нийцсэн байна.

5.5. Мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх хэрэглэгчид дараах түвшинд хуваагдана.

5.5.1. Төрийн байгууллагын хэрэглэгч

5.5.2. Байгууллагын дотоод хэрэглэгч

5.5.3. Энгийн хэрэглэгч

5.6. Мэдээллийн систем нь тоон болон цахим гарын үсэг ашиглах боломжийг хангасан байх ба байгууллагууд өөрсдийн сонголтоор тоон гарын үсэг ашиглах эсэхийг шийдвэрлэнэ.

## Зургаа. Бусад зүйл

6.1. Байгууллага, иргэдээс мэдээллийн сангаас хийлгэсэн судалгаа, шинжилгээний Үйлчилгээний хөлсний хэмжээ нь холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байвал зохино.

6.1.2. Үйлчилгээний хөлсийг хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээний хөлстэй давхардуулан авахгүй.

6.1.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3.1-д заасан байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд амаар болон цахим хэлбэрээр өгөх мэдээллийг үнэ төлбөргүй өгнө.

6.1.4. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хэвлэх, хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй. Шуудангийн үнийг тооцохдоо “Монгол шуудан” компанийн үнийн тарифыг баримтална.

6.1.5. Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөхдөө энэ журмын 6.1.4-т зааснаас өөр хэлбэрээр үйлчилгээний хөлс авахыг хориглоно.

6.1.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээний хөлсийг төлөхгүй.

6.2. Байгууллагын цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг тухайн байгууллага хэвлэж, олшруулж өгөхгүй.

6.3. Сангийн мэдээ, тайлан, лавлагааг алдаатай гаргасан, хугацаа хожимдуулсан албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын  
үндэсний зөвлөлийн 2019 оны  
1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

## **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ**

### **“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” тухай**

2019 оны 08 сарын 27-ний өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолоор баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлыг 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулав.

Зөвлөлийн хуралд оролцогч Зам, тээврийн хөгжлийн яам, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн эрх, үүрэг”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, анхаарах асуудал”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл, тулгамдаж буй асуудал” илтгэлүүд, Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд заасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан болон түүний төрөлжсөн санг хөтлөх, уг сангаас мэдээлэл, лавлагаа өгөх” журмын төслийг тус тус хэлэлцэв.

Энэхүү хуралдаанаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар тодорхой онолын болон практик үйл ажиллагааны үндэстэй санал, санаачилгуудыг дэвшүүлэн, хэвлэл мэдээллийн төлөөллийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлээ.

### **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хурлаар:**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг буурах хандлагатай байгаа хэдий ч системтэй, онолын үндэстэй үйл ажиллагаа явуулахгүй бол цаашид буцаж нэмэгдэж болзошгүй байгааг тооцож, Монгол Улсын хувьд нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай байна гэдгийг хүлээн зөвшөөрч;

Эрүүл мэнд болон Цагдаагийн байгууллагаас гаргасан гэмт хэргийн талаарх сүүлийн 5 жилийн мэдээлэлд Монгол Улсын хэмжээнд жилд зам тээврийн ослын холбоотой 91514 дуудлага ирж, 32659 осол бүртгэгдэж 1482 гэмт хэрэг үйлдэгдэж, гэмт хэргийн улмаас 512 хүн нас барж, 1300 хүн гэмтэж, 16,1 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь улсын хэмжээний гэмт хэргийн 6,6%, нас барагсдын 45,3%, гэмтсэн хүний 11,1% -ийг эзэлж байгааг анхааралдаа авч;

Зам тээврийн ослын улмаас жилд 19 тэрбум төгрөгийн хохирол учирч байгаа нь улс орны тогтвортой хөгжлийг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна гэдгийг хүлээн зөвшөөрч;

Сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй улс орнууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинжлэх ухааны үндэслэлтэй зорилтот программыг тогтмол хэрэгжүүлсний үр дүнд гэмт хэргийн улмаас нас барах, гэмтэх тохиолдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр багасгасан, мөн энэхүү үйл ажиллагаа нь цаашид аюулгүй амьдралын дадал зуршлыг бий болгоход ач холбогдолтой төдийгүй өндөр хөгжилтэй улс орнуудтай золгүй явдлыг багасгах, зам тээврийн ослоос сэргийлэхэд өргөн хүрээнд тэргүүн туршлага солилцох боломжтой гэдгийг тооцон;

Зам тээврийн ослоос сэргийлэх эрсдэлт хүчин зүйлүүдийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээг дэмжих заавар зөвлөмжийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагад хүргүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж буй байгууллага, иргэдийн ололт амжилтыг тэмдэглэж;

Зам тээврийн ослоос сэргийлэх үйл ажиллагаа, салбар хоорондын хамтын ажиллагааг ханган, иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулан, иргэн, сонирхогч талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч;

Иргэдийн аюулгүй байдал нь төрийн бодлогоос хамааран хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд асар их үр нөлөө үзүүлж болох, зам, тээвэр, байгаль орчин, боловсрол, эрүүлийг хамгаалах, хууль сахиулах стратегид тусгалаа олсон байвал зохих, төр, иргэний нийгэм, иргэдээр дэмжигдэж, эмх цэгцтэй, үр дүнтэй зохион байгуулах цогц асуудал гэдгийг хүлээн зөвшөөрч;

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоо буурсан үзүүлэлттэй хэдий ч амь насаа алдсан хүүхдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь хүүхдэд чиглэсэн цогц үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна гэдгийг онцлон тэмдэглэж;

Улсын хэмжээнд ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн 70-аас дээш хувь нь 10-аас дээш жил ашигласан, 53 хувь баруун талдаа нь жолооны хүрд бүхий тээврийн хэрэгсэл байгаа нь цаашид ямар нэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол ноцтой үр дагаварт хүргэж болохыг онцлон тэмдэглэж;

Нийслэл хотын хүн ам 1,3 саяд хүрч, томоохон хотын тоонд багтаж, Монгол Улсын 1000 хүнд ногдох тээврийн хэрэгслийн тоо 264 байгаа нь автомашинжилт, түүнээс үүдэн гарах хор уршиг нэмэгдэх эрсдэл үүсч байгааг онцлон тэмдэглэж;

Зам тээврийн ослын сүүлийн 5 жилийн статистик мэдээнээс үзэхэд мотоциклтой холбоотойгоор 459 хүн амь насаа алдаж, 928 хүн гэмтсэн нь зам тээврийн ослоор нийт нас барагсдын 18,9%, гэмтэгсдийн 13,2 хувийг эзэлж байгаа нь анхаарал хандуулах асуудал болж байгааг онцлон тэмдэглэж;

Аюулгүй байдлын нөхцөл байдлыг тал бүрээс нь үнэлэн дүгнэж хэлэлцэхийн зэрэгцээ аюулгүй байдлыг сайжруулах талаар олон улсын болон төрийн байгууллагуудаас гаргасан уриалга, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилт, энэ талаар зохион байгуулж байгаа зарим ажил хангалтгүй байгааг дурьдан, "Замын

хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн" хурлаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимтэй сайжруулах, улсын хэмжээнд 2019-2023 онд Зам тээврийн осол, түүний улмаас учрах хохирлын хэмжээг 50 хувь бууруулах зорилтыг дэвшүүлж байна.

Энэхүү зорилтыг ханган үр дүнд хүрэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөмжилж байна. Үүнд:

### **Нэг. Аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн хэм, хэмжээг боловсронгуй болгох талаар**

1.1. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын дараах хуулийн заалтуудыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах:

- "Зөрчлийн болон Эрүүгийн хууль"-ийн төсөлд замын хөдөлгөөний аюулгүй байдалд заналхийлсэн аливаа үйлдэл, эс үйлдэлд ногдуулах шийтгэлийг бүрэн тусгаж, сулруулахгүй байх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэргүүлэх үүрэгтэй Автотээврийн тухай, Нийтийн бус хэрэгцээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай, Замын хөдөлгөөний зохион байгуулалтын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, батлуулах;

- "Авто тээврийн хэрэгслийн үйлчилгээ-Оношлогоо-Хяналт-Зохион байгуулалт"-ын нэгдсэн системийг бий болгох үүднээс Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой олон улсын хэм хэмжээг судлан, шаардлагатай гэрээ хэлэлцээрт нэгдэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжих нөхцөлийг хангах;

- Насжилт өндөр, баруун талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зүй зохистойгоор, иргэн, аж ахуйн нэгжид дарамт учруулахгүйгээр шийдвэрлэх;

- "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар тус бүр батлан хэрэгжүүлэх.

### **Хоёр. Аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар**

2.1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, нутгийн захиргааны байгууллага, Засаг даргаас баталсан дараах журам, захиргааны актуудад нэмэлт өөрчлөлт оруулах:

- Явган хүний гарцын гэрэлтүүлгийн стандартыг шинэчлэн боловсруулж энэ оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

- Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан дүрэм, журам, стандартыг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан салбар, засаг захиргааны нэгж тус бүр төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх;

2.2. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолд заасан жишиг нормативт зааснаар олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу байнгын хяналтын пост, үйлчилгээний төв, зогсоол барих ажлыг зохион байгуулж, авто зам, авто тээврийн болон мэргэжлийн хяналтын, цагдаагийн байгууллагын хяналтыг уялдуулах;

2.3. Их, дээд сургуулиудыг түшиглэн салбар бүрийн оролцоотой зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг судлах баг байгуулж ажиллуулах, тус судалгааны багаас гаргасан дүгнэлт, судалгааг дэмжих, ашиглах талаар тодорхой төрлийн ажлыг зохион байгуулах;

2.4. Мансууруулах бодис, сэтгэл мэдрэлд хүчтэй нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг шалгах аргачлал, техникийн шийдлийг бий болгож Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх;

2.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр оролцогч байгууллагуудтай хамтран тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;

2.6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд төсвийн асуудлыг шийдвэрлэж, судалгаанд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.7. Импортлох мотоциклд тавигдах нөхцөл, шаардлага, стандартыг бий болгох, мотоциклтой холбоотой зам тээврийн ослыг бууруулах талаар цаг үеийн нөхцөлд тохирсон арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх;

2.8. Жолооч бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох.

### **Гурав. Урьдчилан сэргийлэх, судалгаа, сургалт сурталчилгааны ажлын талаар**

3.1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн байдалд болон өсвөр үе, залуучуудын дунд Замын хөдөлгөөний дүрмийн ойлголтын талаар тандалт судалгаа хийх, цаашдын хандлага, шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор криминологи судалгааг мэргэжлийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хийх;

3.2. Зам, тээвэр болон Хууль сахиулах байгууллагын чиг үүрэг хариуцсан ажилтан, албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгөөр тасралтгүй зохион байгуулах;

3.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах шаардлага хангасан

камер, программыг үйл ажиллагаандаа ашиглах, хяналтын камерын байршлын тоо, харах орчныг нэмэгдүүлэх, бичлэгийг чанаржуулах, тодруулах тоног төхөөрөмжтэй телекамерын цогц шийдлийг бий болгох;

3.4. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хурд хэтрүүлэх, хамгаалах хэрэгсэл хэрэглэхгүй байх зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн кампанит ажлыг системтэй, үе шаттайгаагаар зохион байгуулах;

3.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх сургалт суртчилгааны ажлыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй даатгагчдаас Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх.

### **Дөрөв. Олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд**

4.1. Тээврийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлж ажиллах;

4.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг сайтар хангаж, гэмт хэрэг зөрчил гаргахгүй байх талаар урьдчилсан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах, холбогдох байгууллагуудтай хамтран дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

4.3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар тогтоосон хууль эрх зүйн акт, дүрэм журам, стандартуудыг иргэдэд сурталчлан таниулах, сургалтад хамруулах, хэрэгжүүлэх ажлыг анхан шатны нэгжид зохион байгуулах, сургалтын төлөвлөгөө, хуваарь боловсруулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

4.5. Эрх бүхий байгууллагаас баталсан үйлчилгээний ажлын даалгавар, чиглэл, цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэх;

### **Тав. Нийт иргэдэд уриалах нь**

5.1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахаар баталсан хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан өөртөө хамаарах дүрэм, журмыг сайтар баримталж, сахин биелүүлэх;

5.2. Замын хөдөлгөөний ачаалал ихтэй, хүндрэлтэй нөхцөл бий болсон үед бусдад хүндэтгэлтэй, соёлтой, хүлээцтэй хандаж “Та-Би” гэсэн “цахилгаан товчны зарчим”-ашиглан хөдөлгөөнд оролцох;

5.3. Харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед зогсох нь ялангуяа орон нутгийн замд гарах осол хэргийн үндсэн шалтгаан болж байгаа тул гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийг заавал асааж, бусдыг анхааруулах, Замын хөдөлгөөний дүрэмд заасан үүргийг биелүүлэх;

5.4. Холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хориглолт



тогтоосон шалтгаан, нөхцөл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн аливаа техник хэрэгсэл, ажил, үйлчилгээний талаар мэдээлэл авах;

5.5. Аюулгүй байдал хангуулах хууль ёсны шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих, иргэдийн аюулгүй байдалд заналхийлсэн элдэв зүйл байгаа гэж үзвэл холбогдох байгууллага, албан тушаалтанд байгууллагын удирдлагаар дамжуулан эсвэл өөрөө уг асуудлыг шийдвэрлүүлэх;

5.6. Аюулгүй байдлыг хангах талаар иргэдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

## **ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/293

Улаанбаатар хот

Журам, заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үлгэрчилсэн журмыг нэгдүгээр, Эмнэлгийн яаралтай тусламжид үйлчлүүлэгчийг эрэмбэлэх зааврыг хоёрдугаар, Амилуулах суурь тусламжид нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жишиг жагсаалтыг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг байгууллагын батлагдсан төсөвт багтаан зохион байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 дугаар тушаалын тавдугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081409

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
06.сарын 21-өдрийн 1/29 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

### ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

#### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү журмын зорилго нь эмнэлгийн байгууллагын яаралтай тусламж үзүүлэх, зохион байгуулахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.
2. Эмнэлгийн яаралтай тусламж (цаашид яаралтай тусламж гэх) гэж хүний амь насанд аюултай цочмог өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэх зорилгоор, хойшлуулшгүй үзүүлэх тусламж, үйлчилгээг хэлнэ.
3. Яаралтай тусламжийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллагууд үзүүлнэ.
4. Эмнэлгийн болон төрөх үеийн яаралтай тусламжийг тухайн иргэнд ойр байгаа эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.
5. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллагууд бүтэц, үйл ажиллагааны стандарт, тусламж, үйлчилгээний төрөл, чиглэл, үйлчлэх хүрээний хүн амын тоонд үндэслэн энэхүү журам болон бусад холбогдох хууль эрх зүй, байгууллагын өвөрмөц орчин, нөхцөлд нийцүүлэн яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах журам баталж, мөрдүүлнэ

#### ХОЁР. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИД БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ЗАРЧИМ.

1. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд амь насанд нь учирч буй эрсдэл өндөртэй үйлчлүүлэгчээс эхэлж үзүүлэх эрэмбэллийн зарчим баримтална.
2. Амь нас нь эрсдэх магадлал өндөртэй байгаа үйлчлүүлэгчийг эмнэлгийн байгууллага **тусч үйлчлэх нийтлэг** зарчимтай байна.
3. Яаралтай тусламжийг хүнлэг, энэрэнгүй, шашин шүтлэг, үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал, үүслээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид, үйлчлүүлэгч түүний гэр бүлд ээлтэй, нээлттэй, хүний эрх, аюулгүй байдлыг нь дээдэлсэн хувийн нууцыг нь хадгалах зарчимтай байна.
4. Үйлчилгээ үзүүлэгч нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм, хэмжээг баримтална.
5. Яаралтай тусламж үйлчилгээ нь шуурхай, тоног төхөөрөмж, хүн хүч, машин, техник, хэрэгслийн 24 цагийн бэлэн байдлын зарчимтай байна.

## ГУРАВ. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ОРЧИН

### 3.1 Гадна орчин.

Эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн хэсгийн гаднах орчин нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1 Үйлчлүүлэгч түргэн тусламжийн машинаар болон өөрөө ирж тусламж авах боломжтой, эмнэлгийн байгууллагын нэгдүгээр давхарт байрлалтай байна.
- 3.1.2 Хаалга буюу орох хэсэг нь сайтар ялгагдахуйц хаяг, гэрэлтүүлэгтэй, цаг агаарын таагүй нөхцөлөөс тусгаарлагдсан, хүрч очих замыг тодорхой харуулсан тэмдэг, тэмдэглэгээтэй байна.
- 3.1.3 Тэргэнцэр, дамнуургатай үйлчлүүлэгчийг саадгүй зөөвөрлөх зориулалтын, өргөн хаалгатай, налуу замтай байна.
- 3.1.4 Үйлчлүүлэгч орох болон гарах урсгал бие биедээ саад учруулахааргүй, амь тэнссэн, халдварт өвчний эрсдэлтэй үйлчлүүлэгчийг хүлээн авах чиглэлийг заасан дуугүй хөтөч, тусгаарлал бүхий зохион байгуулалттай байна.
- 3.1.4 Үйлчлүүлэгч зөөвөрлөх тэргэнцэр, дамнуургуудыг ариутган, хэрэглээнд ойрхон, бэлэн байдалтай байршуулсан байна.
- 3.1.5 Нэгдсэн эмнэлэг, тусгай эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь түргэн тусламжийн машины орц, гарц, үйлчлүүлэгчийн автомашины зогсоол, онгоц, нисдэг тэрэг газардах хэсгийг тусгайлан зохион байгуулсан байгууламж, хэсгүүдтэй байж болно.

### 3.2 Дотоод орчин.

#### 3.2.1 Үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим:

- 3.2.1.2 Үйлчлүүлэгч болон гэр бүлийн гишүүдэд зориулсан хүлээлэг, мэдээллийн танхимтай байна.
- 3.2.1.3 Энэхүү танхим нь үзлэг, эмчилгээний цаг, (утсаар, цахимаар, биечлэн) дугаар авах хэсэгтэй, үйлчлүүлэгчийн дараалал, үзүүлэх тусламж, үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээллийн урсгалыг нээлттэй, ил тод байрлуулсан байна.
- 3.2.1.4 Үйлчлүүлэгч ба тэдгээрийн ар гэрийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох үзүүлэн, самбар, эмнэлгийн дотоод зохион байгуулалтын зураглал байрлуулахаас гадна, үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтнүүдийн товч, танилцуулга, үйлчилгээний хуваарийг байрлуулсан байна.
- 3.2.1.5 Үйлчлүүлэгчийн хүлээлгийн сандал нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүрэлцээтэй тооны, хөнгөн зууш, ундаагаар үйлчлэх хэсэг, холбоо барих утасны үйлчилгээтэй, ариун цэврийн өрөө, хувцасны өлгүүр, хувцас хадгалах хэсэгтэй байна.

3.2.1.6 Хүүхдийн тусламж үзүүлдэг эмнэлэгт хүүхэд саатуулах хэсэг, хүүхдэд зориулсан сандал, ширээтэй байна.

### **3.2.2 Тусгаарлах өрөө.**

3.2.2.1 Тусгаарлах өрөө нь үйлчлүүлэгчийг халдварт өвчинтэй гэж сэжиглэсэн, оношилсон тохиолдолд тусгаарлан сэргийлж, халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор зохион байгуулагдсан байна.

3.2.2.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан "Тусгаарлан сэргийлэлтийн заавар"-ыг мөрдлөг болгон ажиллах нөхцөл бүрдүүлсэн байна.

3.2.2.3 Тусгаарлах өрөө нь агааржуулалтын системтэй, зориулалтын ор, бусад туслах хэрэгслээр хангагдсан, дохиоллын системтэй, халдвартай хувцас хэрэгсэл, ариун хувцас хэрэгслийн өрөө тусдаа, урсгал нь нэг чигийн зохион байгуулалттай байна.

3.2.2.4 Ариун цэврийн өрөө нь үйлчлүүлэгчид асаргаа, сувилгааны тусламж үзүүлэх нөхцөлөөр бүрэн хангагдсан байна.

3.2.2.5 Хасах даралт бүхий тусгаарлах өрөөний дотор даралтыг гаднаас хэмжиж тэмдэглэж, хянах бололцоо бүрдүүлж, даралтыг энгийн өрөөнөөс бага түвшинд байлгана.

### **3.2.3 Яаралтай тусламжийн тасаг, нэгжийн ерөнхий зохион байгуулалт.**

3.2.3.1 Яаралтай тусламжийн тасаг, нэгжийн зохион байгуулалтыг тухайн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт, байгууллагын хүчин чадал, нөөц, үйлчлэх хүрээний хүн амтай уялдуулан зохион байгуулна.

3.2.3.2 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад заасан тоо, чанарын шаардлагад үндэслэн яаралтай тусламж үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, холбоо, мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг бүрэн хангасан байна.

3.2.3.3 Яаралтай тусламжийн тасаг, нэгж нь эмчилгээ, оношилгооны бусад тасаг (дүрс, оношилгоо, хэт авиа, рентген, компьютер томограф, эрчимт эмчилгээ, мэс засал, гэмтэл, эх барихын тасаг) нэгжүүдэд ойрхон байрласан эсвэл үйлчлүүлэгчийг зөөвөрлөхөд цаг алдахгүй, саадгүй байхаар зохион байгуулсан байна.

3.2.3.4 Халдварын сэргийлэлт, хяналтыг холбогдох, дүрэм, зааварт нийцүүлэн бүрдүүлж, гүйцэтгэх, үнэлэх, хяналт тавих тогтолцоотой байна.

3.2.3.5 Үйлчлүүлэгчийг тэргэнцрээр зөөвөрлөх зам дагуу болон тасаг нэгжийн өрөө, тасалгааны босго өндөрлөгөөгүй, хаалгыг тогтоон барих бэхэлгээтэй байна.

3.2.3.6 Яаралтай тусламжийн тасаг нь дараах үндсэн болон бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:



- Үйлчлүүлэгчийг угтах, эрэмбэлэх, лавлагаа мэдээллийн хэсэг,
  - Үзлэг, ажилбарын, амилуулах тусламж, бичил мэс ажилбарын өрөө,
  - Онош тодруулах, хяналт, эмчилгээний, телемедициний хэсэг,
  - Тусгаарлах өрөөнүүд,
  - Нөөцийн өрөө (эм урвалж, ариун материал, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, төхөөрөмж, лабораторийн түргэвчилсэн оношилгооны багаж, хэрэгсэл хадгалах)
  - Хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, ариутгал, угаалгын хэсэг,
  - Ариун цэврийн (үйлчлүүлэгчийн, ар гэрийн, ажилчдын зэрэг зориулалтын хэсгүүдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй бариул, налуу замтай байна)
- 3.2.3.7 Үйлчлүүлэгчийн ор тус бүр тусгаарлах хөшигтэй, стандартад заасан зай талбайн хэмжээг баримталсан байна.
- 3.2.3.8 Яаралтай тусламжийн тасаг нь 12 холболттой зүрхний цахилгаан бичлэг, хэт авиан оношилгоо, зөөврийн рентген аппаратаар оношилгоо хийх боломжоор хангагдсан байна.
- 3.2.3.9 Яаралтай тусламжийн ор нь эмчилгээ оношилгоо хийх, үйлчлүүлэгчийг зөөвөрлөх боломжтой, ханын хийн систем, хүчилтөрөгч, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, амьсгал, зүрх судасны монитор, амьсгалын аппарат болон бусад шаардлагатай эмнэлгийн хэрэгслээр тоноглогдсон байна.
- 3.2.3.10 Үйлчлүүлэгчийн орны дэргэд яаралтай тусламжид шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн зориулалтын хөдөлгөөнт тэргэнцэрийг байрлуулсан байх ба тусламж, үйлчилгээний онцлогт нийцүүлэн нэмэлт шаардлагатай тоног төхөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан байна.
- 3.2.3.11 Тухайн стандартад заасан хүний нөөц, эм, урвалж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг холбогдох журамд нийцүүлэн бүрдүүлж, хүчинтэй байдалд нь бүртгэл хийж, тодотгол хийх тогтолцоотой байна.
- 3.2.3.12 Эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал, нөөцөд тулгуурлан яаралтай тусламжийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, мэдээллийн, номын сан, эмнэлгийн мэргэжилтний амрах болон бусад зориулалтын өрөө тасалгааг олон улсын түвшинтэй дүйцүүлэн зохион байгуулж болно.
- 3.2.3.13 Хүлээлгийн хэсэг (Үйлчлүүлэгчийн сахиур, ар гэрийнхэнд зориулсан өрөө болон үйлчилгээний онцлог, байгууллагын нөөцөөс хамаарсан бусад зориулалтын өрөө, тасалгаа) -тэй байна).
- 3.2.3.14 Түргэн тусламжийн дуудлага хүлээн авах, түргэн тусламжаар ирж буй үйлчлүүлэгчийг хүлээн авах хэсэг,
- 3.2.3.15 Эмнэлэг хүртэлх яаралтай тусламж /түргэн тусламжийн машин/-тай холбогдож зөөвөрлөж байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдалтай танилцах, зөвлөгөө өгөх, угтан авч яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн баг (rapid

response team)-ийг зохион байгуулж, бэлэн байдлыг хангасн зохион байгуулалттай байна.

#### **ДӨРӨВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.**

- 4.1 Яаралтай тусламжийн тасаг, нэгжийн удирдлага нь байгууллагын удирдлагын зөвлөлийн гишүүн байх бөгөөд, тасгийн үйл ажиллагаа, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай байна.
- 4.2 Яаралтай тусламжийн тасаг нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий, эмнэлгийн яаралтай тусламжаар мэргэшсэн эмч, сувилагчтай байх ба тусламж, үйлчилгээний шатлал, төрөл, онцлогоос хамааран шаардлагатай бол бусад төрөлжсөн мэргэшлийн /мэс засал, дүрс оношлогооны, эх барих, хүүхэд,/ эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй байж болно.
- 4.3 Тасгийн бүх мэргэжилтэн, ажилтнуудын үүрэг, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, дүрэмд тусган, баталгаажуулж, хэрэгжүүлж ажиллана.
- 4.4 Халдварт өвчний дэгдэлт, олныг хамарсан гамшиг, осол нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, бэлэн байдлын төлөвлөгөө, яаралтай үед дуудагдаж ажиллах мэргэжлийн багийг томилгоожуулсан байна.
- 4.5 Тасгийн бүх ажилтнууд амилуулах суурь тусламжийн сургалтанд хамрагдсан, шаардлагатай үед тусламжийг бие даан үзүүлэх, бусдад сургах чадвартай байна.
- 4.6 Яаралтай тусламжийн тасаг нь түргэн тусламжийн дуудлага, хүлээн авах, зохицуулах үүрэг бүхий мэргэжилтэнтэй үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй байна.

#### **ТАВ. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

- 5.1 Яаралтай тусламжийг аюулгүй, нотолгоонд суурилсан, эмчилгээний хамгийн сүүлийн үеийн шинэлэг арга, технологи баримтлан үзүүлнэ.
- 5.2 Яаралтай тусламж, үйлчилгээг 24 цагийн турш тасралтгүй үзүүлэх байнгын бэлэн байдлыг хангасан байна.
- 5.3 Яаралтай тусламжийн эмч, сувилагч үйлчлүүлэгчийг угтан авч, бүртгэл, хяналтын картад бүртгэн, анхны үзлэгээр амин үзүүлэлт, эмгэг шинжүүдийг тодорхойлон, эрэмбэлж, шаардагдах тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулна.
- 5.4 Анхан шатны бүртгэл, хяналтын хуудсыг 2 хувь үйлдэж, үндсэн хувийг эмнэлгийн баримтад, 2 дахь хувийг үйлчлүүлэгчийг шилжүүлсэн буюу гэрт нь буцаасан тохиолдолд хамт хүргүүлнэ.

- 5.5 Үйлчлүүлэгчийн амь тэнссэн байдал, амин үзүүлэлт тогтворжсоны дараа үргэлжлүүлэн холбогдох тасагт, өөр эмнэлэгт эсвэл гэрт нь, өрхийн эмчийн хяналтад шилжүүлэхийг шийдвэрлэнэ.
- 5.6 Үйлчлүүлэгчийн нэр хаяг нь тодорхойгүй, өөрөө мэдүүлэг өгөх боломжгүй, амин үзүүлэлтүүд, болон зүрх зогссон байдалтай эмнэлэгт ирээд нас барсан тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдээлэх, шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна
- 5.7 Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь гадны нөлөөтэй үүсгэгдсэн "гэмт хэргийн шинжтэй" бол цагдаагийн байгууллагад мэдээлнэ.
- 5.8 Амилуулах тусламж шаардлагатай үйлчлүүлэгчид шууд амилуулах лавшруулсан тусламж үзүүлж, эрчимт эмчилгээний тасагт шилжүүлнэ.
- 5.9 Үйлчлүүлэгчийн өвчний оношийг богино хугацаанд тогтоох боломжгүй нөхцөлд хяналт, эмчилгээний хэсэгт шилжүүлж, холбогдох шинжилгээг шуурхай хийж, эмчлэгч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарын хамтарсан зөвлөгөөнөөр асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.10 Ажлын цагаар төрөлжсөн мэргэшлийн эмч, зөвлөх эмч, эмч нарын багийг, ажлын бус цагаар жижүүр эмч дуудаж зөвлөгөө авах болон хамтарсан зөвлөгөөн хийж шийдвэрлэнэ.
- 5.11 Халдварт өвчний сэжигтэй үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөнд авч, халдварын сэргийлэлт, хяналт, шинэ болон сэргэж буй халдварт өвчний үед ажиллах журам болон бусад холбогдох журамыг баримталж ажиллана.
- 5.12 Эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн үйлчилгээний багаас мэдээлэл хүлээн авч амилуулах суурь болон амилуулах лавшруулсан тусламжийн зөвлөгөө, мэдээлэл өгч, тосч үйлчлэх бэлэн байдлыг хангаж ажиллана.
- 5.13 Үйлүүлэгч нас барсан тохиолдолд ажлын цагаар тасгийн эрхлэгчид танилцуулж эмнэлзүй эрхэлсэн дэд захирлаар, ажлын бус болон амралтын өдрүүдэд жижүүрийн ахлах эмчээр баталгаажуулж эмгэг анатомийн задлан шинжилгээнд яаралтай тусламжийн хуудасд тэмдэглэн оруулна.
- 5.14 Үйлчлүүлэгчийг хүлээж авсанаас эхлэн гэрт нь гаргах буюу шилжүүлэх хүртэлх тусламж, үйлчилгээний үйл явцыг үйлчлүүлэгч, түүний ар гэрт шуурхай, ил тод ойлгомжтой мэдээлж, байнгын холбоотой ажиллана.
- 5.15 Эрүүл мэндийн байгууллага нь холбогдох эмнэлзүйн заавар, удирдамжид заасан тусламж, үйлчилгээг үзүүлэх, шилжүүлэх, гаргах шалгуурыг баримталж ажиллана.
- 5.16 Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн яаралтай тусламжид хүлээн авсан нийт үйлчлүүлэгч, зөвлөгөө өгч буцаасан болон өөр эмнэлэгт шилжүүлсэн үйлчлүүлэгч, хэвтүүлэн эмчилж гаргасан үйлчлүүлэгчийн цахим бүртгэл, мэдээллийн сантай байна.



**ЗУРГАА. ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ**

- 6.1 Өрхийн эрүүл мэндийн төв нь яаралтай, амь нас нь тэнссэн зайлшгүй шаардлагаар хандсан үйлчлүүлэгчийг харьяалал харгалзахгүй хүлээн авч, эрэмбэлэн, эмнэлгийн анхны болон амилуулах суурь тусламж үзүүлнэ.
- 6.2 Үйлчлүүлэгчийн амь нас тэнссэн байдал, амин үзүүлэлтийг тогтворжуулах арга хэмжээг шуурхай авч, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад хүргэх, боломжгүй нөхцөлд түргэн тусламж дуудан холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.
- 6.3 Зайлшгүй шаардлагаар төрөлжсөн мэргэшлийн эмч дуудаж тусламж, үйлчилгээг хамтран үзүүлэх арга хэмжээг авна.
- 6.4 Өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүд эмнэлгийн яаралтай тусламжийн сургалтанд хамрагдаж, төгсөлтийн дараах багц цагийн сургалтын нэг кредит нь яаралтай тусламжийн чиглэлтэй байна.
- 6.5 Яаралтай тусламжийн мэдлэг, мэргэшлээ байнга дээшлүүлж, анхны тусламж, амилуулах суурь тусламж үзүүлэх ур чадвараа дээшлүүлж ажиллана.
- 6.6 Өрхийн эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа яаралтай тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээг журамлан тусгаж, хэрэгжүүлж ажиллана.
- 6.7 Харьяа, үйлчлэх хүрээний хүн амд яаралтай тусламж үзүүлэх тээврийн хэрэгсэл, эм, тариа багаж, хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг холбогдох журам, стандартад нийцүүлэн хангаж ажиллана.
- 6.8 Харьяа хүн амд олныг хамарсан болзошгүй халдварт өвчин, осол гэмтэл, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөтэй, хүч хэрэгслийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, жил бүр тодотгол хийж ажиллана.

**ДОЛОО. ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛЭЭРХ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭ.**

- 7.1 Хүүхдийн амилуулах суурь тусламж, үйлчилгээ, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний эмнэлзүйн зааврыг холбогдох лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох хууль эрх зүйд нийцүүлэн баталж, мөрдүүлнэ.
- 7.2 Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага нь төрөлжсөн мэргэшил, тусгай мэргэжлийн яаралтай тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, удирдамж боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
06.сарын 11. өдрийн 417 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ  
ЭРЭМБЭЛЭХ ЗААВАР**

**НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ.**

1.1 Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлт, эмнэл зүйн шинж тэмдгийг үндэслэн нэн түрүүнд тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай эрэмбийг тогтоож, үр дүнтэй, оновчтой тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх арга, ажиллагаа.

**ХОЁР. ЗОРИЛГО.**

2.1 Үйлчлүүлэгчийн биеийн байдал, амин үзүүлэлт, эмнэлзүйн шинж тэмдгийг үндэслэн эмнэлгийн яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэх,

2.2 Эмнэлгийн яаралтай тусламж, шаардлагатай үйлчлүүлэгч олноор ирэх тохиолдолд хүн хүчний болон эмнэлгийн бусад нөөцийг зөв зохистой ашиглах.

**ГУРАВ. ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЗАРЧИМ.**

1. Яаралтай тусламжийн эрэмбэлэл нь өвчнийг оношлох бус биеийн байдлыг үнэлэх зарчимд тулгуурлана.
2. Гэнэтийн өвчин, осол гэмтэл, хордлогод өртсөн, амь нас нь тэнссэн үйлчлүүлэгчид яаралтай тусламжийг нэн түрүүнд үзүүлэх зарчмыг баримталж ажиллана.
3. Эрэмбэллийг үйлчлүүлэгчийг хүлээж авснаас хойш 5 минутын дотор хийж гүйцэтгэнэ.
4. Тухайн эрэмбэд холбогдох өнгийн туузыг үйлчлүүлэгчийн биеийн нүдэнд ил үзэгдэх хэсэг, гарын шуу, хүзүү, эсвэл шарх, гэмтэлгүй хэсэгт зүүж, тэмдэглэнэ.

**Дөрөв. ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ.**

4.1 Эрэмбэ НЭГ буюу [REDACTED] ялгах тэмдэг бүхий нэгдүгээр зэрэглэлд хамаарах шинж тэмдэг:

- 4.1.1 Амь нас эрсдэх, амин эрхтэний үйл ажиллагаа зогсох аюул шууд заналхийлсэн, эмнэлгийн сэхээн амьдруулах хойшлуулшгүй тусламжийг 2-5 минутын дотор үзүүлж эхлэх шаардлагатай

тохиолдлууд хамаарна.

4.1.2 Уг эрэмбэд хамрагдах эмнэлзүйн хам шинжүүд. Үүнд:

- Ухаангүй, өвтгөхөд мэдрэнэ,
- Зүрхний цохилт минутанд <40 эсвэл> 180,
- Амьсгал боогдсон, хаагдсан,
- Амьсгалын тоо 1 минутанд <8 эсвэл> 50;
- Артерийн систолийн даралт <60 эсвэл> 200 мм.рт.ст,
- Таталттай,
- Орчиндоо аюул учруулж болзошгүй сэтгэцийн гүнзгий хямралтай.

4.2 **Эрэмбэ ХОЁР** буюу шар өнгийн ялгах тэмдэг бүхий хоёрдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:

4.2.1 Амин эрхтэний үйл ажиллагаа ноцтой алдагдсан, цаашид амь нас эрсдэх өндөр магадлалтай үйлчлүүлэгчид эмнэлгийн яаралтай болон эрчимтэй эмчилгээг 10 минутын дотор үзүүлж эхлэх шаардлагатай тохиолдлууд хамаарна.

4.2.2 Уг эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна. Үүнд:

- Ухаангүй, дуудахад сэргэнэ эсвэл догшрол;
- Амьсгал бачуурч хяхнасан;
- Амьсгалын тоо 1 минутанд <9-10 эсвэл> 35-49;
- Арьс зэвхийрч эрээнтсэн, хөл гарын үзүүр хүйтэн;
- Зүрхний цохилт 1 минутанд <41-50 эсвэл> 141-179;
- Цусны эргэлтийн дутагдлын гаралтай артерийн систолийн даралт унасан <61 -75> мм.рт.ст;
- Цус их алдсан;
- Зүрхний орчимд цээжээр өвдөх;
- Гэнэтийн гемипарез;
- Халуурч ухаан алдсан, татсан;
- Нүдэнд хүчил шүлт орсон
- Хүнд бэртэл гэмтэл;
- Маш хүчтэй өвдөлт;
- Нойрсуулах болон хортой эм ууж хордсон, ухаангүй;
- Хүчтэй өвдөлттэй умайн гаднах жирэмслэлт;
- Өөртөө болон бусдад аюултай сэтгэцийн догшин байдал, хурц
- Солиорол эсвэл эмгэг сэтгэхүй.

4.3 **Эрэмбэ ГУРАВ** буюу ногоон өнгийн ялгах тэмдэг бүхий гуравдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:

4.3.1 Аль нэгэн эрхтэн системийн үйл ажиллагааны ээнэгшилт алдагдаагүй,

эмнэлгийн тусламж үйлчилгээг 30 минутаас 1 цаг хүртэл хугацаагаар хүлээх бололцоотой тохиолдлуудыг хамруулна.

4.3.2 Уг эрэмбэд дараах эмнэлзүйн хам шинжүүд хамаарна. Үүнд:

- Орчиндоо харьцаа суларч, самуурсан;
- Амьсгал давхцан уухилсан, шуугисан;
- Амьсгалын тоо 1 минутанд <11-14 эсвэл> 24-34;
- Зүрхний цохилт 1 минутанд <51-60 эсвэл> 111-140;
- Артерийн систолийн даралт огцом ихэссэн 150-179 мм.рт. ст;
- Дунд ба хөнгөн зэргийн цус алдалт;
- Ухаан алдалтгүй, биеийн булчингийн зарим хэсгийн таталт;
- Шингэн алдалт;
- Хүчтэй өвдөлтүүд, анальгетик шаардлагатай;
- Эрсдэл багатай эсвэл 65-аас дээш насныхны хэвлийн цочмог өвдөлтүүд;
- Мөчдийн гэмтэл, битүү гэмтэл;
- Амьсгалын дутагдалгүй цээжний гэмтэл, гадны биетээр үүссэн аспираци
- Толгойн хөнгөн гэмтэл;
- Үе хавдаж бүлээн болох;
- Бариу чиг, гөлтгөнө тавигдсан байдал
- Мөчдийн хураагуур судасны лугшилт гэнэт алга болсон;
- Гадны биетийн улмаас нүд үрэвссэн, хараа хэвийн;
- Суулгалт, бөөлжилт;
- Сэтгэл хямарсан, амиа хорлохыг завдсан, сандарч тэвдсэн (үг дуугүй)
- Сэтгэц зан төрхийн бусад өөрчлөлтүүд

**ТАВ. ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЭРЭМБЭЛЛИЙН ТОВЧООН**

№	Үзүүлэлт	Эрэмбэ 1 / улаан/	Эрэмбэ 2 / шар/	Эрэмбэ 3 / ногоон/	Эрэмбэ 4 / цагаан/
1	Өвчтөнд үнэлгээ, яаралтай тусламж үзүүлж эхлэх хугацаа	2-5 минут	10 минут	30-60 минут	120 минут гэрт буцаах
2	Төв мэдрэлийн систем, ухаан санааны байдал	Ухаангүй, өвтгөхөд сэргэнэ	Ухаангүй, дуудахад сэргэнэ, догшрол	Орчиндоо харьцаа сул, самуурсан	Ухаантай, хэвийн харьцаатай

3	Амьсгалын зам	боогдсон, хаагдсан	бачуурсан, хяхнасан	уухилсан, шуугисан	чөлөөтэй	
4	Амьсгалын тоо 1 минутад	>50	35-49	24-34	хэвийн 12-24	
5		<80	9-10	11-14		
6	Судасны лугшилтын тоо 1 минутад	олширсон:	>180	141-179	111-140	хэвийн 60-110
7		цөөрсөн:	<40	41-50	51-60	
8	Систолийн даралт мм.рт.ст	нэмэгдсэн:	>200	180-199	150-179	хэвийн 60- 110



Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
.06.сарын 21-өдрийн А/А дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт

**АМИЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖИД НЭН ШААРДЛАГАТАЙ ЭМ, ЭМНЭЛГИЙН  
ХЭРЭГСЛИЙН ЖИШИГ ЖАГСААЛТ**

№	Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл		Төрөл, тоо Тус бүр 2-оос дээш хэмжээний нөөц бүрдүүлсэн байна.
1	Амьсгалын зам чөлөөлөх хэрэгсэл	Амьсгалын зам чөлөөлөх хэрэгсэл /ам,хамраар агаар оруулагч/	Нялхас, хүүхдийн, насанд хүрэгчдийн/
		Соруулах хэрэгсэл	Хүүхэд болон насанд хүрэгчдийн
		Соруулгын гуурс	Жижиг, том
2	Амьсгал дэмжих	Амбуны хошуувч	Нялхас, хүүхэд, насанд хүрэгсэд
		Амбу	Хүүхэд насанд хүрэгчид
3	Цусны эргэлт дэмжих	Тарилгын иж бүрдэл	Тариур /3-20/ мл Дуслын систем
		Спирттэй хөвөн	Шаардлагатай хэмжээгээр
		Чангалуур	Хүүхэд, насанд хүрэгчид
		Судасны гуурс	18G, 20G, 22 G, 24G
		Эпинефрин	1мг/1мл-5 туншил
		Натри хлоридын уусмал	0,9%-500мл-10 уут
4	Дефибриллятор	Глюкозын уусмал	10%
		AED (автомат тохируулгат дефибриллятор)	Мэргэжлийн болон энгийн байж болно
5	Бусад	Ариутгалын уусмалууд	Шаардлагатай хэмжээгээр
		Амилуулах тусламжийн дарааллыг харуулсан хуудас, зөвлөмж, заавар	Шаардлагатай газруудад байрлуулах
		Хүчилтөрөгчийн бортого	(5-10л багтаамжтай) урсгал тохируулагчийн хамт
		Хүчилтөрөгчийн хошуувч, хамрын хос гуурс	Тус бүр 2-оос дээш хүрэлцээтэй нөөцтэй
		Даралтны аппарат	хүрэлцээтэй нөөцтэй
		Чагнуур	хүрэлцээтэй нөөцтэй
		Пульсоксиметр	хүрэлцээтэй нөөцтэй
		Цусны глюкоз хэмжигч	хүрэлцээтэй нөөцтэй
		Биеийн дулаан хэмжигч	хүрэлцээтэй нөөцтэй



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/294

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Түргэн тусламжийн үйлчилгээг зохион байгуулах үлгэрчилсэн журмыг нэгдүгээр, Түргэн тусламжийн үйлчилгээнд хэрэглэгдэх эм, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хоёрдугаар, Болзошгүй гамшиг, олныг хамарсан ослын үеийн эрэмбэллийн зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, батлагдсан төсөвт багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий түргэн тусламжийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгийн дарга, захирал нар т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг зохицуулж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/, Нийслэлийн эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

031413



## ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Гэнэтийн цочмог өвчин, эмгэг, осол гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх үйлчилгээг түргэн тусламжийн үйлчилгээ гэнэ.
- 1.2 Түргэн тусламжийн үйлчилгээг үйлчлүүлэгчид хамгийн ойр байгаа тусгай зөвшөөрөл бүхий түргэн тусламжийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өмчийн бүх хэлбэрийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг үзүүлнэ.
- 1.3 Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн болон тухайн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг холбогдох эмнэлзүйн заавар, удирдамжийг баримтлан үзүүлнэ.
- 1.4 Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх журмыг энэхүү журам болон холбогдох бусад хууль, эрх зүйн хүрээнд тусламж, үйлчилгээнийхээ өвөрмөц онцлогт нийцүүлэн баталж, мөрдөж ажиллана.
- 1.5 Түргэн тусламжийн үйлчилгээнд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан бүртгэл, хяналтын хуудсыг хөтлөнө.
- 1.6 Эрүүл мэндийн байгууллага нь болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед түргэн тусламжийн шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллана.

### ХОЁР. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1 Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдлыг дээдэлнэ.
- 2.2 Хүнлэг энэрэнгүй байна.
- 2.3 Шашин шүтлэг, үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн байдал, гарал, үүслээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид байна.
- 2.4 Тусламж, үйлчилгээний бэлэн, шуурхай, аюулгүй байдлын зарчмыг баримтална.
- 2.5 Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм, хэмжээг чанд баримтална.



**ГУРАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1 Эрүүл мэндийн байгууллага нь иргэд, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд эмнэлгийн анхан болон амилуулах суурь тусламжийн мэдлэг олгох, чадавхижуулах сургалт явуулах нийтлэг үүрэгтэй.
- 3.2 Эрүүл мэндийн байгууллага нь хүчин чадал, нөөц боломжид үндэслэн агаарын тээврийн зориулалтын талбайтай, агаарын тээврийн хэрэгслээр түргэн тусламж үзүүлэх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэн ажиллаж болно.
- 3.3 Байгууллагын түргэн тусламжийн үйл ажиллагааны журамд дараах нийтлэг зохицуулалтыг тусган хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 3.3.1 Түргэн тусламжийн үйлчилгээ нь 24 цагийн бэлэн байдлыг хангасан, түргэн тусламжийн дуудлага зохицуулагч (цаашид дуудлага зохицуулагч гэх), тусламж, үйлчилгээг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх мэргэшсэн дуудлагын баг (цаашид дуудлагын баг гэх)-тай байна.
  - 3.3.2 Дуудлага зохицуулагч нь дуудлага хүлээн авч, бүртгэж, мэдээлэх, багийг хуваарилах үүрэг бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтэн байна.
  - 3.3.3 Дуудлагын багийн үндсэн үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчид шаардлагатай тусламжийг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад багийн зохион байгуулалтаар үзүүлэн яаралтай тусламжийн тасагт хүлээлгэн өгөх үйл ажиллагаа болно.
  - 3.3.4 Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул учрах эрсдэлтэй тохиолдолд холбогдох эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт тээвэрлэх явцад мэдэгдэн, бэлэн байдлыг хангуулж, гараас гарт хүлээлгэн өгнө.
  - 3.3.5 Дуудлагын баг нь түргэн тусламжийг газар дээр нь болон, тээвэрлэлтийн явцад үзүүлэхдээ эмнэлгийн яаралтай тусламжийн эмч, зөвлөх эмч, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлсэн байна
  - 3.3.6 Дуудлагын баг нь түргэн тусламжийн үйлчилгээнд холбогдох баримт бичиг, зөвшөөрөгдсөн бүртгэл, хяналтын хуудсуудыг бүрэн хөтөлсөн байна.
  - 3.3.7 Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тогтмол авч ажиллана.
  - 3.3.8 Дуудлагын багийг халдварын эрсдэл, цаг агаарын халуун, хүйтэн нөхцөл, химийн хорт бодис, бусад хүндрэлтэй нөхцөл байдалд ажиллах хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангасан байна.
  - 3.3.9 Түргэн тусламжийн үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ижил бүтэц, үүрэг, хариуцлага хүлээж оролцоно.
  - 3.3.10 Бүртгэлтэй дуудлагаас бусад тохиолдолд эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, дуудлага өгөх эрх бүхий албан тушаалтан, шийдвэр гаргах шатны байгууллагын гаргасан шийдвэрээс бусад тохиолдолд түргэн тусламжийн баг ажиллуулах, үзүүлсэн тусламж үйлчилгээтэй холбогдолгүй асуудлаар

магадлагаа, дүгнэлт гаргах, зөвшөөрөгдөөгүй эмийн жор бичихийг түргэн тусламжийн үйлчилгээнд хориглоно.

#### **ДӨРӨВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АВТОМАШИН.**

- 4.1 Түргэн тусламжийн үйлчилгээг “MNS 6717:2018” үндэсний стандартад заасан, туулах чадвар сайтай, өвчтөн тээвэрлэх тоноглол бүхий зориулалтын автомашинаар үзүүлнэ.
- 4.2 Эрүүл мэндийн байгууллага нь түргэн тусламжийн автомашины ашиглалт, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шаардлагатай шинэчлэлийг хийж ажиллана.
- 4.3 Эрүүл мэндийн байгууллагууд түргэн тусламжийн автомашины хэрэглээнд халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлан, хяналт тавьж ажиллана.
- 4.4 Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь холбогдох журамд заасан жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж, тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 4.5 Дуудлагын баг нь түргэн тусламжийн үйлчилгээнд гарахын өмнө болон дараа жолооч, автомашины аюулгүй ажиллагааны хяналтын хуудсыг хөтөлж хэвшүүлсэн байна.

#### **ТАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГЫН ТӨРӨЛ.**

Дуудлага зохицуулагч түргэн тусламжийн дуудлагыг хүлээн авч, дараах байдлаар ангилан, холбогдох зохицуулалтыг хийнэ. Үүнд:

- 5.1 **Яаралтай дуудлага.** Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдалтай, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн өгүүлэмжтэй бол дуудлага өгсөн байршилд 20 минутаас хэтрэхгүй хугацаанд тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх зохицуулалт хийннэ.
- 5.2 **Хүлээгдэлтэй дуудлага:** Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул занал учруулахуйц шинж тэмдэггүй бол 20-60 минутад тусламж, үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг хийнэ.
- 5.3 **Дуудлагын алслагдмал байдлаас хамаарах дуудлагын төрөл:**
  - 5.3.1 Ирүүлсэн дуудлага түргэн тусламж үзүүлэх багаас 25 км дотор байршилд бол ***ойрын дуудлага***,
  - 5.3.2 Ирүүлсэн дуудлага 25 км-аас дээш алслагдсан байршилд бол ***холын дуудлагад*** бүртгэн, хүрч очих боломжит хугацааг тодорхойлж, дуудлага өгсөн иргэнд мэдэгдэн, дуудлагын баг очих хүртэл авах арга хэмжээний зөвлөгөө өгч, өгсөн зөвлөгөө, авсан арга хэмжээг дуудлагын хуудсанд тэмдэглэн холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авна.

#### **ЗУРГАА. ДУУДЛАГЫН ТӨРӨЛД ХАМААРАХ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ.**

#### **6.1 ЯАРАЛТАЙ ДУУДЛАГАД ХАМААРАХ ХАМ ШИНЖ**

- 6.1.1 Ухаангүй байдал
- 6.1.2 Осол гэмтэл / бүх төрлийн осол гэмтлүүд/
- 6.1.3 Зүрх судасны дутмагшил
- 6.1.4 Амьсгалын тогтолцооны дутмагшил
- 6.1.5 Бүх төрлийн оворго
- 6.1.6 Төрөлт болон жирэмслэлттэй холбоотой амь насанд аюул тулгарсан үед
- 6.1.7 Бүх төрлийн цус алдалт
- 6.1.8 Хүүхдийн яаралтай дуудлага /таталт, бачууралт, ухаангүй, маш өндөр халуурсан, халууралт таталт хавсарсан, бөөлжсөн, унтаарсан, уух буюу хөхөх чадваргүй, хөхөрсөн/
- 6.1.9 Цээж хэвлийн хүчтэй өвдөлтүүд
- 6.1.10 Бөөр шээсний замын хурц дутмагшил
- 6.1.11 Гадна орчны нөлөөллүүд /живэх, аянга, амиа хорлох оролдлого, хөлдөлт/
- 6.1.12 Бүх төрлийн хордлого
- 6.1.13 Их хэмжээний түлэгдэл
- 6.1.14 Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэг
- 6.1.15 Халдварт өвчнүүд

#### **6.2 ХҮЛЭЭГДЭЛТЭЙ ДУУДЛАГАД ХАМААРАХ ХАМ ШИНЖ**

- 6.2.1 Харшлын байдал
- 6.2.2 Хэвлий, нуруу, цээжээр өвдөх
- 6.2.3 Бөөрний архаг өвдөлт,
- 6.2.4 Бөөлжих,
- 6.2.5 Арьс салстаар тууралт гарах,
- 6.2.6 Халуурах (эм уугаад буурахгүй)
- 6.2.7 Шээс гэнэт хаагдах,
- 6.2.8 Ходоод гэдэсний хямрал
- 6.2.9 Насанд хүрэгч зан аашийн хэвийн бус үйлдэл гаргах
- 6.2.10 Хүүхдийн ааш зан гэнэт өөрчлөгдөх

#### **ДОЛОО. ОРОН НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ.**

##### **7.1 Аймгийн эрүүл мэндийн газар:**

- 7.1.1 Хүн амын өвчний эрсдэлт байдалд нарийвчилсан судалгаа хийж, хяналтыг сайжруулснаар түргэн тусламжийн дуудлагын тоог бууруулах, чанартай тусламж, үйлчилгээг хүргэх асуудалд үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 7.1.2 Хүн амын суурьшлын бүс, отор нүүдлийн зам, алслагдсан цэгүүдэд хүрэх зай, бүсчлэл, замыг тэмдэглэсэн, хүрч очиход хүндрэл гарч, зам хаагддаг хэсгүүдийг

тодорхой харуулсан газар нутгийн байршлын зураглалтай, зураглалын дагуу иргэдэд хүрч очих бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна.

- 7.1.3 Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, нэн шаардлагатай амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбоо мэдээллийн хэрэгсэл, стандартын шаардлага хангасан зориулалтын тоноглогдсон автомашинаар хангах бодлогын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана.
- 7.1.4 Эрсдэлт бүлгийн хүн ам, хүүхдийн осол, гэмтэл, өвчлөл, ялангуяа бага насны хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар малчин өрх, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг хүргэж ажиллана.
- 7.1.5 Явуулын хөдөлгөөнт хүн ам ихтэй, зам дагуух сум, сум тосгоны иргэдэд үзүүлэх түргэн тусламжийн чадавхыг сайжруулахад онцгой анхаарч, хүн амын тоо, бүтэц, байршилд үндэслэн тухайн орон нутгийн хэмжээнд түргэн тусламжийн дуудлагын төв, түргэн тусамжийн явуулын салбар, салбартай байх асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэж ажиллана.
- 7.1.6 Эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг иргэд, байгууллага, хувь хүний дуудлага, мэдээллээр харьяалал харгалзахгүй үзүүлэх бодлогын зохицуулалтыг хийж, хяналт тавьж ажиллана.

#### **7.2 Нэгдсэн эмнэлэг:**

- 7.2.1 Яаралтай тусламжийн тасаг нь түргэн тусламжийн дуудлага зохицуулагч, дуудлагын багтай байна.
- 7.2.2 Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжаар мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн тухайн чиглэлийн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн дуудлагын баг газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад үзүүлэх бэлэн байдлыг хангаж, зохицуулж ажиллана.
- 7.2.3 Яаралтай тусламжийн тасаг нь дуудлагын багт зөвлөн туслах үүрэг гүйцэтгэх зохион байгуулалтыг журамдаа нарийвчлан тусгаж, амь тэнссэн үеийн дуудлагад тосч үйлчлэх бэлэн байдлыг хангаж ажиллана.
- 7.2.4 Дуудлагын баг нь аймаг, орон нутгийн нутаг дэвсгэр дээрх ойрын болон алсын дуудлагын тусламж, үйлчилгээг чанартай, шуурхай гүйцэтгэнэ.
- 7.2.5 Дуудлагын баг нь мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, стандартад заасан шаардлага хангасан дуудлага хүлээн авах утас, түргэн тусламжийн автомашин, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, байршил тогтоогч, бусад холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
- 7.2.6 Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь баг, сумдаас ирсэн дуудлагын төрлөөс хамаарч төв эмнэлэг, төрөлжсөн, тусгай мэргэшлийн эмнэлгээс зөвлөх эмч дуудах, хүргэх асуудлаар шийдвэр гаргаж ажиллана.

#### **7.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв.**

- 7.3.1 Харьяалах болон түүний ойролцоо нутаг дэвсгэрт тохиолдсон гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үеийн түргэн тусламжийн үйлчилгээг иргэд, байгууллага, хувь хүний дуудлага, мэдээллээр харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлнэ.



- 7.3.2 Түргэн тусламжийн дуудлага, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч, анхан болон амилуулах суурь тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулах үүрэг хүлээнэ.
- 7.3.3 Түргэн тусламжийн ойрын болон алсын дуудлагын үйлчилгээг үзүүлэх байгууллагын журмыг энэхүү үлгэрчилсэн журам, стандарт болон холбогдох бусад хууль эрх зүйд нийцүүлэн баталж, хэрэгжүүлж ажиллана.
- 7.3.4 Багийн бага эмчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтын хувьд чиглүүлж, дэмжлэг үзүүлж ажиллана.

### **НАЙМ. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ.**

#### **8.1 Нийслэлийн эрүүл мэндийн газар:**

- 8.1.1 Хүн амын өвчний эрсдэлт байдалд нарийвчилсан судалгаа хийж, хяналтыг сайжруулснаар түргэн тусламжийн дуудлагын тоог бууруулах, чанартай тусламж, үйлчилгээг хүргэх, түргэн тусламжийн үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулах асуудалд үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 8.1.2 Түргэн тусламжийн үйлчилгээний байдалд дүгнэлт хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх, дуудлагын хүлээх хугацааг тасралтгүй бууруулах арга хэмжээний зохицуулалтыг хийж, төлөвлөж, хяналт тавьж ажиллана.
- 8.1.3 Түргэн тусламжийн машинаар хүргэгдэн ирж байгаа үйлчлүүлэгчийг дүүргийн болон төрөлжсөн, лавлагаа шатны байгууллагуудад тээвэрлэн хүргэх болон хүлээн авахтай холбогдох харилцааг зохицуулсан журмыг харилцагч байгууллагуудтай хамтран баталж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
- 8.1.4 Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, нэн шаардлагатай амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбоо мэдээллийн хэрэгсэл, стандартын шаардлага хангасан зориулалтын тоноглогдсон автомашинаар хангах бодлогын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана.
- 8.1.5 Нийслэлийн хн амд үзүүлэх түргэн тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулахад онцгой анхаарч, хүн амын тоо, бүтэц, байршилд үндэслэн нийслэлийн хэмжээнд түргэн тусламжийн салбар төв, дуудлагын төв ажиллуулах асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэж ажиллана.
- 8.1.6 Монгол улсын үндэсний стандарт "MNS 6717:2018" болон энэхүү нийтлэг журам, бусад хууль эрх зүйд нийцүүлэн "Нийслэлийн түргэн тусламжийн төв", дүүргийн нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

#### **8.2 Нийслэлийн түргэн тусламжийн төв:**

- 8.2.1 Нийслэлийн хүн амд түргэн тусламжийн үйлчилгээг чанартай, аюулгүй, шуурхай үзүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, хүртээмжийг нэмэгдүүлж, нөөцийг хангах, бүртгэл, хяналтыг хийж нэгдсэн тайлан, мэдээг гаргаж, үнэлгээ, дүгнэлт өгч ажиллана.
- 8.2.2 Түргэн тусламжийн үйлчилгээг байгууллага, хувь хүний дуудлага, мэдээллээр харьяалал харгалзахгүй үзүүлэх зохицуулалтыг хийж, мэдээ, тайлан гаргаж, хяналт тавьж ажиллана.
- 8.2.3 Нийслэлийн түргэн тусламжийн төвийн (цаашид төв гэх) дүрэм, дотоод зохион байгуулалтын журмыг энэхүү журам болон бусад холбогдох эрх зүйд нийцүүлэн батлуулж, хэрэгжүүлж ажиллана.
- 8.2.4 Энэхүү дүрэмдээ нийслэлийн хүн амд хүргэх түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах, хүлээгдлийг бууруулах, дуудлагын багийг зөв хуваарилах, түргэн тусламжийн бэлэн байдлыг хангуулах, үйлчлүүлэгчийг эмнэлэгт хүргэх, шилжүүлэх, хянах асуудлыг нарийвчлан тусгасан байна.
- 8.2.5 Түргэн тусламжийн автомашин, түүнд тавигдах шаардлага, зогсоол, граж, засвар үйлчилгээ, хаягжилтыг стандартын дагуу, нарийвчлан журамд тусгаж, зохион байгуулсан байна.
- 8.2.6 Мэдээлэл шуурхай удирдлагын төв иргэдийн мэдээллийг програмын дагуу хүлээн авч /EIN/-ээр дамжуулан шаардлагатай тохиолдолд эмч очтол авч байх арга хэмжээний талаар зөвлөгөө өгч болно.
- 8.2.7 Төвийн дуудлага зохицуулагч нь түргэн тусламжийн дуудлагыг төрлөөр нь ангилж, үйлчлүүлэгчийн байршилд ойролцоо байгаа дуудлагын багт дамжуулан байршил тогтоогчоор хяналт тавина.
- 8.2.8 Түргэн тусламжийн дуудлагын хуудсыг бүрэн гүйцэд, гаргацтай бөглөж, яаралтай тусламжийн тасаг, нэгжийн холбогдох хэсэгт үйлчлүүлэгчийг хүлээлгэн өгнө.
- 8.2.9 Түргэн тусламжаар хүргэгдэн ирж байгаа үйлчлүүлэгчийг дүүргийн болон төрөлжсөн, лавлагаа шатны байгууллагуудад тээвэрлэн хүргэх болон хүлээн авахтай холбогдох харилцааг зохицуулсан журмыг баримталж ажиллана.
- 8.2.10 Төв нь нийслэлийн түргэн тусламжийн үйлчилгээний байдалд дүн шинжилгээ хийх, чанарыг хянах, судалгаа хийж, дүгнэлт гаргаж, мэдээлэх, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэр гаргуулах үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.2.11 Төв нь үйлчлүүлэгчид газар дээр нь болон тээвэрлэлтийн явцад эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эмнэлзүйн удирдамж, зааврыг мөрдүүлэх, тогтмол шинэчлэх асуудалд оролцож ажиллана.
- 8.2.12 Төв нь эмнэлгийн мэргэжилтэн, мэргэшсэн жолооч, түргэн тусламжийн автомашин, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, байршил тогтоогч, холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

**8.2.13** Алслагдсан дүүргийн хүн амд нисдэг тэргээр түргэн тусламжийн үйлчилгээг хүргэх асуудлыг эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлүүлэн, хэрэгжүүлж ажиллаж болно.

**ЕС. ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ ЭМНЭЛГИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ**

**9.1** Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг нь (цаашид байгууллага гэх) түргэн тусламжийн чиг үүрэгтэй холбогдох асуудлыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үйл ажиллагаатай уялдуулан байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогт нийцүүлэн энэхүү журам болон холбогдох хууль эрх зүйд нийцүүлэн журамд тусган баталж, мөрдүүлнэ.

**9.2** Байгууллага нь түргэн тусламжаар ирж байгаа үйлчлүүлэгчийг цаг алдалгүй тосч үйлчлэх яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангасан байна.

**9.3** Яаралтай, түргэн тусламжийн дуудлага хүлээн авах утсан болон, цахим бүртгэл, хяналт, харилцааг зохицуулах, эрэмбэлэх дуудлага хүлээн авагчтай, дуудлага хүлээн авах тусгай дугаар бүхий холбооны хэрэгсэлтэй байна.

**9.4** Түргэн тусламжийн дуудлагын багаас болон хүргэгдэн, эсвэл биеэр ирж буй үйлчлүүлэгчийг тосч, авч эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээг харьяалал харгалзалгүй шуурхай үзүүлэх зохицуулалттай байна.

**9.5** Болзошгүй гамшгийн үед эрүүл мэндийн мэргэшсэн, яаралтай, амилуулах тусламж үзүүлэх багуудыг сургаж, бэлтгэн, шаардлагатай үед дуудагдан ажиллах нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллана.

**АРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА.**

**10.1** Улсын хэмжээнд эмнэлгийн яаралтай болон эрчимт, түргэн тусламж, алсын түргэн тусламж, телемедициний тусламж, үйлчилгээний байдалд дүн шинжилгээ хийж, бодлого хэрэгжүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, судалгаа хийж, дүгнэлт гаргах, мэдээлэх, шийдвэр гаргуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**10.2** Эмнэлгийн яаралтай болон эрчимт, түргэн тусламж, үйлчилгээний мэргэжилтний төгсөлтийн өмнөх ба дараах сургалтын бодлого, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

**10.3** Аймаг, нийслэлийн хэмжээний эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй түргэн тусламж, алсын дуудлага, яаралтай тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлага, арга зүй, тоо, чанар, шуурхай, байдал, хүртээмж, нөөцийн бодлого, бүртгэл, хяналт, нэгдсэн тайлан мэдээг гаргуулан авч, бодлогын дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцож ажиллана.

**10.4** Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, ялангуяа улирлын чанартай өвчлөл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар эцэг эхчүүд, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрүүл мэндийн

байгууллагуудтай хамтран тогтмол хийх хуваарь гарган, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

- 10.5** Алсын түргэн тусламжийн үйлчилгээг агаарын болон зориулалтын тоноглогдсон тээврийн хэрэгслээр үзүүлэхтэй холбогдох харилцааг хууль, эрх зүйд нийцүүлэн баталгаажуулж, мөрдүүлнэ.
- 10.6** Энэхүү журамд мэргэжлийн багийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудаас гаргуулах, аюулгүй байдлыг нь хангах, ажлын хөлс, нэмэлт урамшууллыг тооцох аргачлал, үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчтэй эргэх холбоо тогтоосон байдалд үнэлгээ өгөх асуудлыг тусгана.



Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
06... дүгээр сарын 21... ныедрийн 4-10 дугаар  
тушаалын хоёрдугаар хэсгээр

**ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ЭМ, БАГАЖ,  
ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ**

**1. Эм, эмнэлгийн хэрэгсэл**

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Тоо хэмжээ
1	Морфин гидрохлорид	10мг/мл-1мл	ам тарилгын уусмал	2
2	Диазепам	10мг-2мл	ам	2
3	Хлорпромазин	2.5%-2мл	ам	1
5	Сальбутамол		фл	1
6	Атропин сульфат	0.1%-1мл	ам	2
7	Прозерин/неостигмин	0,5 мг/мл	ам	1
8	Метамизол натри	50%-2мл	ам	4
9	Аминокапроныхүчил	40%-10мл	ам	1
10	Аминофиллин	2.4мг/ам-10мл	ам	2
11	Эпинефрин	0.1%-1мл	ам	9
12	Левоментол	0.06гр	шах	10
13	Этамзилат	250 мг/2 мл	ам	2
14	Декстран	40%-10мл	ам	2
15	Амприлан HD Рамиприл-Гипотиазид	125мг+2,5мг	шахмал	10
16	Дифенгидрамин /димедрол/	1%-1мл	ам	4
17	Никетамид	25%-1мл	ам	2
18	Кальцийн хлорид	10%-10мл	ам	2
19	Лозартан+гипотиазид	100/25	ш	10
20	Лидокаин	2%-2мл	ам	2
21	Магнийн сульфат	25%-10мл	ам	6
22	Натрийн хлорид	0.9%-2мл	ам	10
23	Натрийн хлорид	0.9%-500мл	фл	1
24	Глицерил тринитрат	5мг	шах	10
25	Дротаверин	2%-2мл	ам	2
26	Новокаин	0.25%-2мл	ам	4
27	Окситоцин	5МЕ/мл	ам	2
28	Преднизолон	30мг-1мл	ам	2
29	Фуросемид	1%-2мл	ам	2
30	Дексаметазон	4мг-1мл	ам	2
31	Аскорбины хүчил	5%-2мл	ам	6
32	Цефазолин	1гр	фл	2
33	Трамадол	100мг-2мл	ам	2
34	Атенолол	5мг	шах	10
35	Диклофенак натри	50мг-3мл	ам	2
36	Ацетилсалицилийн хүчил	500мг	шах	10
37	Лизиноприл	10мг	шах	10
38	Амлодипин	10мг	шах	10

39	Ацетаминофен 125	125 мг	лаа	5
40	Ацетаминофен 250	250 мг	лаа	5
41	Эналаприл	12,5 мг	ам	2
42	Цетиризин	10 мг	шах	10
43	Рингериин уусмал	400мл	фл	1
44	Гепарин	5000ед-1мл	фл	1
45	Декстран	10%		3
46	Хлорфенамин	4 мг	шах	10
47	Уулгаж сэлбэх олон найрлагат давсны бэлдмэл /Хоросол/	27.9 гр	ш	2
48	Өвдөлт намдаагч цацлага		фл	1
49	Синтомицины эмульс		фл	1
50	Тамедин /багстай/	5%-50мл	фл	1
51	Санитол	70%-30 мл	фл	1
52	Эмнэлгийн вазелин	20 гр	тюб	1
53	Идэвхижүүлсэн нүүрс		шах	1
54	Налоксон	0,4мг/1мл	ам	10
55	Лозартан	50 мг	шах	10
56	Валсартан	80 мг	шах	10
<b>Боолтын материал</b>				
1	Уян бинт	15*2м	ш	5
2	Бинт	7*14	ш	2
3	Наалт	2*3м	ш	1
4	Хөвөн		ш	1
5	Самбай, сальфетка		ш	10
<b>Нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл</b>				
1	Шээсний катетер	№14-16	ш	2
2	Үзлэгийн бээлий		хос	5
3	Хүйн хавчаар		ш	3
4	Мэс заслын утас	№1-3	ш	1
5	Тариур 3 гр		ш	3
6	Тариур 5 гр		ш	3
7	Тариур 10 гр		ш	3
8	Тариур 20 гр		ш	2
9	Тариур 1мл			1
10	Уян зүү 18G		ш	1
11	Амны хаалт		ш	2
12	Вакум тенер		КОМ	2
13	Дуслын систем		ш	1
14	Жирэмсний тест		ш	3
15	Урометр /10зүүлэлтэй/		ш	3
16	Салиа соруулагчын хошуу		ш	2
17	Хүчилтөрөгчийн маск /том хүн/		ш	1
18	Хүчилтөрөгчийн маск /хүүхэд/		ш	1
19	Хамрын гуурс /том хүн/		ш	1
20	Хамрын гуурс /хүүхэд/		ш	1
21	Нэг удаагийн хэл дарагч		ш	10
22	Маск № 95		ш	5
23	Эх барихын иж бүрдэл /нэг удаагийн/		КОМ	1

24	Хос замт амьсгалын гуурс	Ш	ком	1
25	Даавуу/ нярай, дунд, өсвөр /			
26	Ам арчигч			

## 2. Багаж, хэрэгсэл

№	Эмнэлгийн хэрэгсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг /энд зааснаас дээш тоотой /
1	Даралтын аппарат	ш	
2	Чагнуур	ш	1
3	Халууны шил	ш	1
4	Мэс заслын хайч	ш	1
5	Пинцет	ш	1
6	Мэс заслын хутга /нэг удаагийн/	ш	1
7	Хэл дарагч /хүүхэд, том хүн/	ш	1
8	Зүү баригч	ш	1
9	Кохерынхавчуур	ш	2
10	Хэл баригч	ш	1
11	Чангалуур	ш	1
12	Гар чийдэн	ш	1
13	Цахилгаан үүсгүүр	ш	4
<b>Эмнэлгийн тоног төхөөрөмж</b>			
1	Хүзүүний чиг	ш	1
2	Толгойн чиг	ш	1
3	Мөчдийн чиг	ш	1
4	Нурууны чиг	ш	1
5	Дамнуурга	ш	1
6	ЗЦБ-ын аппарат	ш	1
7	Пульсоксиметр	ш	1
8	Зөөврийн отсос	ш	1
9	Амьсгалын аппарат/зөөврийн/	ш	1
10	Дефибрилятор/зөөврийн/AED	ш	1
11	Хяналтын монитор	ш	1
12	Хүчилтөрөгчийн баллон 10	литр	1
13	АМБУ/нярай, хүүхэд, том хүн/	ш	1
14	Глюкометр	ш	1
15	Ларингоскоп	ш	1
16	Отоскоп	ш	1
17	Хүүхдийн амнаас салиа соруулах бургуй	ш	1
18	Аюулгүй хайрцаг	ш	1
19	Автомашини хог хаягдлын сав	ш	1
20	Ясанд хатгах зүү хүүхэд том хүнээр	ш	1
<b>Бусад</b>			
1	Дулаан алдуулахгүй бүтээлэг	ш	1
2	Нярайн өлгий	ком	1
3	Хөтөвч	ш	1
4	Ам арчих даавуу	ш	2
5	Дулаан хөнжил	ш	1
6	Аюулгүй хайрцаг	ш	1
7	Ларингоскопийнхошуу	ш	1
8	Ходоодны зонд олон хэмжээст	ш	1
9	Интубацийн гуурс, соруулах гуурс	ш	1
10	З янзын даавуу	ш	1

Тайлбар:

1. Дээрх бүх аппаратууд автомашины цахилгаан болон 220 вольтоор ажиллах боломжтой байна.
2. Түргэн тусламжийн автомашинд тавигдах шаардлага, түүнд байх тоног төхөөрөмжид MNS6717:2018-ыг баримтална.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны  
06 сарын 21-ны өдрийн А/29 дугаар  
тушаалын гуравдугаар хэсгралт

**БОЛЗОШГҮЙ ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДАЛ, ОЛНЫГ  
ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕИЙН ЭРЭМБЭЛЛИЙН ЗААВАР**

**НЭГ. ЗОРИЛГО.**

Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, олныг хамарсан осол гэмтлийн үед нэрвэгдэгсдэд газар дээр нь эмнэлгийн баг шуурхай арга хэмжээг нэн түрүүнд авахдаа амин үзүүлэлт, эмнэл зүйн шинж тэмдгийг үндэслэж эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх цаг хугацаа, цар хүрээний хувьд эрэмбэллийг тэргүүн эгнээнд хийснээр нас баралт хүндрэлээс сэргийлнэ.

**ХОЁР. ЗОРИЛТ.**

1. Эрэмбэлэл нь үйлчлүүлэгчийн өвчнийг оношлох бус биеийн байдлыг үнэлэхэд чиглэгдэнэ.
2. Эрэмбэлэл нь үйлчлүүлэгч олноор нэрвэгдсэн осол, гэмтэл, хордлого, бэртлийн үед цаг хугацаа болон нөөцийг хэмнэх зорилгоор хийгдэнэ.
3. Хурдан шуурхай эрэмбэлэх нь үйлчлүүлэгчийг эрт үеийн нас баралтаас сэргийлнэ.

**ГУРАВ. ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ.**

- 3.1 Цаг агаар, орчны эрсдэлт нөхцөл байдлыг үл харгалзан нэрвэгдэгсдийг эхлээд эрэмбэл,
- 3.2 Дараа нь яаралтай болон амилуулах тусламж үзүүл,
- 3.3 Тэгээд зөөвөрлөх буюу голомтоос гаргах,
- 3.4 Гэмтэж бэртсэн хүнийг эсрэг урсгалд бус, хөдөлгөөний чиглэл дагуу явуулах,
- 3.5 1 осолдогчийг 1 минутын дотор үнэлж, эрэмбэлэх,
- 3.6 Эрэмбэллийн хуудсанд зөвхөн зөвлөх (✓) байдлаар тэмдэглэлийг хийж, үйлчлүүлэгчийн биед бэхлэх буюу тухайн эрэмбэд холбогдох өнгийн картыг үйлчлүүлэгчийн биеийн нүдэнд ил үзэгдэх хэсэгт, эсвэл шархгүй бол баруун гарын шуунд зүүж тэмдэглэнэ.

**ДӨРӨВ. ЭРЭМБЭЛЭЛ.**

**4.1 Улаан карт буюу нэгдүгээр зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**

- Эгзэгтэй байгаа боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд сэргэх
- Их хэмжээний цус алдалт
- Пневмоторакс, хемоторакс
- Гавал тархины гэмтэл

**4.2 Шар карт буюу хоёрдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:**

- Шарх ихтэй боловч түр азнаснаар амь насанд нь эрсдэл учрахгүй



- Биеийн байдал ноцтой өөрчлөгдөхгүй
  - Дунд чөмөг, бугалгынхугарал гэх мэт

#### 4.3 Ногоон карт гуравдугаар зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд:

- Бага зэрэг шархтай, яаралтай бус
- Шархтай ч өөрөө явж байгаа
- Шалбархай, битүү бэртэл, үе булгарсан
- Шарх

#### 4.4 Хар карт буюу дөрөвдүгээр зэрэглэлд хамаарах шинж тэмдгүүд


- Эмчилгээ хийсэн ч амьд гарах найдвар муутай.
- Толгойдоо маш их гэмтэлтэй
- 3 дугаар зэрэглэлийн 95%-ийн түлэгдэлтэй,
- Нас барсан

#### 4.5 Улбар шар карт буюу тавдугаар зэрэглэлд хамаарах шинжүүд

- Олон хүнийг хамарсан халдварт өвчин
- Өвчлөгсдийг яаралтай тусгаарлан, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан эмчилгээг холбогдох байгууллагад мэдэгдэн шуурхай зохион байгуулах.

### ТАВ. ЭРЭМБЭЛЭХ ХУУДАС.

#### ЗУРАГ 1




#### 1 ДҮГЭЭР ЗЭРГИЙН НЭН ЯАРАЛТАЙ:

- Эгзэгтэй байгаа боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сэргэх

#### ШИНЖ ТЭМДЭГ:

- Их хэмжээний цус алдалт
- Пневмоторакс
- Гавал тархины гэмтэл
- Бусад цээжний гэмтлүүд




#### 2 ДУГААР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:

- Шарх ихтэй боловч түр азнаснаар амь насанд нь эрсдэл учрахгүй

#### ШИНЖ ТЭМДЭГ:

- Биеийн байдал ноцтой өөрчлөгдөхгүй
- Дунд чөмөг, бугалганы хугаралын үед





#### 3 ДУГААР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:

- Бага зэрэг шархтай, яаралтай бус

#### ШИНЖ ТЭМДЭГ:

- Шархтай ч өөрөө явж байгаа
- Шалбархай, битүү бэртэл, үе булгарсан
- Өнгөц шарх

ЗУРАГ 2.



Тийм	Үгүй	Анхдагч халдваргүйтэл
Тийм	Үгүй	Хоёрдогч халдваргүйтэл
Гэмтлийн төрөл:		
		Битүү гэмтэл
		Тулэгдал
		Хүзүүний нугалмын гэмтэл
		Зурхний гэмтэл
		Удаан дарагдалт
		Хугарал
		Шалбаралт
		Нэвтэрсэн гэмтэл

Амин үзүүлэлтүүд			
Цаг	Цусны даралт	Судасны лугшилт	Амьсгалын тоо
Цаг	Эмийн эмчилгээ		Тун

**4 ДҮГЭЭР ЗЭРГИЙН ЯАРАЛТАЙ:**  
 Найдваргүй өвчтөн  
 Эмчилгээ хийсэн ч амьд гарах найдвар муутай.  
 Толгойдоо маш их гэмтэлтэй  
 3 дугаар зэрэглэлийн 95%-ийн түлэгдэлтэй

**ОЛОН ХҮНИЙГ ХАМАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН:**  
 - Өвчлөгсдийг яаралтай тусгаарлан, халдвар хамгааллын дэглэмийг нарийн чанд баримтлан эмчилнэ.  
 - Зооноз, АЦХаХ

Тэмдэглэл:  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_